

Диахона

**Гэр бүлийг
бэхжүүлэх нь,
х.4, 16, 20, 22**

**Залуу насанд хүрэгчид
ариун явдлын талаар
үгээ хэлж байна, х.42**

**Бидэнд тусалсан дөрвөн
судар, х.54**

**Хүүхдийн Хэсгээс дэвшин
шилжих нь, х.58**



**Христ Америк тивд,
Жеффри Хейн**

*Христ Америк тивд
нифайчууд дээр ирэх үедээ
“тэдний бяцхан хүүхдүү-
дийг нэг нэгээр нь авч, мөн
тэднийг адислав, мөн тэд-
ний төлөө Эцэгт хандан
залбирав.*

*Мөн тэр үүнийг хийгээд
дахин уйлав;*

*Мөн тэр олон түмэнд
хандан ярьж, Бяцхан үрсээ
болгоогтун хэмээн хэлэв”
(3 Нифай 17:21-23).*



Лиахона, 2012 оны аравдугаар сар

ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас
бичиг: **Аз жаргалтай гэр
бүлийн нэг түлхүүр**
Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф

8 Айлчлагч багшийн захиас
бичиг: **Гэрээнүүддээ
хүндэтгэлтэй хандах нь**

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

22 Залуучуудад сүнслэг
туршлагатай болоход
туслах нь
Мелиса Меррилл
*Хөрвөлт рүү хөтөлдөг
туришлагуудад дөхөм
үзүүлэх таван арга зам*

28 Алмагийн ном:
Өнөө үеийн сургамжууд
Ахлагч Паул Б.Пайпер
*Нифайчуудаас авах гурван
сургамж өнөө үеийн сорил-
туудыг амжилттайгаар да-
вахад бидэнд тусалж байна.*

34 Дайсны газар нутагт
хэрхэн тэсч үлдэх вэ?
Ерөнхийлөгч Боид К.Пакер
*Ариун Сүнс хэрхэн удирдах
хийгээд хамгаалах нөлөөг
үзүүлдгийг олж нээ.*

ХЭСГҮҮД

9 Залуучуудын бат
бөх байдлын төлөө:
Хувцаслалт ба гадаад төрх

10 Аравдугаар сарын Чуул-
ганы тэмдэглэлийн дэвтэр:
**Чуулганы өдрүүдэд өөр
ажил бүү төлөвлө**
Черил Бөрр

11 Сүмд үйлчилсэн нь:
Ням гарагийн хичээлийн
хариултууд
Эмма Аддамс

12 Бид юунд итгэдэг вэ?:
Алсын хараатай амьдрал
биднийг ирээдүйд бэлтгэдэг

14 Өчүүхэн бөгөөд
энгийн зүйлс

16 Бидний гэр орон, гэр бүл:
Ариун явдал ба ариун
журмыг заах нь
Маттью О.Ричардсон

20 Сайн мэдээний сонгомол
бүтээл: Зөв шударга байд-
лыг гэр оронд заах нь
Ахлагч Делберт Л.Стейпли


38 Хожмын Үеийн Гэгээнтнүү-
дийн дуу хоолой

74 Сүмийн мэдээ

79 Гэр бүлийн үдшийн
санаанууд

80 Биднийг дахин уулзтал:
Сайн үйлс үргэлжилсээр
байх болно
Кейтлин А.Раш

ХАВТСАН ДЭЭР
Гэрэл зураг чимэглэлийг Коди Белл.



42 Бэлгийн харилцааны ёс суртахуунгүй дэлхийд хэрхэн ариун явдалтай байх вэ? Ариун явдлыг үнэ цэнэгүй болгосон дэлхийд хэрхэн ариун явдалтай байх тухай найман залуу насанд хүрэгч ярьж байна.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санамж: Ноа Лиахонаг ашигласан уу?

46 Асуулт, хариулт
Бурханы санваарт хүндэтгэлтэй хандах гэж юу гэсэн үг вэ?

48 Ухаалаг анд найз бай
Ахлагч Роберт Д.Хейлс
Сайн найз нар зарлигуудаар амьдрахыг хөнгөвчилж өгдөг.

51 Бүжигт орохдоо хэрхэн хувцаслах вэ?
Кристал Мартин
Нэг удаа би мөрөө ил гаргасан хувцас өмсөхөөр уруу татагдсан ч, тэр үед патриархын адислалаа санаж билээ.

52 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Хувцаслалт ба гадаад төрх "Ариун Сүнс удирдаг"
Мэри Н.Кук

54 Үгээр хүчирхэгжсэн нь
Судар санаанд нь орж, тэдэнд тусалсан тухай өсвөр насны дөрвөн залуу өгүүлж байна.

57 Үзүүлэн: Шулуун бөгөөд нарийн зам

51



58 Хүүхдийн Хэсгээс шилжин дэвших нь
Залуу Эрэгтэйчүүд эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн ангид та нарыг хүлээж буй зарим туршилагын тухай дор өгүүлэв.

60 Эрхэм хүндэт Амига
Марибел
Хүүхдийн Хэсгийг орхих болсондоо сэтгэл хоргодонгуй байгаа найздаа бичсэн захидал.

61 Амьдралынхаа нэгэн шинэ үеийг баяртай угтаарай
Марисса Виддисон
Ноа, Дайлан, Патрик, Бен нар санваар авахад бэлтгэж байна.

62 Дуу хөгжим:
Их Эзэн Есүс Та ирээч

63 Онцгой гэрч: Би хаана амьдарч байгаагаасаа үл хамааран итгэлтэйгээр Есүс Христийг дагах нь яагаад чухал бэ?
Ахлагч Даллин Х.Өүкс

64 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Санваарын адислалууд бүх хүмүүст боломжтой

66 Хоёр дахин их адислал
Ричард М.Ромни
Мадагаскарын 10 настай ихрүүд Софи, Флоди хоёртой танилцана уу.

68 Би бас баптисм хүртэж болохгүй гэж үү?
Хилари Уоткинс Лемон
Зургаан настай Пауло Сүмийн гишүүн болохоор сэтгэл догдлон хүлээж байна.

70 Бага насны хүүхдүүдэд зориулав

81 Мормоны Номон дахь судрын баатрууд

**2012 ОНЫ АРАВДУГААР САРЫН ДУГААР 13 NO. 5
ЛИАХОНА 10490 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристоферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Крейг А.Кардон

Зөвлөхүүд: Шэйн М.Боуэн, Брэдли Д.Фостер,
Бага Кристоффел Гоулдэн, Энтони Д.Пэркинс

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжын захирал:

Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Ларене Портер Гаунт

Хэвлэлийн туслах: Мэлисса Зентено

Редакцийн баг: Сюзан Баррет, Раян Карр,
Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон,
Минди Эви Фридман, Хикари Лофтус, Лиа МкКланихан,
Майкл Р.Моррис, Ричард М.Ромни, Паул ВанденБерг,
Жулиа Вүүдбери

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсен

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанетт Эндрюс,
Фэй П.Андрус, С.Кимбол Ботт, Томас Чайлд, Керри
Линн С.Херрин, Коллийн Хинкли, Эрик П.Жонсен,
Скотт М.Моои, Брэд Тиаре

Оюуны өмчийн зохицуулагч: Жэин Анн Петрс

Хэвлэлийн захирал: Жэин Анн Петерс

Хэвлэх баг: Конни Бөүторп Бриж, Ховард Г.Браун,
Жүүли Бурдетт, Браян У.Гиги, Катлийн Ховард,
Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон, Таи Пилчер,
Гэйл Тэйт Рафферти

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен,
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо
барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернет веб сайт
liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол
"луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам,
болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез,
ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва,
малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос,
польш, португали, румын, самоа, себуано, солонгос,
тагалог, тай, тахити, тонга, украин, унгар, урду, фижи,
фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан),
чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд
нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)



© 2012 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиран
олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх
асуултаа Intellectual Property Office, 50 E. North Temple
St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон
шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org
хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
October 2012 Vol. 13 No. 5. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price
is \$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes.
Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days'
notice required for change of address. Include address label
from a recent issue; old and new address must be included.
Send USA and Canadian subscriptions to Salt Lake
Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Post
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаас үзэж болно Liahona.lds.org



НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

Тэргүүн Зөвлөлийн Захиас (4-р хуудас)
дахь уучлалын тухай уншсаны дараа та
Ерөнхийлөгч Жеймс И.Фаустын, ерөн-
хий чуулган дээр (2007 оны 4-р сарын)
хэлсэн сүүлчийн үг, "Уучлалын эдгээгч
хүч" -ийг conference.lds.org -оос бас
уншиж болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

52-р хуудсанд Мэри Н.Кук ариун сүмүү-
дэд хүндэтгэлтэй хандах нь биднийг зөв
хувцаслахад хэрхэн хөтөлдгийг тайлбар-
лажээ. Та youth.lds.org, -оос "Хувцас-
лалт ба гадаад төрх" болон *Залуучуудын
бат бөх байдлын төлөө* товхимол дахь
бусад аль ч жишгээр илүү их мэдээллийг
үзэж болно.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Та 66-р хуудсан дахь "Хоёр дахин
их адислал" өгүүллээс Мадагаскарын
ихрүүд Флоди, Софи хоёрын тухай ун-
шиж, liahona.lds.org -оос тэдний тухай
хөгжилтэй зургуудыг олж үзэж болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад материа-
луудыг олон хэлээр www.languages.lds.org -аас үзэж болно.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

- Ажил хөдөлмөр, 12**
- Ариун сүм, 8, 52**
- Ариун явдал, 16, 42**
- Баптисм, 68**
- Бие даах чадвар, 13**
- Бошиглогчид
(эш үзүүлэгчид), 28**
- Бэлтгэл, 13**
- Бэрхшээл, 28**
- Гэр бүл, 4, 16, 20, 22,
38, 66**
- Гэрээүүд, 8**
- Даашинз, 9, 51, 52**

- Дуулгавартай байдал,
40, 57**
- Ерөнхий чуулган, 10**
- Есүс Христ, 62, 63**
- Заах, сургах, 16, 20**
- Залбирал, 38**
- Залуу Эмэгтэйчүүд, 58,
60**
- Залуу Эрэгтэйчүүд, 58,
61**
- Эцэг эх болох нь, 16,
20, 22**
- Итгэл, 39, 80**

- Мормоны Ном, 28, 81**
- Мэргэн ухаан, 48**
- Найз нөхөд, 48**
- Нинжин сэтгэл, 28**
- Санваар, 46, 64**
- Судар судлах, 11, 54**
- Сүмийн түүх, 14**
- Удирдлага, 20**
- Уучлал, 4**
- Хүндэтгэлийн өдөр, 40**
- Хөрвөлт, 39**
- Үйлчлэл, 20, 39**
- Үлгэр дуурайл, 40**





**Ерөнхийлөгч
Диетер Ф.Угдорф**

Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар зөвлөх

Аз жаргалтай гэр бүлийн НЭГ ТҮЛХҮҮР

Оросын их зохиолч Лев Толстой *Анна Каренина* романаа “Аз жаргалтай гэр бүлүүд бүгд адил байдаг. Харин аз жаргалгүй гэр бүл болгон өөр өөр байдлаар аз жаргалгүй байдаг” гэсэн үгсээр эхэлжээ.¹ Аз жаргалтай гэр бүлүүд бүгд адилхан байдаг гэсэн Толстойн санаа миний хувьд тодорхой биш ч гэсэн аз жаргалтай гэр бүлүүдэд байдаг хамгийн нийтлэг зүйл бол бусдын алдаа дутагдлыг уучлан, мартаж, сайн сайхан бүхнийг эрэлхийлдэг явдал гэдгийг би мэдсэн билээ.

Үүний эсрэгээр аз жаргалгүй гэр бүлийн гишүүд бусдаас үргэлж дутагдал олж, өш хонзон санаж, өнгөрсөн үеийн гомдлоо мартаж чаддаггүй.

Аз жаргалгүй хүмүүс “Тийм ээ, гэвч. . .” гэсэн үгсээр гомдлоо эхэлдэг. “Тийм ээ, гэвч тэр эмэгтэй наймайг хэчнээн их гомдоосныг та мэдэхгүй шүү дээ” гэж нэг нь хэлэхэд “Тийм ээ, гэвч тэр эрэгтэйг хэчнээн аймаар хүн болохыг та мэдэхгүй ш дээ” гэж нөгөө нь хэлдэг.

Хоёулаа зөв байж болно. Эсвэл хоёул буруу байж болно.

Хэн нэгэнд гомдсон гомдлын болон учруулсан сэтгэл санааны хохирлын хэмжээ өөр өөр байдаг. Гэвч бид бусдын үйлдлийг уучилж болшгүй, амин хувиа хичээсэн гэж буруутгахдаа уур хилэнгээ зөвтгөн, өөрсдийгөө тайтгаруулахын сацуу өөрсдийн амин хувиа хичээсэн үзэл бодол, учир үндэслэлийг гэм буруутгүй, зөв гэж үздэг нь ажиглагдсан юм.

Хунтайжийн нохой

13-р зууны үеийн Уэльсийн хунтайжийн тухай нэгэн түүх байдаг. Түүнийг гэртээ эргэж ирэхэд нохойных нь нүүр цус болсон хэвтэж байж гэнэ. Тэгээд хун тайж дотогшоо яаран ортол, аймшигтай зүйл харагдаж. Нялх хүү нь алга. Өлгийг нь хөмөрч унагасан байв гэнэ. Тэр уурласандаа илдээ суга татан, нохойгоо цавчаад алчихаж. Хунтайж тэр дорхноо хүүхэд уйлахыг сонсож. Ашгүй хүү нь амьд байжээ! Хүүгийнх нь хажууд нэг чоно үхсэн байв. Хөөрхий тэр нохой хунтайжийн хүүг аюулт араатнаас хамгаалан аварсан байж.

Энэ түүх эмгэнэлтэй ч гэсэн нэг зүйлийг бидэнд өгүүлж байна. Энэ нь бусад хүмүүсийн хийдэг үйлдэл яагаад бодит байдалтай нийцдэггүй тухай бид заримдаа буруу ойлголттой байж болохыг мөн бид өөрсдөө ч бодит байдлыг мэдэхийг хүсдэггүйг харуулж байна. Бид гомдол, дургүйцлээ барьж чадахгүй, уурлаж бухимдсандаа өөрийгөө зөвтгөх шалтаг эрдэг. Заримдаа ийм аттаг санаа хэдэн сар, жил, тэр ч бүү хэл насан турш үргэлжилж болно.

Гэр бүлд хагарал гарсан нь

Нэг эцэг өөрийнх нь заасан замаас гажсаных нь төлөө хүүтээ уучилж чадахгүй байжээ. Тэр хөвгүүний найз нар аавд нь таалагддаггүй бас хүү нь аавынхаа хийж болохгүй гэж боддог олон зүйлийг хийдэг байж. Энэ нь эцэг хүү хоёрын хооронд ангал бий болгож, удалгүй хүү нь гэрээ орхин явж, эргэж ирээгүй гэдэг.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Хичээл бүрт бэлтгэхдээ тухайн зарчим нь гэр бүлийн гишүүд амьдралдаа туулж өнгөрүүлсэн ямар нэг зүйлтэй хэр зэрэг адилхан байгааг өөрөөсөө асуу (*Teaching, No Greater Call* [1999], 171). Уучлалын талаар тэдэнд тохиолдсон буюу бусдаас харсан сайн туршлагаа хуваалцахад ангийн гишүүдийг урь. Уучлалаас ирдэг адислалуудад анхаарал төвлөрүүлэн эдгээр туршлагаудын тухай ярилц. Бие биеэ уучлах нь хэчнээн чухал болох тухай гэрчлэлээ хуваалцаж, хичээлээ төгсгө.

Тэд дахиад ганц хоёрхон удаа ярилцжээ.

Аав нь өөрийнхөө зөв гэж бодсон болов уу? Тийм ч байж магадгүй.

Хүү нь өөрийнхөө зөв гэж бодсон болов уу? Тийм ч байж магадгүй.

Миний олж мэдсэнээр эцэг хүү хоёр бие биеэ уучилж чадаагүйн улмаас гэр бүлд нь хагарал гарч, аз жаргалгүй болсон явдал юм. Эцэг хүү хоёр бие биенийхээ талаарх өнгөрсөн үеийн гашуун дурсамжийг мартаж чадаагүй аж. Тэд зүрх сэтгэлээ хайр, уучлалын оронд уур хилэнгээр дүүргэжээ. Эцэг хүү хоёр бие биенийхээ амьдралд сайн нөлөө үзүүлэх боломжоо өөрсдөө дээрэмдсэн ажээ. Тэдний хоорондох ангалам бүр гүнзгийрч, өргөжин, тэд өөрсдийн сэтгэл хөөрлөөр бий болгосон арал дээрх сүнсний шоронгийн хоригдлууд лугаа адил болсон.

Аз болоход, хайраар дүүрэн, мэргэн ухаант Тэнгэр дэх бидний Мөнхийн Эцэг бардамналыг даван туулах арга хэрэглээр хангасан юм. Агуу хийгээд хязгааргүй Цагаатгал бол уучлал ба эвлэрлийн оргил үйлдэл мөн. Цагаатгалын цар хүрээ бол миний ойлголтоос хэтэрсэн зүйл. Гэвч үүний үнэн бодит байдал хийгээд хэмжээлшгүй их хүчийг би бүх зүрх сэтгэлээрээ гэрчилж байна. Аврагч бидний нүглийн төлөөсийг Өөрийн амиар төлсөн билээ. Бид Түүгээр дамжуулан уучлагддаг.

Төгс гэр бүл гэж байхгүй

Бидний хэн нь ч нүгэлгүй цэвэр ариун биш. Бид бүгд түүний дотор та нар ч, би ч адилхан алдаа гаргадаг. Хэн нэгэн биднийг гомдоодог бол бид ч бусдыг гомдоодог.

Аврагчийн золиослолоор дамжуулан бид өргөмжлөл, мөнх амьдралд хүрч чадна. Бид Түүний замыг хүлээн авч, зүрх сэтгэлээ зөөлрүүлснээр бардамналаа даван туулах юм бол гэр бүлдээ болон хувийн амьдралдаа эвлэрэл, уучлалыг авчирч чадна. Бурхан бидэнд илүү уучламтгай байхад, хэн нэгэнтэй дахиад хоёр бээр явахад, бидний алдаа дутагдал биш ч гэсэн эхлээд уучлалт гуйхад, хүнд муу юм санахаа больж, улмаар үүнийг бүрмөсөн орхиход туслах болно. Төрсөн

Ганц Хүүгээ бидний төлөө өгсөн Бурханд, амиа бидний төлөө өгсөн Хүүд талархал өргөө.

Биднийг хайрладаг Бурханы хайрыг бид өдөр бүр мэдэрч чадна. Бидний дуртай “Because I Have Been Given Much” (“Надад ихийг өгсөн учраас”) дуулалд заадаг шиг бид нөхдөдөө илүү ихийг зориулж болохгүй гэж үү?² Их Эзэн бидэнд уучлагдах үүд хаалгыг нээж өгсөн юм. Аминч үзэл хийгээд бардам зангаа орхин, бодол санаа зөрдөг хүмүүс, ялангуяа гэр бүлийн гишүүдээ уучилдаг байх нь биднийг адислал руу хөтөлдөг цорын ганц зөв зам биш гэж үү?

Эцэст нь, аз жаргал төгөлдөржилтөөс бус харин бурханлаг зарчмуудыг бүр жижигхэн алхмуудаар хэрэгжүүлснээр ирдэг. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга ийн тунхаглажээ: “Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, *өришөөл*, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна.”³

Бидний Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөн дээр суурилсан эдгээр энгийн үнэнүүдийн гол цөм нь уучлал юм. Уучлалын улмаас зарчмууд хоорондоо холбогдог, энэ нь хүмүүсийг хооронд нь холбодог. Энэ бол түлхүүр нь. Түлхүүр цоожтой хаалгыг нээдэг. Энэ бол зөв бөгөөд шударга замын эхлэл. Энэ бол аз жаргалтай гэр бүлд тавьдаг бидний хамгийн чухал найдваруудын нэг юм.

Гэр бүлийнхээ дотор илүү уучламтгай байхад, бие биеэ илүү уучилдаг байхад бас өөрийгөө уучилж чаддаг байхад Бурхан бидэнд туслах болтугай. Хамгийн аз жаргалтай гэр бүлүүдэд байдаг нэгэн гайхамшиг болох уучлал бидэнд байх болтугай хэмээн би залбирч байна. ■

Эшлэл

1. Лев Толстой, *Анна Каренина*, орчуулга. Констанс Гарнеттын (2008), 2.
2. “Because I Have Been Given Much,” *Hymns*, no. 219.
3. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.

Залбирал ба амар амгалан

Лорен В.

Нэг орой би ээжтэйгээ ам муруйснаас болж сэтгэл санаа хямрав. Тэгээд залбирахаар шийдлээ. Сэтгэл санаа тааруухан байсан болохоор би “сүнслэг байхыг” хүсээгүй ч залбирал надад аз жаргалтай байхад туслахын хамт маргааныг намжаахад хэрэгтэй байв. Ээжийг өрөөнөөс гарч явсны дараа би залбирлаа. “Хайрт Тэнгэрлэг Эцэг минь ээ, өнөө орой би Танд хандаж байгаа учир нь гэвэл. . .” Үгүй ээ, би нүдээ нээж, гараа дэлгэлээ. Нэг л таатай санагдахгүй байлаа. Дахиад залбирч үзэв. “Тэнгэрлэг Эцэг минь, надад . . . хэрэгтэй байна.” Энэ ч бас хачин сонсогдов. Сатан намайг Тэнгэрлэг Эцэгээс тусламж гуйж залбирахыг болиулах гэж чармайж байгааг би мэдэрлээ.

Гэнэт би баярлалаа гэж хэлэх сүнслэг өдөөлтийг хүлээн авав! Тэгээд баярлалаа гэж хэлтэл Тэнгэрлэг Эцэгтээ баярласан талархснаа илэрхийлэх ёстой олон зүйл оюун ухаанаас минь ундарч эхэллээ. Түүнд талархлаа илэрхийлсний дараа асуудлаа ярилцлаа.

Үүний дараа би гайхамшигтай амар амгаланг дотоод сэтгэлдээ мэдрэхэд Тэнгэрлэг Эцэг бас эцэг эх минь надад хэчнээн их хайртайг болон өөрийгөө Бурханы хүүхэд гэдгийг сүнслийн дулаан мэдрэмжээр мэдсэн. Тэгээд би ээжээсээ уучлалт гуйж бас ээжийнхээ уучлалыг хүлээн авсан юм.

Уучлал аз жаргалыг авчирдаг

Бид гэр бүлийн гишүүдээ уучилдаг байх ёстой гэж Ерөнхийлөгч Угдорф сургасан. Жозеф, Анна хоёрын сонголт гэр бүлд нь хэрхэн нөлөөлснийг үзэцгээе.



Жозеф бяцхан эмэгтэй дүү Аннатайгаа тоглож байлаа. Анна Жозефын тоглоомыг булааж авлаа. Жозеф юу хийх хэрэгтэй вэ?

Жозеф Аннад уурлахад, Анна уйлав. Жозефын ээж түүнийг дүүтэйгээ муудлаа гэж зэмлэв. Жозеф буруу юм хийсэндээ харамслаа.

Жозеф Аннаг уучилж, өөр тоглоом олов. Тэд хамт тоглохдоо баяртай байлаа. Жозеф дүүдээ эелдэг хандаж, гэр бүлдээ амар амгаланг бий болгосонд ээж нь баяртай байсан. Жозеф дүүгээ уучилсандаа ч баяртай байлаа.



Жозеф Анна хоёр тоглож дууссанаа дараа ээждээ хоол хийхэд нь туслах хэрэгтэй байв. Жозеф тусалсангүй. Анна яах ёстой байсан бэ?

Анна ээждээ гомдол мэдүүлэв. Анна ганцаараа ажил хийх боллоо гэж дургүйцжээ. Маргаснаас болж, хоолны өмнөхөн бүгд сэтгэл дундуур байлаа.

Анна Жозефыг уучилж, хоол хийхэд ээждээ туслав. Аннаг тусалсанд ээж нь баяртай байв. Хоолон дээр гэр бүлээрээ хамт байгаадаа бүгд баяртай байсан. Анна ахыгаа уучилсандаа баяртай байлаа.

Бусдыг уучлах нь гэр бүлийн чинь аз жаргалд хэрхэн нөлөөлдөг вэ?

Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилиц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.



Гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандах нь

Айлчлагч багшлалт бол бидний шавь байх илрэл бөгөөд гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандаж, бие биедээ үйлчилж, бие биенээ хүчирхэгжүүлэх нэг арга зам мөн. Гэрээ бол Бурхан ба Түүний хүүхдүүдийн хоорондын ариун хийгээд урт удаан үргэлжлэх амлалт юм. “Бид гэрээний хүүхдүүд гэдгээ ойлгосон үед өөрсдийгөө хэн гэдгийг бас Бурхан биднээс юу хүсэн хүлээдгийг мэдэх болно. Түүний хууль бидний зүрхэнд бичигдсэн юм. Тэр бол бидний Бурхан, бид Түүний хүмүүс” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон хэлжээ.¹

Айлчлагч багш нар бид айлчилдаг эгч нарынхаа ариун гэрээнүүдийг сахих хүч чармайлтыг улам хүчтэй болгож чадна. Ингэснээр бид мөнх амьдралын адислалуудад бэлтгэхэд нь тэдэнд туслах болно. “Их Эзэнтэй гэрээ хийсэн энэ Сүмийн эгч бүр хүмүүсийг аврахад тусалж, дэлхийн эмэгтэйчүүдийг манлайлан, Сионы гэр бүлүүдийг бэхжүүлж, Бурханы хаант улсыг байгуулахад туслах тэнгэрлэг үүрэг хариуцлагатай юм”² хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард хэлжээ.

Бид ариун гэрээнүүдийг хийж, сахиснаар Бурханы мутарт зэмсэг болдог. Ингэснээр бид итгэлээ тод харуулан Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх бие биенийхээ итгэлийг бэхжүүлэх боломжтой байх болно.



Судруудаас

1 Нифай 14:14; Мозая 5:5–7; 18:8–13; Сургаал ба Гэрээ 42:78; 84:106

Эшлэл

1. Рассел М.Нелсон, “Covenants,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 88.
2. М.Рассел Баллард, “Women of Righteousness,” *Лиахона*, 2002 оны 12-р сар, 39.
3. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 133.

Би юу хийж чадах вэ?

1. Миний гэрээнүүд намайг хэрхэн хүчирхэгжүүлдэг вэ?
2. Харж ханддаг эгч нартаа гэрээнүүдээ сахихад нь би хэрхэн тусалж байна вэ?

Итгэл, Гэр бүл,
Халамж

Бидний түүхээс

Ариун сүм бол “бүх гэгээнтнүүдийн хувьд талархлын газар” мөн гэдгийг Их Эзэн 1833 онд Бошиглогч Иосеф Смитэд илчилсэн билээ. Энэ бол “хэд хэдэн дуудлагууд хийгээд албан тушаалуудад тохинууллын ажилд дуудагддаг тэд бүгдийн зааврын газар байхын тулд юм; тэд өөрсдийн тохинуулал, онол, зарчим мөн сургаалд мөн түлхүүрүүд нь та нарт олгогдсон дэлхий дээрх Бурханы хаант улсад хамаарах бүх зүйлийн ойлголтод төгөлдөржихийн тулд юм” (С ба Г 97:13–14).

Иллинойн Науву дахь Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар 1840-өөд оны эхээр ариун сүмийн ёслолуудад бэлтгэхэд бие биедээ тусалсан ажээ. Наувугийн Ариун сүмд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хүлээн авсан санваарын дээд ёслолуудад “бурханлаг чанарын хүч илэрхийлэгд[сэн]” (С ба Г 84:20). “Гэгээнтнүүд гэрээнүүдээ сахисан үед энэ хүч улам бэхжиж, тэр үед тулгарсан болон хожим нь тохиолдсон хүнд сорилт бэрхшээлүүдэд тэдэнд түшиг тулгуур болж байлаа.”³

Өнөөдөр Сүмийн хэмжээнд дэлхий даяарх итгэлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ариун сүмд үйлчилж, зөвхөн ариун сүмийн гэрээнүүдээр дамжин ирдэг адислалуудыг хүлээн авах хүч чадлаа өсгөн нэмэгдүүлсээр байна.

ХУВЦАСЛАЛТ БА ГАДААД ТӨРХ

Бидний бие махбодын ариун нандин чанарыг ойлгохгүй, эсвэл хүндэтгэлгүй ханддаг өнөөгийн дэлхийд Хожмын Үеийн Гэгээнтнүүд бие махбодынхоо үнэ цэнийг мэддэгээ хувцаслалтаараа харуулдаг учир дэлхийгээс ялгаатай харагддаг (*Залуучуудын бат бөх байдлын төлөө* [товхимол, 2011], 6–8-ыг үзнэ үү). Энэ дугаарын 52-р хуудсан дээр Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Мэри Н.Кук энэхүү стандартын талаар хэлсэн:

“Ариун сүмийг гадна болон дотор талаасаа үзэсгэлэнтэй сайхан харагдахаар, сайн хамгаалалттай байхаар бодож төлөвлөн барьдаг. Ариун сүмийн барилгыг төлөвлөхөд анхаарах зүйл бол энэ нь Их Эзэний өргөөг *төлөөлдөг* бөгөөд энэ түүний гэр гэдгийг ойлгох явдал юм. Бид ариун сүмийг зөвхөн зохистой хүмүүс ордог ариун барилга байгууламж гэж үзэн *хүндэтгэлтэй ханддаг* Бидний оролцдог ариун нандин ёслолууд болон гэрээнүүд нь Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих боломжийг олгодог учраас бид ариун сүмүүдэд *хүндэтгэлтэй* ханддаг.

Чиний бие махбод дэлхий дээрх хамгийн үзэсгэлэнтэй ариун сүмээс ч илүү үнэ цэнэтэй юм. Чи бол Бурханы хайртай хүү буюу охин нь. Их Эзэнийг төлөөлөх болон хүндэтгэлийн эдгээр зарчмууд нь бие махбоддоо анхаарал тавьж, хамгаалахад бүр ч илүү чухал юм.”

Дараах зөвлөмжүүд нь хувцаслалт болон гадаад төрхийн тухай зөв зарчмуудыг хүүхдэдээ заахад тань тусална. Түүнчлэн даруухан хувцасладаг таны үлгэр дуурайл зөв хувцаслах нь хэчнээн чухал болохыг хүүхдүүдэд тань заах болно.

Залуучуудад заах зөвлөмж

- *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь хувцаслалт ба гадаад төрхийн талаарх хэсгийг хүүхэдтэйгээ хамт унш. Ингэх нь жишгүүдийн талаар өгөгдсөн сургаал, адислал болон анхааруулгын тухай ярилцаж, хүү буюу охиныхоо асууж болох асуултуудад хариулах боломжийг танд олгох болно.
- Хувцаслалт болон гадаад төрхийн ач холбогдлын талаар гэр бүлийн үдэш зохион байгуулахад анхаар. Хэрэв Их Эзэн бидэнтэй хамт сүм дээр байгаа бол чи хэрхэн хувцаслахыг хүсэх вэ? Чи Түүнд хэрхэн харагдахыг хүсэх вэ? Даруухан хувцасласан үед өөрт чинь ямар санагддаг вэ? гэхчлэн гэр бүлийн гишүүдээсээ асууж болно. Та бас сургууль, ажил дээрээ эсвэл олон нийтийн газар хэрхэн зөв хувцаслах тухай гэрийнхэнтэйгээ ярилцаж болно.

Хүүхдэд заах зөвлөмж

- Бидний хувцаслалт бидэнд юу чухал болохыг харуулдаг. Энэ зарчмыг дүрслэн үзүүлэхийн тулд хүн бүр номлогч шиг эсвэл ням гарагт өмсдөг хамгийн сайхан хувцсаа өмсөж оролцох гэр бүлийн үдшийг зохион байгуул.
- Хүүхдүүд бага наснаасаа эхлэн даруухан хувцаслаж сурах хэрэгтэй. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлын 7-р хуудсан дээрх удирдамжийг хүүхдүүдтэйгээ хамт нэгтгэн дүгнэж, уг удирдамжинд өгүүлсэн хувцсыг хүүхдэдээ өг. ■



ХУВЦАСЛАЛТ БА ГАДААД ТӨРХИЙН ТАЛААРХ СУДРУУД

Эхлэл 1:27;

1 Коринт 6:19;

Алма 1:27

10-р сарын Чуулганы ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).

Чуулганы өдрүүдэд өөр ажил бүү төлөвлө

Черил Бөрт

Цаг заваа өөр үйл ажиллагаануудад зориулахгүй бол бид ерөнхий чуулганы үгсийг сонсох үедээ Сүнсийг илүү ихээр мэдэрч чадна.

Олон жилийн өмнө манай зургаан хүүхдийг бага байхад бид ерөнхий чуулганыг амьдралдаа илүү чухал ач холбогдолтой болгохоор шийдсэн билээ. Чуулганыг сэргэг оюун ухаантай, бие махбод маань амарсан үед үзэх нь хэчнээн чухал болох тухай бид ярилцсан. Чуулган бол өнөө үеийн бошиглогчдоос заавар хүлээн авах чухал цаг мөн. Тиймээс бид чуулганаас хэд хоногийн өмнө болон чуулганы үеэр ямар нэг өөр ажил төлөвлөхгүй байх зорилго тавьж ажилласан юм. Бид чуулганы өдрүүдийг хуанли дээрээ тэмдэглэж, хэн ч тэр өдрүүдэд өөр ажил төлөвлөхгүй байхаар шийдэж билээ.

Хэрэв та ч бас чуулганд ийм байдлаар хандвал гэр бүлд тань болон нөхцөл байдалд чинь тохиромжтой байж болно. Харин манай гэр бүл чуулганы хуралдаануудын хооронд болон хуралдааны үеэр сургуулийн үйл ажиллагаануудад оролцох, хөрш айлынхаа хүүхдүүдийг гэртээ авчрах, гэрээсээ хол газар найзуудтайгаа уулзаж ярилцах, найз нөхөд садан төрлүүдтэйгээ хоол идэх, сургуулийн төслүүдийг хийх, ажил дээрээ нэмэлт үүрэг даалгавар авах зэрэг “нэмэлт үйл ажиллагаануудыг” харгалзан үзсэн билээ.

Ерөнхий чуулганы өмнөх долоо хоногт дээрх үйл ажиллагаануудад оролцохгүй гэж хэлэх нь заримдаа хэцүү байсан ч манай гэр бүлийн гишүүд тавьсан зорилгодоо хүрэх зөв сонголтуудыг хийсэн билээ. Бага хүүхдүүд маань ерөнхий чуулганд идэвхтэй оролцохыг хүсч байгааг бид мэдсэн юм. Энэ нь бид өмнөх долоо хоногт нь чуулганы ач холбогдлын тухай дахин дахин ярилцаж байсны үр дүн болов уу гэж боддог.

Ерөнхий чуулганы үеэр болон түүний өмнөх өдрүүдэд хуваари мөрдөх нь манай гэр бүлийн туршлагыг бүрмөсөн өөрчилснийг дурдахад баяртай байна. Бидний зүрх сэтгэл, оюун ухаан чуулганд бэлтгэгдсэн юм. Цаг заваа нэмэлт үйл ажиллагаануудад зориулахгүй байснаар бид тухтай сууж удирдагчдынхаа үгс болон зөвлөгөөг анхааралтай сонсож Сүнсийг мэдэрч чадсан билээ.

Бид чуулган бүрээр тавьсан зорилгодоо хүрсэн. Учир нь манай гэр амар амгалангаар бялхаж байсан юм. Манай хүүхдүүдээс хэд нь тусдаа гарсан ч гэртээ байсан үеийнхтэйгээ адил чуулганы үеэр болон өмнөх хэдэн өдөр үйл ажиллагаа төлөвлөхгүй байхад нь бид тэднийг дэмжсээр байдаг билээ. Бид бас чуулганы аль нэг хуралдааныг гэр бүлээрээ хамт үзэхээр төлөвлөхийг хичээдэг. Хүүхдүүд маань гэрлэн, өөрийн үр хүүхэдтэй болсон үедээ чуулганы энэхүү туршлагадаа өндөр ач холбогдол өгч, хэвээр нь хадгалж, чуулганы үеэр өөр үйл ажиллагаа төлөвлөхгүй байх болно гэдэгт би итгэж байна. ■



ЧУУЛГАНЫГ ЭН ТЭРГҮҮНД ТАВЬ

“Яг одоо ерөнхий чуулганыг амьдралдаа эн тэргүүнд тавих шийдвэрийг гарга. Чуулганаар заасан сургаалуудыг анхааралтай сонсож, амьдралдаа хэрэгжүүлэх шийдвэрийг гарга.”

Далын Ахлагч Паул В.Жонсон, “The Blessings of General Conference,” Лиахона, 2005 оны 11-р сар, 52.

НЯМ ГАРАГИЙН ХИЧЭЭЛИЙН ХАРИУЛТУУД

Эмма Адамс

Би өөртөө тулгарсан бэрхшээлүүдийг шийдвэрлэх онцгой хариултуудыг, тэгэхдээ бүх асуудалд тохирох нэг л зүйлийг олоход туслаач гэж Их Эзэнээс гуйхыг боддог байлаа. Асуудалд ийм байдлаар хандах нь юмсыг улам бүр ээдрээтэй болгодгийг би мэдсэн.

Би тойрогтоо Сайн мэдээний сургаал хичээлийг зааж байхдаа гүнзгий тунгаан бодох хийгээд хурц ухаан шаардсан шинэ сэргэг асуултуудыг асуухаар шийдэж билээ. Өөрөөр хэлбэл би тойргийн гишүүдэд долоо хоног бүр санал болгодог “Ням гарагийн хичээлийн асуултуудыг” товхимлоос эш татахаас зайлсхийхийг хүссэн юм.

Хичээлдээ бэлтгэн Шинэ Гэрээг унших үеэр *дотор байх* гэдэг үг дахин дахин тааралдсанд ихэд гайхлаа. Жишээ нь, Иохан 15:10-т, “Би Эцэгийнхээ тушаалыг сахиж, Түүний хайр *дотор байдгийн* адил, та нар миний тушаалыг сахивал Миний хайр *дотор байх болно*” (онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Аврагч өөрийн агуу залбиралдаа “Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ. Мөн Би тэдний дотор, Та Миний дотор байдаг. Ингэснээр тэд төгс нэгдэж болно” (Иохан 17:21, 23) хэмээн шавь нарынхаа төлөө залбирсан байдаг.

Миний олж мэдсэн зүйлийн ихэнх нь би Их Эзэнтэй хэрхэн нэг байж болох тухай, би Түүний хайр *дотор хэрхэн байж* болох тухай байсан бөгөөд үүний үр дүнд би илүү их тэвчээртэй болж, энэхүү тэвчээрийнхээ хүчинд өөрийгөө тамирдуулсан туршлагаас хүч чадал, урам өгч, ариусгасан өөрчлөлт гаргах нь надад туйлын чухал байлаа.

Егөөдсөн утгаар бол, би *дотор байх* гэдэг үгийн утгыг ойлгох, өдөр бүр тулгардаг хүнд сорилтуудад хариу олохоор эрж хайтал нөгөөх зайлсхийхийг хүссэн Ням гарагийн хичээлийн оновчтой хариултууд руу яах ч аргагүй эргэж очих нь тэр. Тэгээд судрууд уншиж, өдөр бүр залбиран, гэр бүлдээ болон бусдад үйлчилж, ариун сүмд орж, ням гарагийн цуглаануудад оролцоноор би сорилтууддаа хариуг олсон билээ. Эдгээр энгийн зүйлсийг тэвчээртэйгээр бүр төгс тэвчээртэйгээр хийснээр өөрчлөлт гарч боддгийг би мэдсэн.

Ням гарагийн хичээлийн хариултууд бол үнэхээр хамгийн сайн хариултууд юм. ■



ИТГЭЛЭЭ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

“Үйлчлэх, суралцах, залбирах ба шүтэн бишрэх нь, [бидний итгэлд] юу дутагдаж байгааг дүүргэх дөрвөн суурь зарчим мөн.

(1 Тесалоник 3:10.) Хэрэв дээрх суурь зарчмуудаар итгэлээ тордохоо боливол бид сул дорой болно. . . .

“Улам таагүй болж байгаа дэлхийд Их Эзэн ‘Сүнсний сэлэм буюу Бурханы үгийг’ ашиглан, бидний ухамсарт нөлөөлж чадна. (Ефес 6:17; мөн Жером 1:12-ыг үзнэ үү.) Гэвч сонсох нь ‘итгэлээр холбогдох’ (Еврей 4:2) ёстой ба бид дахин дахин сонсдогчлон Христэд үйлчлэх үйлчлэлээр холбогдох ёстой.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл (1926–2004), “Lest Ye Be Wearyed and Faint in Your Minds,” *Ensign*, 1991 оны 5-р сар, 88.



СҮМЭЭС ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН МАТЕРИАЛУУДЫГ АШИГЛАХ НЬ

“Багш нар болон удирдагчид сайн мэдээний сургаалуудыг зааж, гэрчлэхийн тулд судрууд, хожмын үеийн бошиглогчдын сургаалууд, Сүмээс хүлээн зөвшөөрсөн сургалтын материалуудыг ашигладаг. Анги буюу чуулга бүрд зориулан Сүмээс хүлээн зөвшөөрсөн сургалтын материалуудыг (*Сургалтын төлөвлөгөөний заавар*) -т жагсаасан байгаа. Шаардлагатай бол багш нар, удирдагчид сургалтын нэмэлт материалуудыг Сүмийн сэтгүүлүүд, ялангуяа *Ensign* ба *Лиахона* -гийн ерөнхий чуулганы дугааруудаас авч болно.”

Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 5.5.4.

Алсын хараатай амьдрал

БИДНИЙГ ИРЭЭДҮЙД БЭЛТГЭДЭГ

Бэлтгэлтэй бөгөөд бие даах чадвартай байхад Хожмын Үеийн Гэгээнтнүүд итгэдэг. Бид ажилтай болохын тулд боловсролтой болж, санхүүгийн хямрал тохиолдсон хүнд үед, байгалийн болон бусад гамшгийн үед бэлтгэлтэй байхад итгэдэг. Хамгийн чухал нь бид Бурхан Эцэгтэйгээ Тэнгэрт дахин хамт амьдрахын төлөө мөн Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй байхад итгэдэг. Юм бүхэнд ийнхүү бэлтгэлтэй байхыг алсын хараатай амьдрал гэдэг.

Алсын хараатай амьдрал нь бидний мөнхийн мөн чанарт тусгалаа олсон юм: Бид “[өөрсдийн төлөө] үйлдэх бөгөөд бусдаар өөрсөд дээрээ үйлдүүлэх нь үгүй болой” (2 Нифай 2:26). Их Эзэн биднээс хариуцлагатай бөгөөд бие даах чадвартай байхыг хүсдэг (С ба Г 78:14-ийг үз). Бид алсын хараатай амьдарснаар хариуцлагатай, өгөөмөр сэтгэлтэй, буурь суурьтай, нинжин сэтгэлтэй болох учраас Тэрбээр биднийг тийнхүү амьдрахыг хүсдэг. Бид хэдий чинээ бие даах чадвартай байна, төдийчинээ гэр бүлдээ болон бусдад тусалж чадна. Хэрэв бид өөрөө өлсгөлөн байвал өлссөн хүмүүсийг яаж тэжээх юм бэ? Хэрэв бид өөрсдөө мэдлэгээр дутмаг байвал яаж мэдлэгээ бусадтай хуваалцах


юм бэ? Хэрэв бид өөрсдөө итгэлээр дутуу дулимаг байвал яаж бусдад итгэлээ хөгжүүлэхэд нь туслах юм бэ?

Алсын хараатай амьдралын зарчмуудад дараах зүйлс орно:

- Бэлтгэл. “Бэлтгэгтүн та нар, ирэх тэр зүйлийн төлөө бэлтгэгтүн та нар, учир нь Их Эзэн ойрхон байна” (С ба Г 1:12).
- Ажилсаг чанар. “Чи залхуу байх ёсгүй” (С ба Г 42:42).
- “Бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн (С ба Г 88:118).

Сүмийн гишүүд өөрсдийнхөө төлөө өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийсэн ч үндсэн хэрэгцээгээ хангаж чадахгүй бол юуны өмнө гэр бүлийнхнээсээ тусламж хүсэх ёстой. Хэрэв гэр бүлийн гишүүд нь туслах боломжгүй бол Сүм тусалж болно. Бишоп болон салбарын ерөнхийлөгч гишүүдэд туслахын тулд “Их Эзэний агуулахын” нөөцөөс ашиглаж болно (С ба Г 82:18–19-ийг үз). Сүмийн аливаа тусламж нь гишүүдэд бие даах чадвараа дээшлүүлж, ажил хийж, амьдралаа өөд татахад нь туслах зорилготой юм. ■

Дэлгэрэнгүй мэдээллийг Эхлэл 41; С ба Г 38:30-аас үзнэ үү.



“Бид өөрсдийгөө болон гэр бүлээ материаллаг хийгээд сүнслэг байдлын хувьд хангах үүрэг хариуцлагыг хүлээдэг. Бид алсын хараатай амьдралын зарчмуудыг хэрэгжүүлэх ёстой. Үүнд нөөц боломжийнхоо хэмжээгээр өөдрөг өрнүүн амьдрах, байгаа юмандаа сэтгэл хангалуун байж, хэт их ер тавихаас зайлсхийн, ухаалгаар арвилан хэмнэж, хүнд үе болон онцгой байдалд бэлтгэлтэй байх нь орно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс, “Becoming Provident Providers Temporally and Spiritually,” *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 8.

Бид бие даах чадвартай болохын төлөө дараах зүйлс дээр ажиллах хэрэгтэй:

Сүнсний хүч чадал: Их Эзэнд итгэн, зарлигуудыг дуулгавартай дагаж, өдөр бүр залбирч, судруудыг судал; бусдад үйлчил.



Бие бялдрын эрүүл мэнд: Мэргэн Ухааны Үгийг дагаж, биеийн тамирын дасгал хийж бай; хангалттай унтаж амран, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сайн сахь.




Ажил эрхлэлт: Өөрийнхөө болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангахын тулд ажил хий.

Гэрийн нөөцлөлт: Ундны цэвэр ус нөөцөлж, байнга болон урт хугацаанд хэрэглэх үр тариа, вандуй зэрэг хүнсний нөөцийг аажмаар бүрдүүл.



Боловсрол: Бичиг сурч, ажлын ур чадвар эзэмш; “шилдэг номуудыг” (С ба Г 88:118) уншиж судал.



АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ НЬ

Хожмын Үеийн Гэгээнтнүүд яагаад нууцаар хүнс цуглуулж, нөөцөлдөг юм бол хэмээн зарим хүмүүс боддог байх. Хүнс, цэвэр ус ховордох буюу гэр бүлийн санхүүгийн байдал хүндэрсэн үед бэлтгэлтэй байхын тулд бид хүнс, ус нөөцөлдөг нь үнэн. Онцгой хүнд үе тохиолдоход хүнс нөөцөлсөн хүмүүс илүү аюулгүй байж, хямралын үед гэр бүл болон хөршүүддээ туслах боломжтой байх болно.

Санхүү: Аравны нэг болон бусад өргөлүүдийг төл; шаардлагагүй өр зээлээс зайлсхий; санхүүгийн нөөцийг аажмаар бүрдүүл.

Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс

“Өчүүхэн мөн энгийн зүйлүүдээр агуу их зүйлүүд улиран авчрагддаг” (Алма 37:6).

АГУУ ХҮМҮҮСИЙН АМЬДРАЛ МАРТАГДДАГҮЙ

Ньюел К.Витней (1795–1850)

Доод талд, зүүн дотор талд: Ньюел К.Витнейн сийлбэр хөрөг зураг. Доод талд, баруун талын оруула: Огайогийн Кертланд дахь Витнейн дэлгүүрийн дээд давхар. Энэ дэлгүүрт Бошиглогчдын сургууль хичээллэж, Сүмийн цуглаанууд болдог байжээ. Доод талд: Витнейгийн дэлгүүр.

Ньюел Кимбалл Витней 1795 оны 2-р сарын 5-нд АНУ-ын Вермонтод төржээ. Тэрбээр авьяаслаг бизнесмен байсан бөгөөд Сидни Гилберттэй нөхөрлөж, бизнесийнх нь түнш болжээ. Бизнесийнхээ эхний жилүүдэд тэд олон удаа томилолтоор явдаг байв. Ньюел нэг удаа бизнесийн томилолтын үеэрээ Огайогийн Кертландад Элизабет Анн Смиттэй танилцжээ. Ньюел Анн хоёр гурван жил болж уулздаг байсан бөгөөд 1823 онд гэрлэжээ.

Ньюел, Анн хоёр үнэнийг хамтдаа эрж, эртний Христийн шашныг сэргээх зорилготой хэмээн мэдэгддэг байсан Кампбеллийн хөдөлгөөнд нэг хэсэг

оролцдог байв. Нэг орой Ньюел, Анн хоёр “Ариун Сүнсний бэлгийг хэрхэн олж авч болохыг Их Эзэнээс асууж мэдэхийн тулд” залбирчээ. Залбиралдаа үзэгдлээр хариу авсан тухайгаа Анн ийн дүрсэлсэн байдаг: “Сүнс бидэн дээр оршиж, манай гэрийг үүл нөмөрлөө. . . Тэгтэл: Их Эзэний үгийг хүлээн авахад бэлтгэ, учир нь тэр үг ирнэ” хэмээн үүлнээс гарах дууг бид сонслоо.”¹

Залбирлын энэ хариунаас хойш удалгүй 1830 оны 10-р сард Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчид Кертландад ирсэн ажээ. Арваннэгдүгээр сард Ньюел, Анн хоёр баптисм хүртэв. Хэдхэн сарын дараа Иосеф Смит, Эмма

Смит хоёр Витнейнхний хаалгыг тогшжээ. Иосеф Ньюелийг нэрээр нь дуудаж, мэнд усыг нь мэдэхэд Ньюел Бошиглогчийн нэрийг мэдэхгүйгээ хэлж чадсангүй. Тэгэхэд нь Иосеф, “Би Бошиглогч Иосеф байна; та миний төлөө энд залбирсан шүү дээ. Одоо надаас юу хүсэхсэн бол?” гэж асуусан гэдэг.² Витнейг хүн тэгэхэд Смитийнхнийг хэдэн долоо хоног гэртээ байгаж, 1832 оны есдүгээр сард тэднийг орон байраар хангасан аж.

Ньюел Смитийнхнийг орон байраар хангаснаас гадна дэлгүүрийнхээ дээд давхрыг бүхэлд нь Сүмд ашиглуулж байжээ. Витнейн дэлгүүрт Сүмийн удирдагчид хурал цуглаан хийж, Бошиглогчдын сургуулийг хичээллүүлж байв.

1831 оны 12-р сард Ньюел Сүмийн хоёр дахь бишпоор дуудагдсан бөгөөд хожим нь Сүмийн санхүүгийн үйл ажиллагааны менежерээр үйлчилж, мөнгөн хөрөнгөө эрхлэн зарцуулж, өрнөөс гарахад нь Сүмд тусалсан ажээ. 1838 оны намар Витнейгийн гэр бүл Миссурийн Фар Вестэд шилжиж ирэхэд Ньюел дахин бишпоор дуудагдав. Түүнээс хойш 10 жилийн дараа тэр гэр бүлийнхээ хамт хээр талыг туулан Солт Лейк уруу аян хийж, тэнд Сүмийн Тэргүүлэх Бишпоор үйлчилж байв.

Ньюел 1850 оны 9-р сарын 24-нд Солт Лейк хотод амьсгалын замын өвчнөөр нас баржээ.

ЭШЛЭЛ

1. Элизабет Анн Витни, Эдвард Таллийжийн *The Women of Mormondom* (1877), 41–42-т эш татжээ.
2. Иосеф Смит, Элизабет Анн Витнейгийн “A Leaf from an Autobiography,” *Woman's Exponent*, 1878 оны 8-р сарын 15, 51-д эш татжээ.



Дан Жонс (1810–62)

Сүмийг зохион байгуулагдсанаас хойш нэг саяас илүү номлогчид дуудагдсан боловч Дан Жонс саяд нэг тохиох ховор номлогч байлаа. Уэльсийн номлогчдын талаар Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) ийн хэлсэн юм “Хөрвүүлсэн хүмүүсийнхээ тоогоор бол Дан Жонс Сүмийн түүхэн дэх хамгийн үр бүтээлтэй таван номлогч нарын нэг юм”.¹

Тэр номлогч болохоосоо өмнө Уэльсээс Америкийн Нэгдсэн Улсад цагаачилсан байсан ба Миссури мөрөнд маш олон Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг Иллинойгийн Наувуд авчирсан *Maid of Iowa* нэртэй хөлөг онгоцонд ахмадаар ажиллаж байсан юм. Тэрээр 1843 онд Сүмд нэгдсэн бөгөөд Бошиглогч Иосеф Смиттэй дотно найзууд болсон ажээ.

Данийн номлол Иосеф Смитийн хамгийн сүүлд бичиглэсэн бошиглолыг гүйцэдүүлжээ. Бошиглогч Иосеф Смит хөнөөгдөхийнхөө өмнөх орой Картейжийн шоронгийн цонх руу буудах буун дууг сонссон учраас шалан дээр унтахаар шийджээ. Түүний дэргэд Дан Жонс байлаа. Бошиглогч Дан Жонсоос үхэхээс айсан эсэхийг нь асуужээ. Тэр “Үхэх цаг нь ирсэн гэж бодож байна уу? Ийм агуу ажил хийж байгаа хүний хувьд надад үхэл тийм аймшигтай санагдахгүй байна” гэж хариулсан байна. Тэгээд Иосеф “Чи хэзээ

нэгэн цагт Уэльсийг харах болно. Мөн чамд тохоогдсон номлолыг чи нас барахаасаа өмнө хийх болно” хэмээн бошигложээ.²

Бошиглогчийн амлалт Дан эхнэр Жейнийхээ хамт Уэльст үйлчлэхээр дуудагдах үед 1845 онд биеллээ олсон байна. Дан сайн мэдээг агуу итгэл үнэмшилтэйгээр заахад өөрийн авьяас билгийг ашигласан билээ. Тэрээр Уэльс ба Англи хэл дээр ус цас ярьдаг байсан төдийгүй хоёр хэлээр сургаалыг зааж, сонирхогчдын анхаарлыг олон цагийн турш татаж чаддаг байснаараа бичиглэсэн бошиглолын гэрч болжээ.

Уэльст байхдаа Дан Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сэтгүүл, товхимол, номнуудыг Уэльс хэл дээр хэвлэж гаргасан байна. Дан Жонсын удирдлага дор Уэльс дэх номлогчид 29 салбарыг зохион байгуулж, түүний номлолын эхний жилд 1000 хүнд баптисм



хүртээжээ. Тэрээр 1852 онд Уэльст хоёр дахь номлолоо хийхээр дуудагджээ. Тэр үед Сүмийнхнийг улам ихээр хавчиж, дарамталж байсан ч дөрвөн жилд 2000 хүн баптисм хүртээсэн байна.

Юта руу буцахдаа тэрээр маш олон Уэльс хөрвөгчдийг Ютад авчирчээ. Тэрээр 51 настайдаа нас барахдаа ойролцоогоор 5000 хүнийг АНУ-н барууны мужуудад ирэхэд нь тусалсан билээ.

ЭШЛЭЛ

1. Гордон Б.Хинкли, “The Thing of Most Worth,” *Tambuli*, 1994 оны 3-р сар, 8; *Ensign*, 1993 оны 9-р сар, 7.
2. Иосеф Смит, *History of the Church*, 6:601.



Зүүн гар талаас: Уэльс номлогч Дан Жонсийн хөрөг зураг. Хөлөг онгоц, Иллинойгийн Наувуд газардсан Дан Жонсын удирдсан хөлөг онгоцны загвар. Дан Жонс Уэльс хүмүүст цагаачлахад нь тусалжээ.

АРИУН ЯВДАЛ БА АРИУН ЖУРМЫГ Заах нь



Маттью О.Ричардсон

Ням гарагийн ангийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Эцэг эхчүүд хүүхдүүддээ бэлгийн харилцааны тухай заахдаа доорх зургаан стратегийг хэрэглэж болно.

Дэлхийн олон орны янз бүрийн ажил мэргэжилтэй залуучууд болон залуу насанд хүрэгчидтэй уулзаж, ярилцах боломж надад олдсон юм. Нэг удаа би ариун журам, ариун явдал ба ёс суртахуунтай амьдралын тухай өсвөр насны, нүдэнд дулаахан хэсэг залуустай ярилцлаа. Бодол санаа, итгэл үнэмшил, гадаад төрх, зан төлөв нь надад хэчнээн сайхан санагдсаныг тэдэнд хэлсний дараа би “Та нар энэхүү эмзэг сэдвийн талаар ийм цэгцтэй, тодорхой, итгэлтэй хариултыг хэрхэн өгч чадсаныг би мэдэж болох уу?” гэж асуулаа. Нэг залуу эмэгтэй өчүүхэн ч эргэлзэлгүйгээр, “Эцэг эх минь надад заасан юм” гэхэд бусад нь зөвшөөрч толгой дохив. Энэхүү энгийн атлаа үр өгөөжтэй туршлага нь ялангуяа ариун журам ба ариун явдал, бэлгийн болон хүмүүс хоорондын харилцааны тухай хүүхдүүддээ заах эцэг эхчүүдийн үүрэг тэдний амьдралд чухал нөлөө үзүүлдэгийг харуулж байна.

Харамсалтай нь, олон эцэг эх хүүхдүүддээ бэлгийн харилцааны асуудлуудын тухай боломжийнхоо хэрээр заахгүй байна. Жишээ нь, Хожмын Үеийн Гэгээнтэн 200 гаруй ганц бие идэвхтэй гишүүдэд хийсэн судалгаа тэдний дөнгөж 15 хувь нь бэлгийн харилцааны асуудлуудын тухай анх эцэг эхээсээ сонсож мэдсэнийг харуулж байна. Залуу гишүүдийн үлдсэн хэсэг нь энэхүү чухал сэдвийн тухай найз нар буюу үе тэнгийнхэн, интернет, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үзвэр, сурах бичиг, төрөл садан

болон Сүмийн удирдагчдаас мэдсэн хэмээн хариулжээ.

Мэдээж хэрэг энэ бол заахад амаргүй сэдэв. Гэвч энэ мэтийн ариун зарчмуудыг заахад эцэг эхчүүд хамгийн сайн багш гэдэгт би итгэдэг. Дараах стратегиуд нь танд ариун журамтайгаар амьдарч, ариун явдлын хуулийг чанд сахихыг хүүхдүүддээ зааж сургах энгийн атлаа урт удаан хугацаанд үр өгөөжөө өгөх зарчмууд хийгээд үйл ажиллагааг хөгжүүлэхэд туслах болно.

Заах, сурах үйл ажиллагаа хүүхдийн бага наснаас эхлэх ёстой. Бэлгийн харилцааны сэдвийг хүүхдүүддээ үр нөлөөтэй заадаг эцэг, эхчүүд хүүхдүүд нь тэдний бодлогоос эсвээс тэдний хүсдэгээс хавьгүй эрт энэ сэдэвтэй тулгардгийг ойлгодог. Олон хүүхэд 11, бүр түүнээс ч бага насандаа бэлгийн харилцааны тухай интернетээс олж үздэг болжээ. Үзвэр цэнгээний газар, спортын үйл явдлууд, зар сурталчилгаа, тэр ч байтугай олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хүртэл бэлгийн харилцааг шууд бус замаар өөгшүүлэн дэмжсэн мэдээллээр дүүрэн байх болжээ.

Зарим эцэг эхчүүд “Бэлгийн харилцааны сэдвийг би хүүхдэдээ хэзээнээс эхэлж ярих ёстой вэ?” гэж асуудаг нь зүйтэй юм. Энэ нь тухайн хүүхдийн нас, өсөлт, амьдарч байгаа орчин нөхцөлөөс хамааралтай байдаг. Хүүхдүүдийнхээ зан авирыг анхааралтай ажиглан, үгийг нь зориуд сонсож, юуг, хэзээ заавал зохихыг залбирч шийддэг эцэг эхчүүдэд сүнсний удирдамж ирэх болно. Жишээ нь, манай хүү дөнгөж таван настай байхдаа хүний биеийн анатомийн тухай надаас олон асуулт асуудаг байсан. Энэ тухай ярилцах нь эхлээд жаахан эвгүй юм шиг санагдсан ч цаг нь үнэхээр болсон юм шиг байсан. Гэвч чухам юу гэж хариулах билээ гэж бодтол хүүтэйгээ бэлгийн харилцааны тухай ярилцах цаг *болоогүй* нь тодорхой байлаа.

Заах болон сурах үйл явц байнгын шинжтэй байх ёстой. Суралцах нь нэг удаагийн үйлдэл биш харин байнга үргэлжилдэг үйл явц юм. Бэлгийн харилцаа



болон үүнтэй холбоотой бусад асуудлуудын тухай хүүхдэд заана гэхээр хүмүүс ихэнхдээ үүнийг нүүр улайм “яриа” гэж боддог. Юутай ч гэсэн энэ сэдвийн талаар эцэг эхчүүд хүүхэдтэй ганцаарчлан ярилцах хэрэгтэй нь ойлгомжтой. Гэхдээ энэ бол хүүхдийн хувьд сурч мэдэх хамгийн үр ашигтай арга зам биш. Бид “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) суралцдаг хэмээн Аврагч сургасан билээ. Бид бэлгийн харилцааны сэдвийг хүүхдүүдийнхээ нас, өсөлтийг харгалзан олон дахин ярилцвал илүү амжилт олох болно. Энэ зарчмыг ойлгодог эцэг эхчүүд бэлгийн харилцааны тухай сэдвүүдийг хүүхдүүддээ бага насанд нь болон өсвөр үед нь заахад оюун санаа, сэтгэл хөдлөл, сүнслэг байдлын хувьд өөрсдийгөө бэлтгэдэг.

Үр өгөөжтэй заах хийгээд суралцах үйл явц нь багш, суралцагч хоёрын харилцаанаас хамааралтай байдаг. Бэлгийн харилцаа болон үүнтэй холбоотой асуудлын тухай хүүхдэд заана гэхээр ихэнх эцэг эхчүүд юу ярьдаг билээ хэмээн хэтэрхий их санаа зовдог. Энэ нь чухал ч гэсэн

үр өгөөжтэй заах болон суралцах үйл явц нь аль нэг зүйлийн зөвхөн агуулгын тухай ярилцахаас илүү чухал зүйл юм. Чухамдаа хүүхдүүддээ заадаг эцэг эхчүүдийн *арга барил* нь тэдний юу ярихаас илүү чухал байж болно. Бэлгийн харилцааны асуудлуудаар хүүхдүүдтэйгээ илэн далангүй ярилцаж, амьдралд нь идэвхтэй оролцдог, тэдэнд хайр, анхаарал халамж тавьдаг эцэг эхчүүд хүүхдүүддээ нөлөөлж чаддагийг судалгаа харуулж байна.¹

Хожмын Үеийн залуу Гэгээнтнүүд бэлгийн харилцаатай холбоотой асуудлуудаар эцэг эх нь тэдэнтэй илэн далангүй ярилцдаг байхыг хүсдэгийг миний хийсэн албан бус судалгаа харуулж байна. Эдгээр залуу насанд хүрэгчид эцэг эх нь энэ асуудалд оролцоосой гэж боддог төдийгүй *үглэж яниших* биш харин *өөрсөдтэйгөө* илэн далангүй ярилцаасай гэж хүсдэгээ илэрхийлж байлаа. Тэд эцэг эхээсээ “зүй ёсны”, “энгийн”, “тааламжтай”, “нүүр улаймаар биш” яриаг хүсдэг ажээ. Энэ нь эцэг эхчүүдэд нээлттэй, энгийн, нөхөрсөг байж, аливаа сэдэв, нөхцөл байдалд сандарч тэвдэлгүй ярилцдаг

Бэлгийн харилцааны асуудлуудаар хүүхдүүдтэйгээ илэн далангүй ярилцаж, амьдралд нь идэвхтэй оролцдог, тэдэнд хайр, анхаарал халамж тавьдаг эцэг эхчүүд хүүхдүүддээ нөлөөлж чаддаг.

байхын тулд илүү шаргуу ажиллахад нь тусалдаг. Хэрэв хүүхдүүдээ үр ашигтайгаар заахын тулд аль ч сэдвийн талаар ялангуяа хувийн шинжтэй сэдвээр хүүхэд нэг бүртэй ганцаарчлан ярилцахад эцэг эхийн зүгээс хамгийн их анхаарах зүйл бол хүүхдээ эвгүй байдалд оруулахгүй, сэтгэл санааг тайван, тавтай байлгах явдал мөн.

Ярилцах сэдэв оновчтой бөгөөд зайлшгүй шаардлагатай байвал заах, суралцах үйл явц хамгийн үр нөлөөтэй байдаг. Бэлгийн харилцааны асуудалд хандах бидний хандлагаас хамааран энэ нь эвгүй, тааламжгүй эсвэл амьдралд төдийлөн хэрэгтэй биш юм шиг санагдаж болох ба бүр эсрэгээр тааламжтай санагдаж ч болно. Энэ тохиолдолд амжилт олох түлхүүр нь хүүхүүдэд байдаг ихэнх асуултууд болон санаа зовоох асуудлууд нь амьдралын бодит нөхцөл байдал, ажиглалтын хариултауд гэдгийг ойлгох явдал юм. Бид хүүхдүүдээ ажиглаж, үг яриаг нь анхааралтай сонсвол тэдэнд юу заах хэрэгтэйг мэдэх болно.

Жишээ нь, кино, хувцасны загвар, нийгэмд түгээмэл байдаг ямар нэг үзэл бодол, зурагтын хөтөлбөр, зар сурталчилгаа, яруу найраг зэрэг нь ёс суртахууны жишгүүдийн тухай ярилцах боломжийг үргэлж олгодог. Хүүхдүүд бусад хүмүүстэй хэрхэн харилцаж, хамтран ажиллаж байгаа, тэд өөрсдөө болон үе тэнгийнхэн нь яаж хувцасладаг, хэл яриа нь ямар байгаа, эсрэг хүйстэндээ болон ариун явдал, ёс суртахууны жишгүүдийн талаарх нийгэм дэх олон янзын үзэл бодолд хэрхэн ханддагийг гярхай ажиглах нь мөн л заах боломжийг бидэнд олгодог. Ёс суртахуун ба ариун журмын тухай хүүхдүүдтэйгээ амьдралтай холбон ярилцах боломж үй олон байдаг.

Амьдралтай холбон заахад хамгийн чухал нь эцэг эхчүүд ариун явдал, даруу зан ба ариун журмын үлгэр жишээг өөрсдийн амьдралд харуулах явдал мөн. Эцэг эхийн зөвлөгөө нь тэдний сайн үлгэр дуурайл дээр үндэслэж байгаа үед хүүхдүүд эцэг эхийнхээ зөвлөгөөг илүү сайн сонсож, дуулгавартай дагадаг.

Эцэг эхийн үлгэр дуурайл муу бол хүүхдүүдэд мөн л муугаар нөлөөлнө. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс хэлсэн нь: “Олон тохиолдолд, бидний үйлдэл бусад хүмүүст бидний үг ярианаас илүү хүчтэй нөлөөлдөг.” Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) сургасан нь: “Бид [хүүхдүүдээ] даган дуурайгаасай гэж

*Бид хүүхдүүдээ
ажиглаж,
үг яриаг нь
анхааралтай
сонсвол
тэдэнд юу
заах хэрэгтэйг
мэдэх болно.*

хүсдэг үлгэр жишээг өөрсдөө үзүүлэх ёстой. Бид үүнийг ойлгодог уу? Хүүхдээсээ эсвэл хүүхдүүдээсээ дуулгавартай, эелдэг зан харьцаатай, хэл яриа төвшин, дуугаа өндөрсгөж, чанга ярьдаггүй, бүх талаараа бусдын нүдэнд дулаахан харагддаг байхыг шаарддаг атлаа өөрсдөө зан авир муутай, хараалын үгс урсгадаг эцэг эхчүүд олон байдгийг бид мэднэ. Ийм байх нь хэчнээн харамсалтай, утга учиргүй хэрэг билээ!”² Бидний ийм зохисгүй зан авирыг хүүхдүүд маань ажиглаж, өөрсдийнхөө иймэрхүү үйлдлийг зөвтгөх шалтаг олох болно.”²

Суралцагчид багшийн заасан зүйлийг ойлгосон үед амжилттай суралцаж чадна. Эцэг эхчүүд нь, бүр Сүмийн удирдагчид хүртэл яриандаа дүлэгнэсэн, “бүдэг бүрхэг үг хэллэг” хэрэглэдэг нь хэрэг дээрээ улам олон асуудлыг бий болгож, тус нэмэр болохоосоо илүү эргэлзээ төрүүлдгийг олон залуус, залуу насанд хүрэгчид харамсан өгүүлж байна. Энэ нь бэлгийн харилцааны сэдвийн тухайд бүр ч үнэн юм.

Намайг ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргийн бишопоор үйлчилж байхад “илж таалах” гэж юу гэсэн утгатай үг болохыг олон гишүүн асуудаг байсан. Манай тойргийн гишүүдэд хүний биеийг илж таалж болохгүй гэж заадаг байсан ч, илж таалах гэдэг нь чухам юу болохыг огт заадаггүй байлаа. Ойлгоогүй зүйлээ дагаж мөрдөнө гэдэг тэдэнд хэцүү байсан нь мэдээж хэрэг.

Ямар нэг зүйлийг зөвхөн бусад хүмүүс ойлгож болох арга замаар заах нь хангалтгүй юм. Харин бид үүнийг хэн ч буруу ойлгохгүй байх тийм аргаар заах ёстой хэмээн Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Марион Ж.Ромни (1897–1988) тайлбарлажээ.³ Бид бүдэг бүрхэг буюу этгээд үг хэллэгээр ярихын оронд зөв бөгөөд тохирох нэр томъёог ашиглавал илүү амжилт олох болно. Энэ нь ярилцаж байгаа асуудлыг зөв ойлгоход тусалж, зөвлөгөө өгөгчийг хүндлэхэд хүргэнэ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт ёс суртахууны зарчмууд хийгээд жишгүүдийг хэрхэн үр өгөөжтэй заасныг ажиглана уу. Тэрбээр ийн хэлжээ: “Гэрлэлтээс гадуур бэлгийн сэрлийг өдөөсөн аливаа янаглал нь, тухайлбал хувцастай болон хувцасгүй байхад нь өөр хүний биеийн ариун нандин, нууцлаг эрхтнүүдэд зориуд хүрч илж таалах нь нүгэл бөгөөд үүнийг Бурхан хориглосон юм. Энэ нь бас та бие



эрхтнийхээ дотоодод ийм сэрлийг зориудаар өдөөж байгаа зохисгүй үйлдэл мөн.”⁴

Үр нөлөөтэй заахын тулд зааж байгаа хүмүүс маань захиасыг ойлгодог байхад бид онцгой анхаарах ёстой. “Энэ зөвлөгөө асуултанд тань хариулав уу?” “Би ойлгомжтой тайлбарлаж чадав уу?” “Өөр асуулт байна уу?” гэхчлэнгийн энгийн асуултууд ашиг тустай байдаг.

Багш нар захиасаа мөнхийн зарчмууд болон жишгүүдтэй холбосон тохиолдолд суралцагчид сайн мэдээнд амжилттай хөрвөж чадна. Бид зөвхөн “амьдралын бодит байдалд” анхаарлаа төвлөрүүлэхээс илүүгээр эдгээр бодит байдлыг “мөнх амьдралын зүйлстэй” холбовол сайн мэдээг үр ашигтай зааж чадна. Жишээ нь, бид бие махбодынхоо талаар ярихдаа хайр энэрлээр дүүрэн Тэнгэрлэг Эцэг минь бидний биеийг хэрхэн бүтээсэн тухай, бид Түүний бүтээлтүүдэд Түүний хүсэн хүлээдгийн дагуу хэрхэн талархал, хүндэтгэлтэй хандах ёстойг ярьж болно.

Дэлхий ёс суртахуунгүй байдлын намаг балчигт живж байгаа ч гэсэн ирээдүй үеийнхний төлөө итгэл найдвар байгаа

билээ. Энэхүү итгэл найдвар нь өсвөр үеийнхэнд ариун журам ба ариун явдалтай байхыг заахад чадах бүхнээ хийдэг, нэгэн үзүүрт сэтгэлтэй эцэг эхчүүд дээр төвлөрч байна. Хүүхдүүдээ ариун журам ба ариун явдалтай амьдрахыг заадаг эцэг эхчүүд сайн мэдээний тухай мэдлэгээ гүнзгийрүүлж, заах ур чадвараа дээшлүүлэхийг үргэлж хичээдэг. Тэд ингэснээрээ “Их Эзэн Өөрийн зарлиг болгосон арга замаар өөрсдийг нь хүчирхэгжүүлэх болно” гэдгийг мэддэг. Эцсийн эцэст энэ нь “хайр энэрлийн хөдөлмөр, сонгох эрхээ зөв ашиглах, Христэд ирэх болон мөнх амьдралын адислалуудыг авахад нь бусдад туслах боломж юм.”⁵ ■

ЭШЛЭЛ

1. Бонита Ф.Стантон, Жеймс Бёрнс, “Sustaining and Broadening Intervention Effect: Social Norms, Core Values, and Parents,” *Reducing Adolescent Risk: Toward an Integrated Approach*, хянан тохиолдуулсан Даниел Ромер (2003), 193–200-г үзнэ үү.
2. Роберт Д.Хейлс, “Our Parental Duty to God and to the Rising Generation,” *Лиакхона*, 2010 оны 8-р сар, 74.
3. Жакоб де Жагер, “Let There Be No Misunderstanding,” *Ensign*, 1978оны 11-р сар, 67-г үз.
4. Ричард Г.Скотт, “Serious Questions, Serious Answers,” *Лиакхона*, 1997 оны 9-р сар, 31.
5. *Teaching, No Greater Call* (1999), 4.

Амьдралтай холбон заахад хамгийн чухал нь эцэг эхчүүд ариун явдал, даруу зан ба ариун журмын үлгэр жишээг өөрсдийн амьдралд харуулах явдал мөн.

ЗӨВ ШУДАРГА БАЙДЛЫГ ОРОН ГЭРТЭЭ заах нь

Зөв шударга амьдрахыг хүүхдүүдэдээ зааж, сурган хүмүүжүүлэх нь эцэг эхчүүдийн үүрэг хариуцлага бас тэдэнд өгөгдсөн адислал юм.



**Ахлагч
Делберт Л.Стейпли
(1896–1978)**

Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Делберт Л.Стейпли 1896 оны 12-р сарын 11-нд АНУ-ын Аризонад төржээ. Тэрээр 1950 оны 10-р сарын 5-нд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр дуудагдаж, 1978 оны 8-р сарын 19-нд нас барах хүртлээ уг чуулгад үйлчилжээ. Дараах үгийг тэрээр 1977 оны 2-р сарын 1-нд Бригам Янгийн Их Сургууль дээр хэлжээ. Энэ үгийн англи хэлээрх бүрэн эхийг speeches.byu.edu-гээс уншиж болно.

Эцэг эхчүүд үр хүүхдийг нь Сатан уруу татах хүчтэй болохоос өмнө буюу тэднийг найман нас хүрч Бурханы өмнө хариуцлага хүлээхээс өмнө тэдэнд зааж, зан араншинг нь төлөвшүүлэх боломжтой юм. . . . Хүүхэд юу хэлж, юу хийж байгаагийнхаа төлөө хариуцлага хүлээх чадваргүй байдаг, үнэт эрдэнэ лүгээ адил амьдралынх нь анхны жилүүдийг Их Эзэн эцэг эхчүүдэд итгэмжлэл хүлээлгэн даатгасан билээ. Зөв шударга амьдрахыг хүүхдүүдэдээ зааж, сурган хүмүүжүүлэх нь эцэг эхчүүдийн үүрэг хариуцлага бас тэдэнд өгөгдсөн адислал юм.

Зөв шударга амьдрал болон шүтлэг бишрэлийн тухай гэр оронд заах хамгийн

үр өгөөжтэй арга зам бол үлгэр жишээ юм. Эцэг эхчүүд өөрсдөө зөв шударга, цэвэр ариун амьдрах юм бол энэхүү үлгэр жишээгээрээ хүүхдүүдэдээ зааж, тэднийг сургаж хүмүүжүүлж чадна гэдэгт итгэлтэй байж болно. [Ерөнхийлөгч Давид О.МакКей (1873–1970) ийн сургажээ:] “Хэрэв та Бурханд итгэх итгэлийг заахыг хүсдэг бол Түүнд итгэх итгэлээ өөрөө харуул; хэрэв та залбирахыг заахыг хүсдэг бол өөрөө залбирч бай; . . . хэрэв та хүүхдээ дөлгөөн тайван зантай болгохыг хүсдэг бол өөрөө тайван дөлгөөн бай; хэрэв та хүүхдээ ариун журамтай, сайхан зантай, биеэ барьж чаддаг болоосой гэж хүсдэг бол эдгээр бүх зүйлээр хүүхдэдээ сайн үлгэр дуурайл үзүүл.”¹ Ийнхүү үлгэр дуурайл үзүүлэх нь хүүхдэдээ үр ашигтай заахад тань нөлөөлөх болно. Иймд эцэг эхээсээ удирдамж авсан хүүхдүүд Сатаны уруу таталтын эсрэг өөрийгөө хүчирхэгжүүлж чадна. Сатаны зорилго бол тэднийг хариуцлагын насанд хүрмэгц амьдралыг нь сүйрүүлэх явдал мөн. Эцэг эхчүүд хүүхдээ эелдэг, шударга, тэвчээртэй, бүх цагт зөв зүйлийг хийх зоригтой байхыг хүсдэгчлэн өөрсдөө тийм байх үүрэгтэй. Үлгэр жишээ нь зүгээр заахаас хавьгүй илүү хүчтэй байдаг.

Гэр орны өдөр тутмын амьдрал Сүмийн зарчмууд болон жишгүүдтэй нийцэж байх ёстой. Бидний бизнесийн үйл ажиллагаа бидний шүтлэг бишрэлтэй тохирч байх ёстой. Хүүхдүүд хуурмаг занг маш түргэн анзаардаг. АНУ-ын төрийн зүтгэлтэн, зохиолч Жон Милтон, хоёр нүүр гаргах нь нүгэл бөгөөд үүнийг зөвхөн Бурхан л ялган таньж чадна гэж хэлжээ. Харин хүүхдүүд буруу зүйлд эмзэг ханддаг бөгөөд хуурмагаар дүр эсгэхэд дургүй. Бид заадаг сургаалаасаа илүүгээр амьдралын үлгэр жишээгээрээ хүүхдүүдэд нөлөөлдөг мэддэг билээ. Эцэг эх нь хүүхдүүдэд үргэлж шударга хандаж, тэдэнд өгсөн амлалтаа биелүүлдэг, үргэлж үнэнийг ярьдаг байх ёстой. Энэ бол хүүхдийнхээ итгэлийг хүлээдэг эцэг эхийн шинж юм. Хүүхэд таныг өөрт нь хүндэтгэлтэй



хандаж, итгэдгийг мэдрэх юм бол энэхүү итгэлийг хөсөрдүүлэхгүй бас өөрийг тань хүндлэх болно. . . .

Эцэг эхчүүд хүүхдийнхээ дэргэд хэзээ ч хэрэлдэж, маргаж болохгүй. Зарим үед эцэг эхчүүд хүүхдийн буруу үйлдлийг залруулах буюу сахилгажуулах гэснээс хэрүүл маргаан үүсдэг. Эцэг эх хоёрын нэг хүүхдэд шүүмжлэхэд нөгөө нь өмөөрдөг. Ингээд хүүхдэд санаа тавих эцэг эх хоёрын нэгдмэл шаардлага байхгүй болдог. Эцэг эхчүүд хүүхдэдээ ямар зөвлөгөө өгөх, юуг анхааруулж хэлэх талаараа нэгдмэл санаа бодолтой байх хэрэгтэй. Эс тэгвээс хүүхэд эцэг эхийнхээ зөрүүтэй үгний учрыг олохгүй буруу замд орж болно. “Эцэг эхийн үг, санаа бодол зөрөх нь шударга бус хэрэг бөгөөд хүүхдийг төөрөлдүүлэх, гэр бүлийн суурийг сулруулах муу нөлөөтэй. Хүүхдийн удирдамж, зөвлөгөө авахыг хүсдэг хүмүүс нь өгч байгаа удирдамжиндаа санал нэгдмэл байх ёстой.” гэж Ричард Л.Эванс хэлжээ.² Хүүхдүүд гэр бүлийнхээ сэтгэл санааны байдалд мэдрэмтгий байдгийг бид мэднэ. Тэд гэр бүл дэх сэтгэл санааны түгшүүртэй байдал, өөрчлөлтийн учир шалтгааныг тэр бүр ойлгодоггүй эсвэл мэддэггүй. . . .

Хүүхэд гэр орноо өөрийн амьдрах газар, гаднаас ирж болзошгүй дэлхийн аюул, хилэнцээс өөрийг нь хамгаалах газар гэж мэдрэх эрхтэй юм. Хүүхдийн энэхүү

хэрэгцээг хангахад гэр бүлийн эв нэгдэл, зарчимч байдал чухал. Энэ амьдралд урт удаан үргэлжлэх, жинхэнэ аз жаргалыг олох газар гэр орноос өөр хаа ч байхгүй. Гэр орныг тэнгэрийн бяцхан хэсэг болгох нь боломжтой зүйл. Би тэнгэрийг энэ дэлхий дээрх бидний төгс гэр бүлийн амьдралын үргэлжлэл гэж боддог.³ . . .

Бидний заадаг сайн мэдээ үнэн. Христ амьд, Бурхан амьд бөгөөд итгэл бишрэлтэй, бие сэтгэл бүхнээ энэ ажилд зориулдаг. Түүний бүх хүүхдүүдэд тэнгэрт гайхамшигтай орд харшууд бэлтгэгдэж байна. Гэр орон, гэр бүл тань ямархуу байхыг, селестиел хаант улс дахь мөнх амьдрал руу гэр бүлийг тань хөтлөх зөв зам дээр үр хүүхдээ байлгаж, хэрэгцээг нь хэрхэн хангахаа одооноос эхлэн төлөвлө. Ах, эгч нар минь, Бурхан та нарыг нэг бүрчлэн адислах болтугай. Энд яригдсан зүйлсийн ихэнх нь та нарт хамаатайг та бүхэн ойлгож байгаа гэдэгт би итгэлтэй байна. Гэр орноо цэвэр ариун байлгаж, энэхүү ариун байдлаа үргэлж ахиулж байх нь амьдралыг тань адислахаар ирэх хойч үеийнхэнд чинь туйлын чухал юм. ■

Том үсгээр бичих болон цэг таслалын дүрмийг стандартын дагуу болгосон.

ЭШЛЭЛ

1. Давид О.МкКей, *Secrets of a Happy Life*, эмхтгэсэн Ллюлин Р.МкКей (1967), 11.
2. *Richard Evans' Quote Book* (1975), 23.
3. Давид О.МкКей, *Gospel Ideals* (1953), 490-ийг үз.

Хүүхэд гэр орноо өөрийн амьдрах газар, гаднаас ирж болзошгүй дэлхийн аюул, хилэнцээс өөрийг нь хамгаалах газар гэж мэдрэх эрхтэй юм. Хүүхдийн энэхүү хэрэгцээг хангахад гэр бүлийн эв нэгдэл, зарчимч байдал чухал.



ЗАЛУУЧУУДАД СҮНСЛЭГ ТУРШЛАГАТАЙ БОЛОХОД ТУСЛАХ НЬ

Сүнслэг туршлагатай болоход нь залуучуудыг хэн ч албадаж чадахгүй. Гэвч хөрвөлт рүү хөтөлдөг туршлагуудад тус дөхөм үзүүлэх олон арга зам байдгийг дараах эцэг эхчүүд болон удирдагчид нээж олсон ажээ.

Украины Вячеслав Гулко, Зоя Гулко нар Сүмийг сонирхож эхлэхэд тэдний 13 настай охин Кира дуртай байсангүй. Тэр номлогчийн хичээлүүдэд оролцохоос татгалздаг байсан төдийгүй ахлагч нарыг ирэхэд “өрөөнийхөө хаалгыг зориуд хаадаг байсан” хэмээн ээж нь ярилаа.

Гулко ах, Гулко эгч хоёр Сүмд элссэнийхээ дараа Кирад Сүнсийг мэдрэх боломж олгох хэрэгтэй, тэгвэл түүний зүрх сэтгэл өөрчлөгдөх болно гэж үзжээ. Гулко эгч өөр хүний баптисмд оролцох үедээ гэрчлэлийг анх олсон учраас *охиноо* өөрийнхөө баптисмд урьж, баптисмын дараа хуурай хувцас сольж өмсөхөд туслахыг түүнээс хүссэн ажээ. Кира зөвшөөрсөнд Гулко эгч гайхсан гэнэ.

“Бидний бодсоноор болсон шүү! Тэнгэрлэг Эцэг маш гайхалтай арга замаар ажилласан” хэмээн Гулко эгч хэллээ. Кира

Сүнсийг *мэдэрч*, аав, ээж хоёрынхоо баптисмаас хойш долоо хоногийн дараа номлогчидтой уулзахыг зөвшөөрсөн гэнэ. Тэр Мормоны Номыг уншиж эхэлжээ. Хэдэн долоо хоногийн дараа Гулко эгч Кирагийн ширээний дээгүүр нэг жижигхэн цаас өлгөөтэй байхыг харжээ. Түүн дээр 2 Нифай 2:25-ын үгсийг бичсэн байв. Гулкогийнхан баптисм хийлгэснээсээ хойш хоёр сар хагасын дараа охиныхоо баптисмд оролцжээ. Өдгөө хорин жилийн дараа Кира гэрлэсэн ажээ. Кира нөхөр Дейвтэйгээ ариун сүмд холбуулж, тэд хоёр хүүтээ сайн мэдээгээр өсгөн хүмүүжүүлж байна. Тэр нэлээд олон дуудлагад итгэлтэйгээр үйлчилсэн бөгөөд Сүмд идэвхтэй хэвээр байна.

Насан туршдаа Сүмийн гишүүн байгаа эцэг эхчүүд бас өөр шигээ болон нөхөр шигээ шинэ гишүүд аль аль нь хэрэглэж болох нэн чухал нэг сургамжийг Зоя энэ туршлагаасаа авсан нь: Эцэг эхчүүд, удирдагчид сайн мэдээг хүлээн авахад нь хүүхдүүдийг албадаж болохгүй, харин сүнслэг туршлагуудыг өөрсдөө мэдрэх газруудад тэднийг урьж, сүнслэг орчныг бүрдүүлж *чадна* гэдгийг нотолжээ. Тэгвэл эдгээр туршлага хөрвөлт рүү хөтлөх болно.

Харин ийм туршлагыг бий болгох хамгийн сайн ямар арга зам байж болох вэ? Дэлхий дахины эцэг эхчүүд болон удирдагчид энэ талаарх туршлагаа хуваалцаж байна.

Өнөө үеийн жишээнүүдийг Бурханы үг болон залуучуудын амьдралтай холбон тайлбарла.



Залуучуудад үйлчлэх боломж олго

Бразилын Сан Паулогийн Котя гадасны Гранжа Виана тойрогт залуу эрэгтэйчүүдийн идэвхийн хувь хэмжээ өндөр байлаа. Гэвч залуусын зарим нь хувийн сорилт бэршээлтэй тулгарсны улмаас санваартны үүргээ биелүүлэх нь хүндрэлтэй байсныг удирдагчид ажиглажээ.

Бишопын зөвлөл, Залуу Эрэгтэйчүүдийн удирдагчид хамтран зөвлөлдөж, үзвэр, зугаа цэнгэлд зориулж олон үйл ажиллагаа зохион байгуулах биш харин үйлчлэлийн төслүүд хэрэгжүүлэхэд илүү их анхаарал төвлөрүүлэхээр шийдсэн ажээ. Эдгээр үйл ажиллагаануудад чуулгын идэвх султай гишүүдийн гэрээр айлчлах, бүрэн цагийн номлогчидтой хамтран номлолын ажилд оролцох, тойргийнхоо гэрээсээ гардаггүй гишүүдэд ариун ёслолыг гүйцэтгэх зэрэг нь орсон ажээ. Эдгээр үйл ажиллагаанууд нь семинар болон ням гарагийн цуглаануудаас сурч мэдсэн зарчмуудынхаа дагуу ажиллаж, амьдрах боломжийг залуу эрэгтэйчүүдэд олгосон ажээ. (2 Нифай 2:26-г үз).

Цаг хугацаа өнгөрөх тусам “эдгээр сүнслэг үйл ажиллагаанууд нь өөрчлөлтөд хүргэсэн юм” хэмээн санваартны нэг удирдагч хэллээ.

“Мацгийн нэг ням гарагт манай бүх залуу эрэгтэйчүүд гэрчлэлээ хуваалцсан нь гайхалтай үйл явдал байлаа” хэмээн тэр ярих. “Тэд ийнхүү гэрчлэлээ хуваалцах үед тэднээс олных нь нүдэнд нулимс хурж, үйлчлэлээс мэдэрсэн сүнсийг гэрчилсэн юм. Гурван жил хэвтэрт байгаа тойргийнхоо өндөр настай нэг гишүүнд ариун ёслол гүйцэтгэсэн тухай туршлагаа нэг залуу эрэгтэй хуваалцжээ. Тэр хүний эхнэр, итгэлтэй эгч залуу эрэгтэйчүүдийг баяр баясал, итгэл найдвар өвөрлөн хүлээн авчээ. Тэр эмэгтэй хэдийгээр өөрт нь хүндрэлтэй олон асуудал, сорилт бэрхшээл тулгарсан ч сайн мэдээний ачаар амьдралд нь ирсэн аз жаргалыг ариун ёслолын дараа хуваалцсан ажээ. Тэд бүгд Сүнсийг мэдэрч, сайн мэдээ хүмүүсийн амьдралд өөрчлөлт гаргадгийг ойлгожээ. Тэд энэ үйл явдлыг олон жил, магадгүй насан туршдаа мартахааргүйгээр тийм хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн байлаа.”

“Хөл бөмбөгийн ямар ч тоглолт, Мючелийн ямар ч хөгжилтэй үйл ажиллагаанаас би ийм их сүнслэг хариу үйлдлийг хараагүй хэмээн тэрээр хэллээ. Энэ үйл явдал нь залуучууд Сүнсийг мэдрэх туршлагуудыг урамшуулан дэмжих нь хэчнээн чухал болохыг түүнд заасан юм гэж хэллээ.

“Нийгэм олон нийтийн үйл ажиллагаанууд чухал. Гэвч сүнслэг туршлагууд нь залуучуудад гэрчлэлээ төлөвшүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой хэмээн тэр цааш нь ярилаа.”

Францын Ангерс гадасны Реннес тойрогт Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхийлөгч ням гараг бүр ариун ёслолын цуглаанд ирсэн залуу эмэгтэй бүрд ил захидал тарааж, сүмд ирээгүй үе тэнгийнхээ нэг эмэгтэйг сонгож, түүнд зурвас бичихийг хүсдэг байжээ. Ил захидал хүлээж авсан залуу эмэгтэйчүүд тэр долоо хоногийн хичээлээр сурч мэдсэн буюу сүнслэгээр нөлөөлсөн зүйлсийн тухай нөхөрсгөөр бичдэг байжээ. Түүний

Амьд болон эртний бошиглогчдын үгсийг ашиглан заа.

зөвлөхүүдийн нэг Леторт эгч сүмд ирээгүй хүмүүст ил захидлыг шуудангаар явуулдаг байв.

Энэ үйл ажиллагаа энгийн ч гэсэн, цуглаанд ирээгүй хүмүүст тэднийг санаж байгаагаа илэрхийлэх арга зам болдог төдийгүй бас зурвас бичиж байгаа хүмүүс бусдадаа туслах, бие биедээ санаа тавих нэг хэлбэр болдог гоороо үр өгөөжтэй юм.

“Өчүүхэн зүйлс агуу гайхамшгуудыг авчирдаг шүү дээ” хэмээн тэр ярилаа (Алма 37:6-г үз). “Ийнхүү гайхамшиг тохиохыг бид харсан. Залуу эмэгтэйчүүд урамшиж, энэ туршлага тэдний гэрчлэлийг өсгөхөд хувь нэмрээ оруулсан юм.”

Залуучуудад Бурханы үгийг таниул

Бурханы үгийг номлох нь хүчирхэг нөлөө үзүүлдгийг Алма заасан байдаг (Алма 31:5-ыг үз). АНУ-ын Техас дахь Залуу Эрэгтэйчүүдийн удирдагч Давид Элмер Алмагийн заасан зүйлийг мэддэг байсан бөгөөд өөрийн удирдагч залуу эрэгтэйчүүдийг ирээдүйд бэлтгэхэд нь тусалсан Скаутын сонирхолтой, үр өгөөжтэй аяллыг зохион байгуулжээ.

Элмер ах хуваалцах зүйлийнхээ талаар залбирч үзэхэд, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл Л.Андерсенгийн хэлсэн үгийг хуваалцахад сүнсээр чиглүүлэгдсэн ажээ. Элмер ах аяллын үеэр тэр захиаснаас Шинэ Зеландын рагбийн од Сидней Гоингийн тухай Ахлагч Андерсены ярьсан түүхийг заасан ажээ. “Бусдыг Христэд авчран тэднийг Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд туслах нь таны ариун үүрэг хийгээд эрхэм боломж байх болно” хэмээн Ахлагч Андерсен хэлжээ.¹

Тэрээр амьд бошиглогчийн үгсээс заасан учир энэ туршлага их хүчтэй нөлөө үзүүлсэн юм гэж Элмер ах ярилаа. Онцгой цугларалтын төгсгөлөөр бүх залуу эрэгтэйчүүд, тэдний удирдагчид номлолд үйлчлэх хүсэлт болон өөрсдийнхөө сурч мэдэрсэн зүйлийн сануулагч болгон ригбийн бөмбөгөн дээр нэрээ бичиж гарын үсгээ зурсан гэнэ. Эцгүүд болон удирдагчдаас олонх нь номлолд үйлчилсэн нь амьдралд нь хэрхэн нөлөөлсөн тухай залуу эрэгтэйчүүдтэй ярилцан, тэр шөнө унтаагүй ажээ.

“Амьд Бурхан биднийх. Тэрбээр Өөрийн залуучуудыг мэддэг” хэмээн Элмер ах хэллээ. “Бурхан тэдний амьдрал болоод тэдэнд одоо тохиолдож байгаа бас ирээдүйд тохиолдох зүйлсийг мэддэг. Тэр тэдний амьдралд хэрхэн нөлөөлдгийг бид хэзээ ч мэдэхгүй. Тиймээс удирдагчид бид залуучууддаа Сүнсийг мэдэрэх орчин, нөхцөлийг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Бид



судруудаар бас бошиглогчдын үгсээр дамжуулан Сүнсийг мэдрэх орчныг бүрдүүлж чадна. Гэвч тэдний зүрх сэтгэлд нөлөөлөн тэднийг өөрчилдөг нь бид биш Их Эзэн юм.”

Тууштай бай

Залуу эрэгтэйчүүдэд аялаас өөр ямар нэг зүйл, тухайлбал, сайн мэдээ судалснаас мэдсэн ямар нэг зүйл санаанд нь үлдэх ёстой.

“Тэднийг Сүнсийг мэдрэх туршлагатай болгох нь миний үүрэг хариуцлагын нэг хэсэг гэж би боддог. Иймээс хэрэв би үүргээ биелүүлэхийг хүсдэг бол үүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх ёстой” гэж тэр хэллээ. “Бид гэр орондоо сүнслэг байдлын загварыг, судар судлах, залбирах болон гэр бүлийн үдшийн загварыг хэрхэн бий болгох тухай Ахлагч Давид А.Беднар заасан юм.² Долоо хоног дуусахад бид сүнслэг байдлын загвараа цааш нь тасралтгүй үргэлжлүүлдэг байлаа. Бид бүлгээрээ залбирдаг байсан. Бас өглөөний 10 минутын онцгой цугларалтаар гэрчлэлээ хуваалцах залуу эрэгтэйчүүдийг томилдог байсан ба тэдний удирдагчид болон эцгүүд оройн онцгой цугларалтыг бэлтгэдэг байв.

“Бид гэрээсээ хол, үйл ажиллагаа нь ердийнхөөс өөр байсан ч сүнслэг байдлын загвараа таслалгүй

Өдөр тутмын үйл ажиллагаануудаас заахад нэн тохиромжтой хормуудыг олж чаддаг бай.



үргэлжлүүлсэн нь бүхнээс илүү чухал байлаа. Залуу эрэгтэйчүүд аль нэг буюу хэсэг хичээлийг онцгойлон санахгүй байж болох юм. Харин тэд онцгой цугларалтуудыг хэрхэн зохион байгуулж, хэрхэн залбирч, судар судалж байснаа мартахгүй гэдэгт би итгэдэг.”

Филиппиний Мира Бокобо Гарсия бас сайн мэдээг тогтвортой судлахын үнэ цэнийг, үүнийг гэртээ заахын ач холбогдлыг мэддэг. Гарсия эгч түүний нөхөр Эдвин хоёр 8-22 насны гурван хүү, зургаан охинтой бөгөөд тэд бүгдээрээ ашиг тустай өөр өөр үйл ажиллагаануудад оролцдог ажээ. Энэ гэр бүлээс олон хүн өөр өөр газарт янз бүрийн үйл ажиллагаанд оролцдог болохоор тэд оройн хоол идэхдээ хамт байхыг их хичээдэг ажээ.

“Хоолоо хамт хөгжилдөн бэлтгэж, хийсэн хоолоо хамт идэх нь бидний хувьд хүүхдүүдээ цуглуулах хамгийн сайн аргуудын нэг юм. Хоолны цаг бол гэр бүлийн гишүүдийн хувьд итгэлээ сэргээх, хоорондоо харилцаж, Их Эзэний адислалуудыг мэдрэх цаг” гэж Гарсия эгч хэллээ.

Заах, сонсох боломж бүрийг алдалгүй ашигла

Эдүгээ 20-30 насны зургаан хүүхдээ өсгөн хүмүүжүүлснээс миний авсан хамгийн чухал сургамж бол тэдэнд зөвхөн шууд заах төдийгүй харин хүүхдүүд үнэнийг өөрөө олж мэдэх орчныг бүрдүүлэх хэрэгтэй юм байна гэдгийг мэдсэн явдал хэмээн Канадын Нова Скотиягийн Жозелин Фиелден ярьж байна.

“Хүүхдийнхээ өмнөөс сонголт гаргаж, тэдний бүх асуултуудад хариулах гэж яарсны хэрэггүй. Ингэхийн оронд хүүхдүүдийг удирдамж, хариултуудыг судрууд болон бошиглогчийн зөвлөгөөнөөс эрж олоход чиглүүлэх хэрэгтэйг” тэрээр зөвлөж байна. “Харин тэдний олж мэдсэн зүйлийн талаар ярилцахад бэлэн бай” хэмээн тэр цааш нь санал болгожээ. Түүнээс гадна тэр хүүхдүүдийнхээ асуултыг сонссоны дараа заримдаа “Чи яах хэрэгтэй гэж бодож байна?” хэмээн эргүүлэн асууснаар тэдний асуултанд хариулдаг гэнэ.

“Хүүхдүүд зөв сонголт хийнэ гэдэгт итгэлтэй бай” гэж тэр хэллээ. “Бид өдөр бүр хүүхдүүдтэйгээ хамт байхдаа тэдэнд амьдралдаа Сүнснийг мэдрэхэд нь туслах олон зүйлийг заах үед мөн тэд Сүнснийг мэдрэх нь ямархуу байдгийг мэддэг болох үед тэд илүү их сүнслэг туршлагуудыг эрэлхийлж, Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёрын үнэн бодит байдлын тухай гэрчлэл нь бэхжих болно. “Энэ нь мэдэгдэхүйц үр дүнд хүргэдэг. Тэд Сүнсний авчирдаг гэрэл ба тайтгарлыг хэдийчинээ их мэдрэх тусам түүнийг төдийчинээ ихээр хүсч, амьдралд нь Сүнснийг элбэг дэлбэг байлгах зүйлсийг хийхийг хичээх болно.”

Тэрээр гэр бүлийнх нь амьдралд үр өгөөжөө өгсөн болон Сүмийн удирдагчдын дахин давтан заадаг зарчмуудын ач холбогдлыг онцлон тэмдэглэж байлаа. Жишээ нь, эцэг эхчүүд гэр бүлийн үдэш, гэр бүлээрээ судар судлах, гэр бүлийн залбирал зэрэг албан ёсны ярилцлагаас гадна Сүнсний удирдамжийн дагуу хэзээ зааж болохыг ажиглан харж, хүүхдүүддээ олон хэлбэрээр зааж болно.³

“Зугаалгаар явган явах, үйл ажиллагаанд оролцохоор машинаар явах, сагсан бөмбөг

Би сайн мэдээнд хэрхэн бат бөх итгэлтэй байсан бэ?

Туа Рожерс

Би 12-той байхдаа баптисм хүртсэн бөгөөд олон жилийн турш гэр бүлээсээ цорын ганц Сүмийн гишүүн байлаа. Гэрийнхнээсээ ганцхан Сүмийн гишүүн байна гэдэг амаргүй байсан ч аз болж би сайн мэдээний сургаалуудыг ойлгож мэдэх болон итгэлээ бэхжүүлж, амьдралаа өөд татах үйл хэрэгт эдгээр сургаалуудыг ашиглахад тусалсан сайн удирдагчдаар адислагдсан юм. Итгэл бишрэлдээ чин үнэнч байхаар шийдсэнийхээ ачаар би өөрийнхөө амьдралд бас нэлээд хожуу гэр бүлийнхээ гишүүдийн амьдралд агуу адислалууд ирэхийг харсан билээ.

Бат бөх итгэлтэй хэвээр үлдэхэд надад тусалсан зарим зүйлийн тухай өгүүлбэр:

- Залбирал, судруудыг өдөр бүр судлах зэрэг үйл ажиллагаануудаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэй ойр бай. Тэрбээр бидний нөхцөл байдлыг сайн мэддэг. Түүнд ойр байсан нь би хэн бэ гэдгээ санахад надад тусалсан юм.
- Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дага. Бошиглогчид, төлөөлөгчдийн зөвлөгөө үнэн гэдгийг би өөрийнхөө амьдралд харж, мэдэрсэн хүн.
- Сайн мэдээгээр амьдрах нь энэ амьдралд ч, ирэх амьдралд ч амьдралыг илүү сайн болгоно гэдгийг ойлго. Энэ нь итгэлтэй хэвээр байж, жишгүүдээ

дагахад надад тусалсан юм. Удирдагчид намайг ариун сүм явахад дэмжсэн нь мөнх амьдралын тухай ойлголттой болоход надад тусалсан.

- Жишгүүдийг тань хуваалцдаг сайн найз нөхдөөр өөрийгөө хүрээлүүл. Зөв шийдвэр гаргахад нөлөөлдөг бөгөөд итгэлтэй байхад надад тусалсан сайн найз нараар би адислагдсан билээ.
- Гэр бүлийн гишүүдтэйгээ ойр дотно бай. Би гэрийнхнээ хайрлаж, тэдэнтэй илүү ойр дотно харилцаатай байхыг хүсдэг байлаа.
- Амьдарсан шиг амьдар. Жишгүүдийг чанд дагаж, Сүмийн хөтөлбөрүүдэд оролц. Эдгээр нь итгэлээ ашиглаж, үргэлж зөв сонголт хийхэд тань туслах болно. Зөв сонголт амьдралыг үргэлж аятай сайхан, илүү аз жаргалтай болгодог.

тоглох, гэр бүлээрээ хоол идэх, хамт ажиллах, дуулах, бусдад үйлчлэх зэрэг нь бидний хувьд гэр орондоо сайн мэдээг заах олон боломжуудаас цөөхөн нь юм” гэж тэр ярилаа. “Бусад үйл ажиллагаануудад оролцох үед сайн мэдээний сэдвүүдээр ярилцах боломж бидэнд байнга олддог.”

Нийтийн зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажилла

Ка Ян Данис Мок Хавай дахь Бригам Янгийн Их Сургуулийг төгсөөд удалгүй Хонг Конг дахь гэртээ эргэж ирэн Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн дуудлага хүлээн авчээ. Тэр гэртээ ирж, ажил төрөлтэй болж, хичээл номоо үргэлжлүүлэн үзэж байх үедээ хамт ажилладаг залуу эмэгтэйчүүддээ ирээдүйн амьдралдаа бэлтгэхийн тулд гэрчлэлээ хөгжүүлэхэд нь туслах сүнс-лэг нөлөөний төлөө чин сэтгэлээсээ залбирдаг байлаа.

Мок эгч нэг ням гарагт мөнх амьдралын тухай заах үедээ тэр өдөр сүмд ирсэн цорын ганц эмэгтэйтэй хамт Мормоны Номыг унших хэрэгтэй гэсэн сүнсний өдөөлтийг мэдэрсэн гэнэ.

“Би нэг зөвлөхийнхөө хамт нөгөөх залуу эмэгтэйтэй хамт нэг баг болж, Мормоны Номыг уншиж дуусгах зорилгыг тэр даруй тавьж билээ. Бид тэр зорилгыг хамтдаа биелүүлж чадна гэдэгт нөгөөх залуу эмэгтэй эргэлзэхгүй байсан учир бидний саналыг хүлээн зөвшөөрсөн юм.”

Тэр үеэс хойш Мок эгч, түүний нэг зөвлөх, нөгөөх залуу эмэгтэй гурав Facebook-т “найз нарын хуудсыг нээж,” мессежээр дамжуулан сурч мэдсэн зүйлээ хуваалцахын тулд уншсан зүйлийнхээ тухай бие биедээ мэдээлдэг болжээ.

Судруудыг хичээнгүйлэн судалсны үр дүнд сайхь залуу эмэгтэйн амьдралд гайхалтай өөрчлөлт гарсныг би харсан хэмээн Мок эгч ярилаа. Мок эгч цахилгаан галт тэргээр ажилдаа очих замдаа өдөр бүр судар уншдаг байснаас олон адислал хүлээн авсан ажээ. “Би бас Сүнснийг мэдэрч, залбиралдаа хариу хүлээн авдаг байсан учир мөнх амьдрал өөд үргэлж урагш ахиж байлаа” хэмээн тэр ярилаа.

“Зарим залуучууд бусдын адил гэрчлэлтэй болж чадах болов уу хэмээн санаа зовж, өөртөө итгэлгүй байдлыг би өөрийн туршлагаас мэднэ” гэж тэр цааш нь ярьсан. “Бид хамтдаа нэг зорилгын төлөө ажилласнаар бие биенээ алхам тутамдаа дэмжиж, амжилтад хүрч чадна гэдэгт итгэлтэй байлаа.” ■

ЭШЛЭЛ

1. Нийл А.Андерсен, “Preparing the World for the Second Coming,” *Лиахона*, 2011 оны 5-р сар, 50.
2. Давид А.Беднар, “More Diligent and Concerned at Home,” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 17–20.
3. Жишээ нь, Роберт Д.Хейлс, “Our Duty to God: The Mission of Parents and Leaders to the Rising Generation,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 95–98; Давид А.Беднар, “More Diligent and Concerned at Home,” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 17–20-ийг үз.



Ахлагч
Паул Б.Пайпер
Далын

АЛМАГИЙН НОМ: ӨНӨӨ ҮЕИЙН СУРГАМЖУУД

Нифайчууд өөрийнхөө үеийн хүнд сорилтуудыг итгэлээр даван туулсан бөгөөд манай өнөө үеийн сорилт бэрхшээлүүдийг амжилттай шийдвэрлэхэд бидэнд хэрэгтэй адислалууд хийгээд хамгаалалтаар Их Эзэн биднийг хангах болно гэдгийг нотлон харуулсан юм.

Хаан Мозая хэмжээгүй эрхэт хаант засгийг хүмүүсийн сонгосон шүүгчдийн тогтолцоогоор солих саналыг хаанчлалынхаа төгсгөлд дэвшүүлжээ. Түүний санал болгосон засаглалын тогтолцоогоор хүмүүсийн сонгосон шүүгчид төрийн хэргийг Бурханаас өгөгдсөн хуулиуд дээр үндэслэн удирдан явуулах ёстой байлаа.

Санал болгосон тогтолцооны үндэс суурь нь сонгох эрхийн зарчим бөгөөд хуульд нийцүүлэн ажиллах үүрэг хариуцлагыг хаан биш харин хувь хүмүүс хүлээх ёстой байлаа. “Хүмүүсийн санал зөв зүйлийн эсрэгийг хүсэх нь нийтлэг биш байдаг” (Мозая 29:26) учраас энэ тогтолцоо хувь хүмүүсийн эрхийг болон нийгэм дэх шударга ёсыг бүхэлд нь хамгаалах боломжийг олгох байв.

Мозаягийн саналд хүмүүс хариулахдаа “бүх нутаг даяар хүн бүр адил тэгш эрхтэй байхад үлэмж догдолж байв; тийм ээ, мөн хүн бүр нүглүүдээ хариуцахад бэлэн буйгаа илэрхийлэв” (Мозая 29:38).

Алмагийн ном нь санал болгосон

засаглалын тогтолцоог хүмүүс хүлээн зөвшөөрснөөс хойших 40 жилийн хугацаан дахь ард түмний түүхийг агуулдаг. Алмагийн цэдгийн сүүлчийн бүлгүүд болох 43-62-р бүлгүүд нь хүнд сорилт бэрхшээлүүд газар аван тэлсэн үеийн тухай өгүүлдэг. 19 жилийн богинохон хугацаанд ард түмэн дотоодын улс төрийн тэмцэл, гадны аюул заналхийлэлтэй тулгарч, зэвсэгт мөргөлдөөн байнга гарч байлаа.

Удирдагчдаа өөрсдөө сонгох болон чөлөөтэйгөөр шүтэн бишрэх ард түмний эрхийг үгүй болгож, хаан болохыг хүссэн хүмүүс засаглалын тогтолцоонд дотроос нь хоёр удаа аюул занал учруулжээ. Энэ цаг үед мөн нифайчуудын төр засгийг устгаж, тэднийг боолчлохоор улайран тэмүүлсэн леменчүүдийн дараалсан олон довтолгооноос ард түмэн өөрийгөө хамгаалах шаардлагатай байлаа.

Эдгээр олон сорилт бэрхшээлийн үед эдийн засгийн хөгжил саарсан тухай тусгайлан дурдаагүй боловч эдийн засаг нь



Шударга нифайчууд сорилт бэрхшээл тулгарсан үед зөв зорилгын төлөө тэмцэж байснаасаа хүч чадлыг олдог байжээ. Тэдний цорийн ганиц хүсэл нь “гэр орон, газар нутаг, төр улс, эрх чөлөө, шүтэх шашин, мөн өөрсдийн амиа” чандлан хамгаалахад оршсон ажээ.

хүмүүст сүрхий дарамт болж байсан бололтой. Мормон энэхүү ариун цэдгийг эмхтгэхдээ энэ үеийн тухай нэн тодорхой өгүүлсэн шастир үлдээхийг зорьсон ажээ. Хэрэв тэрээр нифайчуудын үлдсэн 1,000 жилийн түүхийг мөн тийм байдлаар нарийвчлан өгүүлсэн бол Мормоны Ном 2 000 гаруй хуудастай болох байсан биз ээ!

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994) сургасан нь:

“Мормоны Номыг. . . бидний өдрүүдэд зориулан бичсэн юм. Эртний нифайчууд, леменчүүд аль алинд нь энэ ном байгаагүй. Энэ номыг бидэнд зориулан бичсэн юм. . . . Бүх зүйлийг эхлэлээс хардаг Бурханы сүнсний нөлөөн дор [Мормон] хэдэн зууны цэдгийг товчлон, бидэнд хамгийн чухал үй олон түүх, хэлсэн үгс, үйл явдлуудаас сонгон авч товч хураангуйг хийсэн ажээ. . . .

“Их Эзэн юуны учир үүнийг цэдэгтээ оруулахад Мормонд (эсвэл Моронайд болон Алмад) сүнслэгээр нөлөөлсөн юм бол? Энэ эрин үед амьдрахад туслах зүйлээс би ямар сургамж авч болох вэ?” гэж бид өөрсдөөсөө байнга асууж байх ёстой.”¹

Дээр дурдсан Нифайчуудад тулгарч байсантай адил олон сорилт бэрхшээл, түүний дотор шүтэн бишрэх болон амьдарч байгаа нийгмийнхээ тулгамдсан асуудлуудын талаар үгээ хэлэх эрхийг нь нийгмийн гишүүдэд үгүй болгох гэсэн оролдлого өнөөдөр дэлхий даяарх Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд тулгарч байна. Хожмын Үеийн зарим Гэгээнтнүүд гаднаас дайрч довтолон, улс үндэстнийг нь болон эрх чөлөөг нь устгахаар заналхийлж байгаа хүчнүүдийн аюул заналыг мэдэрч байна.

Азаар нифайчууд тулгарсан сорилт бэрхшээлүүдийг ер бусын хүч чармайлт, золиослол, Их Эзэний тусламжтайгаар даван туулсан юм. Тэд сорилт бэрхшээлүүдийг хэрхэн амжилттай туулсан тухай зарим сургамж нь өнөө үед тохиолдож байгаа сорилтуудыг шийдвэрлэх удирдамж болон зоригийг бидэнд өгч болно.

1. Зохистой хүсэл, зөв учир шалтгааныг удирдлага болго.

Зөв шударга нифайчууд бүхий л сорилт бэрхшээлийн үед зөв зорилго, учир шалтгаанаас хүч чадлыг олдог байлаа. Тэдний чинхүү зорилго бол “өөрсдийгөө мөн гэр бүлээ мөн газар нутгаа, эх орноо, эрхээ, мөн шашин шүтлэгээ хамгаалах” (Алма 43:47) явдал байлаа. Тэдний хүсэл бол зөв шударга байдалд үйлдэх эрх болох сонгох эрхээ хамгаалах, хаан тэдний үйл хэргийг тодорхойлох биш харин өөрсдөө үүнийгээ хариуцах явдал байлаа. Тэдний ингэх учир шалтгаан нь хуулийн өмнө бүгд адил тэгш байж, ялангуяа Бурханыг шүтэн бишрэх эрх чөлөө болон

сүмээ хадгалж үлдэх явдал байлаа (Алма 43:9, 45-ыг үз).

Хувийн ашиг сонирхлын зорилгоор эрх мэдэл, хүч нөлөөтэй болохын тулд олон нийтийн санаа бодлыг төөрөлдүүлэхийг хичээдэг хүчнүүд нийгэмд байдаг мөн байсаар байх болно. Тэдний энэхүү санаархлыг эрх мэдлийн төлөөх тэмцэл, зөрчил сөргөлдөөн болгон хувиргах уруу таталт тохиолдож болно. Их Эзэний зам бол нифайчуудынхтай адил ямагт цэвэр хүсэл эрмэлзэл, учир шалтгаан дээр үндэслэн үйлдэх явдал мөн. Энэ нь тулгарсан сорилт бэрхшээлүүдийг “Их Эзэний хүчээр” (Алма 46:20; мөн Алма 60:16; 61:18-ыг үз) даван туулахын тулд тэнгэрийн хүчин дээр тулгуурлах боломжийг тэдэнд олгожээ.

Үүн лүгээ адил өнөөдөр бидэнд тулгарч байгаа сорилт бэрхшээлүүдэд бид хариу үйлдэл үзүүлэхдээ хүсэл эрмэлзэл, учир шалтгаанаа цэвэр ариун байгааг мөн эдгээр нь Есүс Христийн сайн мэдээн дээр үндэслэж байгаа эсэхийг зүрх сэтгэлдээ байнга шалгаж байх ёстой. Хэрэв бид амин хувиа хичээсэн үзэл бодлын үүднээс, хувийн ашиг сонирхлыг эрхэмлэн үйлдэх (мөн бусдыг үүнд түлхэх) буюу бусдыг дорд үзэх юм бол тулгарсан сорилт бэрхшээлүүдийг даван туулахад хэрэгтэй тэнгэрийн тусламжийг авч чадахгүй.

2. Ядуус, тусламж хэрэгтэй хүмүүст өгөөмөр, сайн сэтгэлээр ханд.

Тэдний хуучин дайсан Антай-Нифай-Лихайн хүмүүсийг устгахаар заналхийлэхэд нифайчууд тэдэнд амьдрах газар олгож, амьдралаа шинээр төвхнүүлэхэд нь туслан, тэднийг хамгаалах санал тавьж байв (Алма 27:21–22; 43:11–12-ыг үз). Антай-Нифай-Лихайчууд дайны зэр зэвсгээ хэзээ ч дахин агсахгүй хэмээн андгай тангараг өргөсөн учир энэхүү эгзэгтэй хүнд үед нифайчуудын их цэрэгт туслахын тулд “өөрсдийнхөө хөрөнгөний ихээхэн хэсгийг” (Алма 43:13) гаргаж өгчээ. Тэрслүү үзлийг дэврээж, хутган үймүүлэхийг хүсдэг хүмүүс эдгээр цагаачдыг улс төрийн зорилгоор амархан ашиглаж болох байсан ч нифайчууд тэднийг хайрлаж, хүндэлдэг байснаас өөр ямар нэг зүйл тэмдэглэгдэж үлдээгүй ажээ.

Нифайчууд Аммоны хүмүүс хэмээн нэрлэгддэг байсан хүмүүст ч ийм байдлаар хандсан юм. Тэд хариуд нь нифайчуудад хүндэтгэлтэй хандаж, эцэстээ 2 000 залуу дайчин хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн, хамгийн их сүнслэг цэргийн ангийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсан билээ. Эдгээр залуу эрчүүдийн хүчин зүтгэл Нифайчуудын нийгмийг арай эрт устгагдахаас хамгаалан үлдэхэд гол үүрэг гүйцэтгэсэн байж болох юм.

Дотоодын зөрчил сөргөлдөөн, гадны довтолгоо,



Нифайчууд тусламж хэрэгтэй хүмүүст өгөөмөр сэтгэлээр, найрсаг ханддаг байсан нь Нифай үндэстнийг хамгаалан үлдээх болон хүнд хэцүү үед тэд тэнгэрийн адислалуудыг хүлээн авахад чухал хүчин зүйл болсон юм. Нифайчуудын найрсаг харилцаа Аммоны хүмүүст сайнаар нөлөөлж, улмаар 2 000 залуу дайчныг өсгөн өндийлгөхөд хувь нэмрээ оруулсан билээ.

эдийн засгийн хүндрэл бэрхшээлийн үед хүмүүс “өөрсөдтэйгөө адил биш” үзэл бодолтой хүмүүст үл итгэн, сөргөөр хандаж, шүүмжлэн буруутгах нь элбэг болдог. Хүмүүс тэдний үнэнч итгэлтэй байдал, нийгэм дэх үнэ цэнэ, эдийн засгийн хөгжилд оруулдаг хувь нэмэрт нь эргэлзэж эхэлдэг. Эдгээр сөрөг хариу үйлдэл нь хөршөө өөрийн адил хайрлах ёстой гэсэн Аврагчийн зарлигт харш бөгөөд туйлшрал, зөрчил сөргөлдөөн, салан тусгаарлалтыг бий болгоно. Хэрэв Аммоны хүмүүсийг Нифайчуудын нийгэм хүлээн аваагүй бол тэдний хойч үеийнхний дунд талархал биш, дургүйцэл бий болох байсан биз ээ. 2 000 итгэлтэй дайчдыг төрүүлэхийн оронд хойч үеийнхэн нь холдон хөндийрч, леменчүүдтэй нэгдэж мэдэх байлаа.

Тусламж хэрэгтэй хүмүүст өгөөмөр, нинжин сэтгэлээр хандах хүсэл нь Нифайн үндэстэн хамгаалагдан үлдэхэд чухал хүчин зүйл болсон бөгөөд хүнд хэцүү үед тэнгэрийн адислалуудыг хүлээн авах эрхээр тэднийг хангажээ. Бурханы хүмүүст өнөөдөр ийм адислалууд хэрэгтэй байна.

3. Сүнсээр нөлөөлөгдсөн удирдагчдыг сонсож, дага.

Нифайчуудад тулгарч болох сорилт бэрхшээлүүдийг Их Эзэн мэдэж байсан бөгөөд тэдгээрийг даван туулахад нь туслах сүнсэлг удирдагчдыг өсгөн өндийлгөсөн билээ. Ахмад Моронай дайчин эр байсан төдийгүй өөрийн хүмүүсийг хамгаалахын тулд цээжний хуяг, гарын хаалт, дуулга, зузаан хувцас бэлтгэхэд сүнсэлгээр нөлөөлөгдсөн ажээ (Алма 43:19-ийг үз). Үүний ачаар нифайчууд леменчүүдийг бодвол тулалдаанд бага хохирол амсчээ (Алма 43:37–38-г үз). Хожим нь Моронай хотуудаа тойруулан өндөр шороон далангууд босгож, далангуудын орой дээр бат бөх, өндөр гуалингуудаар хана барьжээ (Алма 50:1–3-ыг үз). Сүнсээр нөлөөлөгдсөн эдгээр бэлтгэл нь нифайчуудыг устгагдахаас хамгаалж үлдсэн юм.

Моронайг дайнд бэлтгэж байх үед Хиламан болон түүний ах нар Бурханы үгийг номлож, Их Эзэний Сүнс тэднийг удирдаж, хамгаалахын тулд хүмүүсийг зөв шударга байдалд уриалан дуудаж байлаа. Нифайчууд сүнсээр нөлөөлөгдсөн удирдагчдынхаа амьдрал ахуйн болон сүнсэлг удирдамж, зөвлөгөөг анхааран сонссоноор хамгаалагдан үлдсэн билээ. Дотоодын зөрчил сөргөлдөөн газар авч, хүмүүс сүнсэлг нөлөө бүхий сэрэмжлүүлгийг үл тоомсорлосон үед л нийгмийн хөгжилд ухралт гарч, нифайн хүмүүст гай зовлон нүүрлэсэн юм.

Их Эзэн биднийг сэрэмжлүүлж, өнөө үеийн сорилт бэрхшээлүүдэд бэлтгэхээр биднийг удирдахын тулд

амьд бошиглогчид, үзмэрчид, илчлэгчдийг дуудсан үед амьдрахаар адислагдсан хүмүүс билээ бид. 1998 онд Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) Сүмийн гишүүдэд дараах сүнсээр нөлөөлөгдсөн заавар болон сэрэмжлүүлгийг өгчээ:

“Бид амьдрал ахуйдаа дүгнэлт хийн өөрчлөлт гаргах цаг болжээ.

Үй олон хүн цалингаас цалингийн хооронд амьдарч байна. Үнэн хэрэгтээ, зарим хүмүүс өр зээл тавин амьдарч байна. . . .

Эдийн засаг гэдэг эмзэг хэврэг зүйл. . . .Бид ирээдүйд тохиох хүнд сорилт бэрхшээлүүдэд илүү их анхаарах хэрэгтэй байна.”²

Би саяхан Ерөнхийлөгч Хинклийн үгс болон Сүнсний өдөөлтүүдийг анхааран сонссон нэг хүнтэй ярилцсан. Тэр хүн эхнэрийнхээ хамт бизнесээ татан буулгаж, гэр орноо зараад өргүй болсон гэнэ.

Ингэсний хүчинд тэр бие даах чадвартай болсон ажээ. Дараахан нь болсон эдийн засгийн бууралт түүний гэр бүлд маш бага нөлөөлжээ. Харин ч бие даасан байдал нь түүнд болон эхнэрт нь номлолд үйлчлэх боломж олгосон гэнэ.

Ерөнхийлөгч Томас С.Монсон бол бидний энэ үеийн төлөө төрж, өссөн бошиглогч мөн. Түүний амьдрал, сургаал бол өнөө үед биднийг адисалж, хамгаалахаар Бурханы илгээсэн захиас юм. Олон хүн гачигдаж, дутагдсан зүйлийнхээ төлөө санаа нь зовж байгаа үед Ерөнхийлөгч Монсон Их Эзэнээс өгсөн олон адислалын төлөө талархалтай байхыг бидэнд зааж байна. Мөн олон хүн хувийнхаа асуудал дээр хамаг анхаарлаа төвлөрүүлж байгаа үед Ерөнхийлөгч Монсон бусдыг адислахын төлөө өөрийгөө умартан, тэдэнд тусалж, тэднийг аврахыг бидэнд уриалж байна. Ерөнхийлөгч Монсонгийн удирдлаган дор манай гэр бүлүүд өнөө үед хэрэгтэй байгаа сүнсэлг байдлын хамгаалалт болон адислалуудаар хангагдах болно.

Сайн мэдээ сэргээгдсэн үед амьдарч байгаадаа би баярлан талархаж явдаг. Их Эзэн Мормоны Номыг манай өнөө үед зориулж бэлтгэсэнд би талархалтай байдаг. Нифайчууд өөрийнхөө үеийн хүнд сорилтуудыг итгэлээр даван туулсан бөгөөд манай өнөө үеийн сорилт бэрхшээлүүдийг амжилттай шийдвэрлэхэд бидэнд хэрэгтэй адислалууд хийгээд хамгаалалтаар Их Эзэн биднийг хангах болно гэдгийг нотлон харуулсан юм. ■

ЭШЛЭЛ

1. Эзра Тафт Бенсон, “Мормоны Ном бол манай шашны тулгуур чулуу” *Ensign*, 1986 оны 11-р сар, 6.
2. Гордон Б.Хинкли, “To the Boys and to the Men,” *Ensign*, 1998 оны 11-р сар, 53.



*Моронай мэ-
тийн сүнсээр
нөлөөлөгдсөн
удирдагчдын
удирдамж,
зөвлөгөөг сон-
сож, дагаснаар
нифайчууд
хамгаалагдан
үлдсэн юм.
Зөвхөн дотроо
хагралдаж, сүн-
сээр өдөөгдсөн
анхааруулгыг
үл тоомсорлох
үед л тэдэнд
ялагдал болон
зовлон ирдэг
байжээ.*



ДАЙСНЫ ГАЗАР
НУТАГТ ХЭРХЭН


ТЭСЧ ҮЛДЭХ

ВЭ?



**Ерөнхийлөгч
Боид К.Пакер**

Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын Ерөнхийлөгч



Бид Сүмийн семинарын 100 жилийн ойг тэмдэглэж байна. Энэ хөтөлбөр эхэлж байсан эд зүйлсээр хомс тарчиг, шинэ тулгар тэр үеийг эргэн саная.

Тийм даруухнаар эхэлсэн семинарын ангиуд эдүгээ дэлхий даяар 143 оронд 375 008 суралцагч, сайн дурын бүрэн цагийн 38 000 гаруй багштайгаар хичээллэж байна. Бид залуучууддаа их хөрөнгө оруулж байгаа бөгөөд та бүхний үнэ цэнэ, чадавхийг мэднэ.

Дайсныг ялахад мэргэн ухаан тусална

Би өнгөрсөн үеийг сайн мэдэх хүний хувьд бас та нарыг ирээдүйд бэлтгэхийн төлөө үгээ хэлж байна.

Та нар дайсны газар нутагт өсч байна. Та нар сүнслэг байдлын хувьд өсч хөгжсөн үед дайсан өөрсдийн чинь эргэн тойронд хэрхэн шургалан орсныг ойлгох болно. Дайсан гэр оронд чинь, үзвэрийн газрууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэл яриа гээд та нарын эргэн тойронд хаана л бол хаана байж байдаг. Ихэнх тохиолдолд тэр байгаа нь мэдэгддэггүй.

Хамгийн үнэ цэнэтэй бөгөөд хамгийн чухал зүйлсийн талаар би та бүхэнд ярихыг хүсч байна. “Мэргэн ухааны эхлэл болбоос түүнийг олж авах” хэмээн сударт өгүүлсэн байдаг. Харин би үүн дээр, “та нар тэрхүү мэргэн ухаантайгаа ямагт хамт байгун” хэмээн нэмж хэлье. (Сургаалт Үгс 4:7). Би өөрийнхөө болон та нарын цагийг дэмий үрэхийг хүсэхгүй байна. Иймээс анхааралтай сонсоорой!

Багш болохоор шийдсэн тэр хором миний санаанд туйлын тодхон байна. Би Дэлхийн II Дайны үед 20 дөнгөж гарсан, Агаарын Цэргийн нисгэгч байлаа. Манай анги Аие Шима хэмээх жижигхэн арал дээр байрладаг байсан юм. Шуудангийн марктай адилтгамаар энэхүү жижигхэн, өнчин арал Окинава арлын хойд үзүүрээс нэлээд зайдуухан оршино.

Зуны нэгэн уйтгартай орой би нар жаргахыг харан цохио хадан дээр, хэрэв дайнаас эсэн мэнд гэртээ харьвал амьдралаа яаж төвхнүүлдэг билээ хэмээн бодлогоширон сууж байлаа. Намайг ямар мэргэжилтэй болохыг хүсч байсан гэж бодож байна? Тэр орой би багш болохоор шийдсэн юм. Учир нь би багш нарыг үргэлж сурч байдаг хүмүүс гэж боддог байлаа. Үргэлж сурч, мэдэх нь амьдралын зорилго юм.

Би анх 1949 онд ахлах сургуульд байхдаа явдаг байсан Бригам хот дахь семинартаа багшилсан.

Тэр үед семинарт Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ, Сүмийн түүх гурвыг заадаг байлаа. Өглөө эртний семинарын ангид Мормоны Номыг заахаар нэмж оруулсан нь миний хувьд гайхамшигтай хэрэг байсан юм. Би дайнаас эргэж ирэхдээ Мормоны Номын гэрчлэлтэй болсноос гадна Ариун Сүнсний бэлэг хэрхэн ажиллагчийг ойлгодог болсон байв.

Ариун Сүнс та нарыг дайсны газар нутагт байхад тань хамгаалах болно.

Ариун Сүнсний бэлгийн тухай та нар бага наснаасаа эхлэн заалгасан байгаа. Гэвч хүмүүст заах нь тийм ч амар биш. Иймээс та нар Ариун Сүнс удирдах болоод хамгаалах нөлөөтэйг амьдралынхаа туршид, хувийн туршлагаараа нээн илрүүлж чадна, ингэх ч ёстой.

Залуу эрэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдийн хувьд энэхүү үйл явц адилхан юм. Ариун Сүнс амьдралд чинь хэрхэн нөлөөлдгийг нээн илрүүлэх нь насан туршийн эрэл хайгуул юм. Та нар энэхүү нээлтийг өөрсдөө хийж чадвал дайсны газар нутагт амьдарч байгаа ч гэсэн мэхлэгдэхгүй, сүйрэлд хүрэхгүй байж чадна. Ариун сүнсний өдөөлтөөр сэрэмжлүүлэлгүйгээр ноцтой алдаа гаргадаг сүмийн гишүүн

гэж байхгүй. Гишүүн гэдэг чинь та бүгд шүү дээ.

Зарим үед бид алдаа гаргачихаад, өнгөрсөн хойно нь “Ингэж болохгүй, энэ нь буруу гэдгийг уг нь би мэдэж байсан юм” эсвэл “Би ингэх ёстой байснаа мэдэж байсан. Гэвч зориг хүрээгүй юм даа!” хэмээн харамсдаг. Ийм мэдрэмж бол Ариун Сүнс биднийг сайн зүйл рүү чиглүүлж, хор уршгаас холдуулахыг хичээж байгаа нь тэр юм.

Бид Сүнсстэй холбогддог харилцаагаа авч үлдэхийн тулд зарим зүйлсийг огт үйлдэж болохгүй. Жишээ нь, биднийг худал хэлэх, хулгайлах, залилан мэхлэх буюу ёс суртахуунгүй алхам хийх үед Сүнсстэй холбогддог харилцаа буурдаг билээ. Сүнслэг байдалд хохирол учруулах газар руу бүү яв.

Бид өөртөө боломжтой хүч, удирдамжийг эрэлхийлж, түүнийг тууштай дагах ёстой.

“Хийх ёстой” зүйлсийнхээ жагсаалтанд *залбирлыг оруул*. Ихэнх тохиолдолд бид чимээгүй залбирах болно. Та залбирлынхаа тухай бодох хэрэгтэй.

Тэнгэр дэх Эцэгтэйгээ шууд харилцан ярилцах боломжтой. Залбирлыг чинь хэн ч сонсдоггүй гэж итгүүлэх боломжийг дайсанд бүү олго. Залбирлыг чинь Тэнгэрлэг Эцэг үргэлж сонсох болно. Чи хэзээ ч ганцаараа биш.

Бие махбоддоо анхаарал тавьж бай. Цэвэр ариун бай. “Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу?” (1 Коринт 3:16).

Сургаал ба Гэрээний 89-р хэсэг дэх амлалтуудыг анхааралтай унш. Мэргэн Ухааны Үг төгс эрүүл мэндийг амладаггүй ч бидний доторх сүнслэг зүйлийг хүлээн авагчийг хүчтэй болгодог.

Шивээс хийлгэх болон үүнтэй адилаар бие махбодыг чинь гутаах зүйлсээс хол бай. Бидний бие Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн юм.

Бошиглогчийн зөвлөгөө юу үнэн болохыг заадаг

Одоо би өөр нэг асуудлын талаар та нартай илэн далангүй ярилцахыг хүсч байна.

Эрэгтэй, эмэгтэй хүний хүйс нь мөнх бус байдлын өмнөх дэлхийд бий болсныг бид мэднэ.¹ “Сүнс хийгээд мөн бие нь хүмүүний бодгаль бөлгөө” (С ба Г 88:15). Хүйсний энэхүү асуудал бүхэлдээ ёс суртахууны асуудал учраас Ах нар үүнд их санаа тавьдаг.

Та төрөлхийн ийм учраас уруу таталтанд автагдсан бол гэм буруугүй хэмээн та нарын зарим нь боддог эсвэл бусад хүмүүс ингэж хэлэхийг сонссон байж болох юм. Хэрэв бид үүнийг сургаалын хувьд зөв гэж үзэх юм бол бидэнд сонгох эрх хэрэггүй болно. Ийм байж

болохгүй. Ариун Сүнсний өдөөлтүүдийг дагахаар сонгон, ариун журмаар дүүрэн, ёс суртахууны хувьд цэвэр ариун амьдралаар амьдрах сонголт бидэнд ямагт байдаг.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли ерөнхий чуулган дээр дараах байр сууриа илэрхийлсэн юм: “Өөрсдийгөө. . . ижил хүйстэнтэйгээ нөхцөгч буюу лесбичүүд хэмээн нэрлэдэг хүмүүсийн талаарх бидний байр суурийг хүмүүс асууж сонирхдог. Миний хариулт бол бид тэдэнд Бурханы охид хөвгүүдийнх нь хувьд хайртай. Тэд өөр хүсэл сонирхолтой бөгөөд тэр нь их хүчтэй учраас хянахад хүндрэлтэй байдаг биз. Ихэнх хүмүүст өөр өөр үед янз бүрийн [уруу таталт] тохиолддог. Хэрэв тэд тэдгээр зохисгүй шохоорхлоо үйлдэл болгохгүй бол Сүмийн бусад гишүүдийн адил тэд урагш ахиж чадна. Хэрэв тэд Сүмийн ариун явдлын хууль болон ёс зүйн хэм хэмжүүрийг зөрчвөл Сүмийн сахилгыг зөрчигчид болно.

“Бид тэднийг хүчирхэгжүүлж. . . , хүндрэлтэй асуудлаа шийдэхэд нь дэмжин, туслахыг хүсдэг. Хэрэв тэд садар самуун, ёс суртахуунгүй үйл ажиллагаанд орооцолдож, ижил хүйстэнтэйгээ гэрлэх, энэхүү үзэл бодлоо хамгаалах тохиолдолд бид зүгээр хараад суух ёсгүй. Ийм үйлдлийг хүлээн зөвшөөрөх нь Бурханы үндэслэсэн гэрлэлтийн бүхнээс эрхэм, ариун үндэс суурь хийгээд үүний зорилго, гэр бүлүүдийг төлөвшүүлэх үйл хэрэгт хөнгөн хуумгай хандсан хэрэг болно.”²

Ерөнхийлөгч Хинкли энэ асуудлаар Сүмийг төлөөлөн үгээ хэлсэн юм.

Аюулгүй байдлыг олж, түүнийгээ хадгалахын тулд сонгох эрхээ ашигла.

Адам, Ева хоёрын анх хүлээж авсан бэлэг нь сонгох эрх байлаа: “Чи өөрийнхөө төлөө сонгож болно, учир нь энэ нь чамд өгөгдсөн билээ” (Мосе 3:17).

Энэхүү сонгох эрх бидэнд байдаг. Санаанд чинь орж ирсэн ямар нэг зохисгүй, ариун бус зүйл буюу уруу талтанд автагдахгүй байхын тулд сонгох эрхээ ашигла. Тийм газар руу бүү зүглэ. Хэрэв тийм газар нэгэнт орчихсон бол тэндээс түргэн гарч яв. “Бүхий л бурханлаг бус зүйлээс татгалзагтун” (Моронай 10:32).

Өөрийн бие махбод дахь амьдралыг тэтгэгч хүчийг ганцаараа буюу бусадтай нийлэн өөрчлөх гэж бүү оролд. Ингэхгүй байх нь Сүмийн жишиг. Сүмийн жишиг хэзээ ч өөрчлөгддөггүй юм. Та нарыг өсч хөгжихийн хэрээр ёс суртахуунгүй зүйлд сорин уруу татах оролдлого ихсэнэ. Үүнд бүү автагд!

Уруу татагдахгүй байх түлхүүр нь *сахилга* буюу хувийн сахилга юм. *Сахилга* гэдэг үг *шавь* буюу *дагалдагч гэдэг үгнээс гаралтай юм.* Аврагчийн шавь

бөгөөд дагалдагч бай. Тэгвэл бид аюулгүй байх болно.

Биднээс ганц хоёрхон нь “Би ийм ноцтой алдааг аль хэдийн гаргасан гэм буруутай болохоор алдаагаа засах нь оройтсон” хэмээн боддог байж магадгүй. Оройтно гэж хэзээ ч байдаггүй.

Та нар гэртээ болон семинарт Есүс Христийн Цагаатгалын тухай заалгасан байгаа. Цагаатгал нь баллууртай адилхан бөгөөд гэм бурууг эсвэл түүнээс үүдэлтэй гэм буруугийн мэдрэмжийн үр дагаврыг арилгадаг.

Гэм буруу гэдэг бол сүнсний өвчин юм. Сүнсний өвчинд архагших боломжийг бүү олго. Үүнээс зайлсхий. Сүнсний өвчнийг тэр дор нь эдгээ. Шаардлагатай бол наманчил. Дайсан чамайг эрхшээлдээ оруулж чадахгүй болтол дахин дахин бас дахин наманчил.

Байнга наманчилснаар өнө удаан үргэлжлэх амар амгалан ирдэг

Амьдралд сорилт бэрхшээл, алдаа мадаг ээжлэн ирдэг. Хийх зүйлсийн жагсаалтандаа “байнга наманчлах” гэдэг үгийг нэмж бич. Энэ нь дэлхийн ямар ч үнээр худалдаж авч чадахгүй өнө удаан үргэлжлэх амар амгаланг та нарт авчрах болно. Цагаатгалыг ойлгох нь та нарын хувьд насны залууд сурч мэдвэл зохих хамгийн чухал үнэнүүдийн нэг байх ёстой.

Өөрийг чинь өсөн төлөвшихөд сайнаар нөлөөлөхийн оронд уруу татдаг хүмүүстэй нөхөрлөдөг бол тэднээс даруй салж, өөр найз нөхөдтэй бол. Та нар зарим үед ганцаардаж, уйтгарладаг байж магадгүй. “Ганцаараа байгаа үед ч гэсэн бидэнд нэг сайн нөхөр байдаг биш үү?” гэсэн асуултыг өөрөөсөө асуух нь чухал юм.

Өөрийг чинь эрхшээлдээ оруулсан муу зуршлаас салах нь хэцүү байж болно. Гэвч тэрхүү муу зуршлыг үлдэн хөөх хүч та нарт байгаа. Бүү цөхөр. “Бие махбодтой бүх хүмүүс бие махбодгүй тэднийг захирах хүчтэй байдаг” хэмээн Бошиглогч Иосеф Смит сургажээ.³ Бид уруу таталтыг эсэргүүцэж чадна!

Бид дайсантай яг нүүр тулан учрахгүй. Тэр өөрийгөө бидэнд харуулдаггүй. Харин тэр биднийг уруу татаж, сорихоор ирлээ ч гэсэн бид үргэлж давуу талтай байдаг. Хэрэв бид сонгох эрхээ ашиглавал тэр биднийг орхин зайлахаас аргагүйд хүрнэ.

Семинараас ирдэг адислалуудын ашиг тусыг хүрт

Та нар бол эгэл жирийн бус, онцгой, гайхалтай хүмүүс. Би үүнийг яаж мэддэг вэ? Есүс Христийн сайн мэдээ та нарын гэр орон болон Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн сургаал, үйл

ажиллагаануудаар дамжин амьдралд чинь ирэх тийм цаг үе, тийм газарт та нар төрсөн учраас би үүнийг мэддэг юм. Энэ Сүм бол Их Эзэний Өөрийнх нь хэлснээр “бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” (С ба Г 1:30).

Та нар жагсаалтан дээрээ нэмж болох өөр зүйлүүд бий. Гэвч амьдралдаа юу хийх ёстой, юу хийх ёсгүйг та нар мэднэ шүү дээ. Та нар юу зөв, юу буруу болохыг мэднэ. Тиймээс юм болгонд тушаал, заавар бүү хүлээ.

Семинарын жилүүдийг бүү дэмий үр. Сүмийн болон бошиглогчдын сургаалуудыг судалж мэдэхээс ирдэг агуу адислалуудыг олж авах боломжийг бүү алд. Хамгийн үнэ цэнэтэй зүйлсийг сурч мэд. Энэ нь та нарыг болон ирээдүйн олон үеийн үр удмыг тань адислах болно.

Цөөхөн жилийн дараа та нар гэрлэн, үр хүүхэдтэй болж, ариун сүмд гэрлэлтээ лацдан холбуулна. Та бүхнийг цаг нь болоход амьдралд хөлөө олон, тойрог, салбартаа амар тайван амьдрахын төлөө бид залбирдаг.

Итгэл, найдвараар жигүүрлэн урагш тэмүүл

Ирээдүйгээс бүү ай. Итгэл, найдвараар жигүүрлэн урагш тэмүүл. Ариун Сүнсний ер бусын гайхамшигтай бэлгийг санагтун. Үүгээр заалгаж сур. Үүнийг эрэлхийлж сур. Үүгээр амьдарч сур. Есүс Христийн нэрээр үргэлж залбирч сур (3 Нифай 18:19–20-ийг үз). Их Эзэний Сүнтэй нөхөрлөснөөр та бүхэн адислагдах болно.

Бид та бүхэнд туйлын их итгэдэг.

Намайг залуу байхад ирсэн гэрчлэлээ би та бүхэнтэй хуваалцъя. Та нар надтай л адилхан бөгөөд бусдаас юугаараа ч өөр биш юм. Та нар бусдын нэгэн адил энэхүү гэрчлэлийг олж авах эрхтэй билээ. Хэрэв та нар чин сэтгэлээсээ хичээвэл энэ гэрчлэл та нарт ирэх болно. Их Эзэний адислалууд буюу гэрчлэлийн адислалуудыг амьдралд тань байж, аз жаргалтай ирээдүйгээ цогцлон байгуулахад тань та нарыг удирдахад би урьж байна. ■

Семинарын зуун жилийн ойн шууд нэвтрүүлэг дээр 2012 оны 1-р сарын 22-нд хэлсэн үгнээс.

ЭШЛЭЛ

1. “Гэр бүл дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129; мөн Мосе 3:5; Абрахам 3:22–23-ыг үз.
2. Гордон Б.Хинкли, “What Are People Asking About Us?” *Ensign*, 1998 оны 11-р сар, 71.
3. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 211.



Энэ үгийг бүрнээр нь үзнэ үү

Ерөнхийлөгч Пакерын үгийг бүрнээр нь seminary.lds.org/history/centennial-ээс үзэх буюу сонсоно уу.



Семинарын жилүүдийг бүү дэмий үр. Сүмийн болон бошиглогчдын сургаалуудыг судалж мэдэхээс ирдэг агуу адислалуудыг авах боломжийг бүү алд. Хамгийн үнэ цэнэтэй зүйлсийг сур.



БИ ЗОРИГТОЙ БАЙХЫН ТӨЛӨӨ ЗАЛБИРСАН

Манай аав, ээж хоёр Сүмийн гишүүн ч, идэвх султай. Гэр бүлийн цаг бүхнээс илүү чухал, сүмд явах, дуудлагаа сайн биелүүлэх болон бусад үйл ажиллагаанаас илүү чухал гэж аав, ээж хоёр үздэг учраас заримдаа үүнээс болж бидний дунд зөрчил гардаг.

Би Хүүхдийн Хэсэгт удирдагч бөгөөд тойргийн найрал дууны гишүүн учраас Сүмийн цуглаанууд заримдаа миний гэр бүлийн үүрэгт ажилд саад болдог. Нэг өдөр намайг Антананариво дахь цуглааны байранд болох ерөнхий чуулганы шууд нэвтрүүлгийг үзэхээр бэлтгэж байтал, аав ээж хоёр манайд зочид ирчихээд байгааг надад санууллаа.

“Чи гэр бүл, Сүм хоёрынхоо аль нэгийг сонгох хэрэгтэй шүү. Нэг бол чи гэртээ бидэнтэй хамт бай, чуулганд бүү оролц, нөгөө бол чи тэр чуулгандаа яваад шийтгүүлээрэй” гэж ээж надад хатуухан сануулав.

Би ээжтэйгээ ам муруйхыг хүссэнгүй. Тэгэхийн оронд Тэнгэрлэг Эцэгт хандан зориг, хүч чадал өгөхийг бас яах ёстойг мэдэхэд надад туслахыг Түүнээс гуйлаа. Би гэр бүлтэйгээ гэртээ байх уу эсвэл сүмд очиж, бошиглогчийн дуу хоолойг сонсох уу?

Залбирч дуусмагцаа би Ариун

Сүнсийг мэдэрлээ. Чуулганд оролцож, бошиглогчийн үгийг сонсох нь надад хэчнээн чухал болохыг ээждээ тайлбарлах зоригийг Сүнс надад өгснийг би мэдэрсэн. Би өнөөдрийнхөө амьдралын талаар төдийгүй ирээдүйнхээ талаар чухал зөвлөгөө авах болно гэдгийг ээждээ хэлэх ёстойг мэдэрсэн юм.

Бурхан гайхамшгийг үйлдэж чаддаг, тиймээс аав, ээж хоёрын зүрх сэтгэлийг зөөлрүүлж, тэд намайг шийтгэлгүйгээр ерөнхий чуулганд оролцохыг зөвшөөрсөн билээ. Энэ бол миний амьдралд тохиолдсон

Залбирч дуусмагцаа би Ариун Сүнсийг мэдэрлээ. Чуулганд оролцож, бошиглогчийн үгийг сонсох нь надад хэчнээн чухал болохыг ээждээ тайлбарлах зоригийг Сүнс надад өгснийг би мэдэрсэн.

гайхалтай үйл явдал байлаа. Энэ нь “Ариун Сүнсний хүчээр [бид] бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” (Моронай 10:5) гэсэн сударт өгүүлдэг үнэнийг надад батлан харуулсан юм.

Хэрэв бид үйлддээ сайн мэдээний зарчмууд дээр төвлөрүүлж, Сүнснийг сонсох юм бол хийсэн сонголтууддаа үргэлж баяртай байж чадна. Энэ туршлага Бурхан бидэнд тусалдаг, Ариун Сүнс бидний амьдралд тусалдаг тухай миний гэрчлэлийг бэхжүүлсэн билээ. ■
Фи Тианаривело, Мадагаскар



БАЙХ ЁСТОЙ ГАЗРАА ОЛСОН МИНЬ

Сүмд элсэхээс өмнө миний амьдрал золгүй явдлаар дүүрэн байлаа. Аав, ээж хоёр салсны дараа намайг долоон настай байхад аав минь шоронд оров. Ээж минь архинд орж, үнэ цэнэтэй юм бүхнээ алдлаа. Намайг өнчин хүүхэд өсгөн хүмүүжүүлдэг нэг айлд өгөв.

Би эдгээр золгүй явдлуудаас болж үе тэнгийнхнээсээ илүү түргэн өсч том болсон юм. Нийгэмд байр сууриа олж чадна гэдэгт огт итгэдэггүй байснаас би үргэлж уцаартай, цухалдангүй байдаг байлаа. Бүр бага байхаасаа би тамхи татаж, Мэргэн Ухааны Үгэнд харш гэдгийг нь одоо мэддэг болсон бусад зүйлүүдийг хийж эхэлсэн. Би гэдэг хүн амьдралд хөлөө олохоос өнгөрсөн юм шиг санагддаг байлаа.

Гэр орныг нь цэвэрлэж хүмүүст туслах эсвэл амьдралынх нь түүхүүдийг сонсох нь надад баяр баяслыг авчирдаг байлаа. Хүмүүс надад итгэж болно гэдгийг мэддэг байхыг би юунаас ч илүү хүсдэг байлаа. Би нэг жил амралтаараа нэгэн настай эмэгтэйтэй танилцаж, үгийг нь сонсон, түүнд үйлчлэхээр шийдэв. Тэр эмэгтэй Христэд итгэгч байсан болохоор шашны тухай надад яриу.

Би Бурханд ерөөсөө итгэдэггүй байлаа. Бурхан үнэхээр *байж болох юм*, гэвч би амьдралд маань тохиолдсон олон таагүй зүйлд Түүнийг буруутгадаг байв. Гэвч тэр эмэгтэй Бурханд итгэхийн чухлыг тодорхой тайлбарлахад надад сонирхолтой санагдаж эхлэв. Тэр эмэгтэй намайг явахаас өмнө “Мормончууд Бурханы зарлигуудыг дагадаг” гэж хэлсэн нь миний сонирхлыг бүр ч их татлаа.

Мормончуудын тухай би огт сонсоогүй болохоор гэртээ ирээд интернет орж, хайлт хийлээ. Тэгээд би Mormon.org-т орж, үнэгүй Мормоны Номыг захиалав. Хэд хоногийн дараа номлогчид Мормоны Номыг надад авчирч өглөө.

Би Бурханд итгэдэг болно гэдэгтээ төдийлөн итгэхгүй байсан ч зөвхөн Түүнд итгээд зогсохгүй бас Түүнийг мэдэхэд номлогчид надад тусалсан билээ. Мормоны Номыг залбирч, судалдаг болсноор би аз жаргалыг олох, сайхан аянд гарсан юм. Би тамхи татахаа больсон юм. Бурханыг буруутгахаа больж, амьдралд минь өгсөн сайн сайхан зүйлийн төлөө Түүнд талархал өргөдөг болов. Түүний Хүү миний нүглийн төлөө бас миний амссан бүх уй гашуугийн төлөө зовон шаналсныг би мэдсэн. 2007 оны 10-р сарын 28-нд би Сүмд баптисм хүртсэн.

Хэрэв би урам хугаралтаас аз жаргалд хүргэсэн өөрчлөлтийг

биеэрээ туулаагүй бол энэ нь боломжтой гэдэгт итгэхгүй байсан биз ээ. Өнөөдөр би Хүүхдийн Хэсэг дэх дуудлагадаа дуртай. Польшийн ганц бие залуу насанд хүрэгчдийн чуулганы үеэр үйлчлэлийн төсөл зохион байгуулах боломж олдсонд баяртай байна. Есүс Христийн сайн мэдээнээс миний олсон аз жаргал дээр Сүмийн үйлчлэлээр дамжуулан бусдад тогтмол туслах боломж нэмэгдлээ. Би Есүс Христийн ачаар эдүгээ хийдэг бүх зүйлээ цэвэр хайраар хийдэг болсон. Бидэнд сорилт бэрхшээл тохиолдлоо ч хэрэв бид Аврагчийг дагах юм бол алдахгүй, амьдрал сайхан гэдэгт би итгэдэг.

Бурханд итгэх итгэлтэй байх нь туйлын *чухал* гэж миний танилцсан эмэгтэйн хэлсэн нь үнэн байлаа. Хэрэв бид Түүнийг мэдэхгүй бол энэ дэлхийд байр сууриа олж чадахгүй. Эцэстээ би байх ёстой газраа олондоо баяртай байна. ■
Дорота Мюзиал, Польш

Тэр эмэгтэй намайг явахаас өмнө “Мормончууд Бурханы зарлигуудыг дагадаг” гэж хэлсэн нь миний сонирхлыг бүр ч их татлаа.



СҮМИЙНХЭЭ ТУХАЙ БИДЭНД ЯРЬЖ ӨГӨӨЧ

Би ахындаа очихоор аялахдаа Онгоцны үйлчлэгч нарын суудаг арын суудалд сууж явлаа. Тэр хэсгийн хоёр эгнээ суудал өөд өөдөөсөө харсан байлаа.

Би өөрийгөө хамт сууж явсан хүмүүст танилцуулаад Бригам Янгийн Их Сургуульд суралцах тухайгаа дурдлаа. Миний өөдөөс харж суусан хүн охинд нь саяхан бүрэн цагийн номлолд явсан сайн найз бий гэлээ. Охин нь Сүмийн тухай бага сага зүйл мэддэг, харин тэр өөрөө бараг юу ч мэддэггүй гэнэ. Тэгтэл онгоцны үйлчлэгч “тэр сүмд” чинь би л лав элсэхгүй, яагаад гэвэл тэр сүм эмэгтэйчүүдийг ялгаварладаг юм гэнэлээ гэв. Хожмын Үеийн Гэгээнтэн эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс доогуурт үздэг, тэд санваар авч, хурал цуглаан дээр тэргүүлдэггүй, Сүмд эрэгтэйчүүд давуу эрхтэй байдаг тухай сонссон гэж нөгөөх эрэгтэй хэллээ.

Тэгээд тэр над руу эргэж, “Та энэ талаар юу гэж бодож байна?” гэж асуув. Долоон хүн бүгдээрээ над руу харж, юу гэж хариулахыг хүлээв.

Миний дотор пал хийгээд явчихав. Би хүүхэд байхдаа яг иймэрхүү нөхцөлд Итгэлийн Тунхгийг цээжээр хэлэх хэрэгтэй болж байв. Бас арав гаруй насандаа мөн залуу насанд хүрэгч байхдаа Иосеф Смитийн үзэгдэл болон Мормоны Номын тухай гэрчлэлээ хэлдэг байсан. Харин би энэ хүний асуултанд хэрхэн хариулахаа огт мэдэхгүй байлаа. Тэгээд Тэнгэрлэг Эцэгт хандан чимээгүй залбирч удирдамж өгөхийг хүсэв.

Тэгтэл “Та Нийгмийн Халамжийн Бүлгийн тухай мэдэхгүй байгаа нь аргагүй л дээ” гэсэн анхны үгс миний санаанд орж ирлээ. Тэд ч бас энэ тухай юу ч мэдэхгүй болох нь тэдний харцанд илэрлээ.

“Бүх эмэгтэйчүүд гишүүд нь болох Нийгмийн Халамжийн Бүлэгтэй санваартнууд нягт хамтран ажилладаг. Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч эмэгтэй бүх дэлхий даяарх Сүмийн эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг удирддаг. Эмэгтэйчүүдийн үүрэг бол гишүүдийн амьдралд ялангуяа тэдний гэр бүлийн амьдралд хайр, энэрэл, нинжин сэтгэлийг бий болгох явдал мөн” хэмээн би тайлбарлав.

Миний үгийг хүмүүс анхааралтай сонслоо.

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн адил ажиллаж, бодож сэтгэх ёстой гэж зарим эмэгтэйчүүд үздэг

хачирхалтай цаг үед бид аж төрж байна. Харин Бурхан ажил үүргийн зааг ялгааг тогтоосон гэдэгт бид итгэдэг. Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээ удирдагчид байх ёстой, харин гэр бүлээ нөхөртэйгөө хамтран удирдах ёстой гэж бид үздэг. Эрэгтэйчүүд эдгээр асуудлуудад үндсэндээ бидний зөвлөгөөн дээр түшиглэдэг. Энэ нь зөв бөгөөд манай Сүмийн байгууллагуудын ажлыг амжилттай, гэр бүлүүдийг аз жаргалтай болгодог. Иймээс эрэгтэй хүн эмэгтэй хүнгүйгээр бас эмэгтэй хүн эрэгтэй хүнгүйгээр Их Эзэн дотор байдаггүйд бид үнэхээр итгэдэг (1 Коринт 11:11-ийг үз). Эрэгтэй, эмэгтэй хүн дан ганцаараа бүрэн бүтэн байж чадахгүй гэдэгт бид итгэдэг. Биднийг хооронд нь өрсөлдүүлэхийн тулд биш харин нэг нь нөгөөгийнхөө дутууг гүйцээж байхын тулд

“Та Нийгмийн Халамжийн Бүлгийн тухай мэдэхгүй байгаа нь аргагүй л дээ” гэсэн анхны үгс миний санаанд орж ирлээ.



бүтээсэн гэдэгт бид итгэдэг.”

Би үгээ хэлж дуусаад адислагдсанаа мэдэрсэн. Миний хэлсэн үгс Сүнснээс ирсэн гэдгийг би мэдэж байлаа. Хүн бүр миний ярьсан зүйлд сэтгэл ханамжтай байх шиг харагдсан. Тэгтэл нөгөө хүн “Сүмийнхээ тухай бидэнд дэлгэрэнгүй ярьж өгөөч” гэв.

Тиймээс, дараагийн хоёр цагт нь Сэргээлтийн тухай ярьж, хүмүүсийн асуултуудад хариулж, өөрийнхөө дуртай сайн мэдээний тухай гэрчлэлээ баяртайгаар хуваалцах боломж надад олдсон юм. ■

Шауна Мооре, Виржиния, АНУ

НЯМ ГАРАГТ АЖИЛЛАХ УУ ЭСВЭЛ СҮМДЭЭ ЯВАХ УУ?

Эхнэр бид хоёр 1981 онд Японы Токиогийн Ариун сүмд гэрлэсэн. Гэрлэсний дараа бидний амьдрал эхний үед амар байгаагүй. Би ажилтай болсондоо баяртай байсан ч гэр бүлийнхээ зарлагыг нөхөхөд бидэнд бэрхшээл тохиолдлоо. Бид Тэнгэрлэг Эцэгээс тусламж гуйсан бөгөөд

хэрэгцээгээ хангаж, аравны нэгээ төлж чаддаг болохын тулд чадах бүхнээ хийсэн юм. Хэрэв бид Их Эзэнд итгэх юм бол Тэр биднийг хэрэгцээт зүйлсээр хангах болно гэдгийг бид мэддэг байлаа.

Нэг долоо хоног манай эхнэр, найз хоёр сонины нэг жижигхэн хайчилбарыг надад авчирч өглөө. Бүрэн цагийн англи

хэлний багш ажилд авна гэсэн зарлал байлаа.

Тэгээд намайг тэр компанид товч намтраа явуулахад ирж ярилцлаганд орно уу гэв. Ярилцлага хийсэн хүн төгсгөлд нь “Та товч намтартаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд сайн дураараа номлолын ажил хийсэн гэж бичжээ. Ингэхлээр та бүтэн сайн өдөр бүр сүмд явдаг гэсэн үг үү? Хэрэв та ням гарагт сүмд явах, ажиллах хоёрын аль нэгийг сонгох боллоо гэвэл алийг нь сонгох вэ?” гэж асуусан юм.

Надад илүү сайн ажил хэрэгтэй байсан болохоор энэ хэцүү асуулт байлаа. Гэвч би түр зуур бодсоны дараа “Би сүмдээ явна” гэж хариулав.

Ярилцлага хийгч инээмсэглэснээ “Аан, ойлголоо” гэв. Тэгээд компани тэр өдрийн орой гэхэд шийдвэрээ гаргана. Тиймээс хариугаа мэдэхээр утасдаарай гэж надад хэллээ. Өрөөнөөс гарч явахдаа ярилцлага амжилтгүй болсон юм байна гэж би бодлоо.

Орой нь утасдах цаг болоход би ихэд айж, нөгөөх компани руу залгалаа.

“Ярилцлагын дүн юу болсон бол?” гэж би нарийн бичгийн даргаас асуув. “Би унасан биз, тийм үү?”

Би хариугаа сонсоод мэл гайхсан ч баяртай байлаа.

“Бид таныг манайд ажиллахыг хүсч байна” гэж тэр хэллээ.

Сар орчмын дараа намайг яагаад ажилд авсныг би мэдсэн. Ярилцлага хийгч Хожмын Үеийн Гэгээнтэн бүрэн цагийн номлогчдын зэргэлдээх хаалганд амьдардгийг нарийн бичгийн дарга надад хэлсэн юм. Тэрээр өглөө бүр дугуйгаа унаж, ажилдаа яаран явдаг номлогчдыг олонтоо хардаг байсан гэнэ.

“Таныг тэр сүмд явдаг болохоор сүмийнхээ төлөө номлогчид нь шаргуу ажилладаг шиг бидэнтэй



“Хэрэв та ням гарагт сүмд явах, ажиллах хоёрын аль нэгийг сонгох боллоо гэвэл алийг нь сонгох вэ?” гэж ярилцлага хийгч надаас асуув.

хамт бас тэгж шаргуу ажиллах байх гэдэгт тэр итгэлтэй байсан” гэж нарийн бичгийн дарга ярьжээ. “Та их азтай хүн шүү!”

Тэр цагаас хойш бидэнд хэрэгтэй бүх зүйл манайд үргэлж байдаг болсон.

Би энэ явдлыг бодох бүрдээ урам зориг орж, тайтгарлыг мэдэрдэг билээ. Бурхан хүүхдүүдээ адислахын тулд бусад хүмүүсийг олонтоо ашигладгийг би мэднэ. Сонины тэр зарлалыг надад авчирч өгөхөөр сүнслэгээр нөлөөлөгдсөн эхнэр, найз хоёртоо, ажилдаа үнэнч шаргуу номлогчдын агуу үлгэр жишээний төлөө, түүнчлэн бидний хичээл зүтгэлийг бидний сайн сайхны төлөө адислах хүчтэй, энэрэл хайраар дүүрэн, бидэнд үргэлж анхаарал тавин халамжилж байдаг Тэнгэрлэг Эцэгтээ талархлаа хэрхэн илэрхийлэхийг би мэдэхгүй байлаа. ■
Кеня Иший, Япон

БЭЛГИЙН ХАРИЛЦААНЫ ЁС СУРТАХУУНГҮЙ ДЭЛХИЙД ХЭРХЭН ариун явдалтай БАЙХ ВЭ?

Ариун явдлыг үнэ цэнэгүй зүйл гэж үздэг, тэр ч байтугай үүгээр элэг доог хийдэг дэлхийд ариун явдалтай байхаас ирдэг адислалууд хийгээд тохиолддог сорилтууд бэрхшээлүүдийн талаар ярилцахаар Сүмийн сэтгүүлүүд дэлхийн янз бүрийн газраас ирсэн олон залуу насанд хүрэгчтэй уулзсан юм. Бид тэдэнтэй илэн далангүй, сэтгэл санааг өргөсөн, сүнслэг нөлөө бүхий чин сэтгэлийн ярилцлага хийсэн бөгөөд гэрлэлт болон янаг амрагийн харилцааны ариун нандин байдлын үнэ цэнийг ойлгоход та нарт тусалж болох зүйл тэдний санал зөвлөмжид байж болох юм.

Үй олон хүн ёс суртахуунгүй зан авирыг зөвтгөж байгаа өнөө үед бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун байхад тань сайн мэдээний ямар үнэнүүд тусалдаг вэ?

Мартин Исаксен, Норвеги:

Ариун явдалтай байх хэрэгтэй хэмээн судруудад өгүүлдэг. Энэ бол миний хувьд хангалттай шалтгаан.

Лиззи Женкинс, Калифорни,

АНУ: Ариун явдал бол үүрэг мөн. Бид ариун явдлаар амьдрах ёстой. Энэ бол амьдралын хэв маяг.

Лиз Уэст, Англи: Би өөрийгөө хэн билээ гэдгийг ойлгосон, ирээдүйн амьдралд минь одоогийнхоос илүү чухал зүйл намайг хүлээж байгаа гэдгийг ойлгосон нь надад их тусаллаа. Арваад настай байхдаа миний тайлбарлаж чаддаггүй байсан авралын төлөвлөгөө энд чухал ач холбогдолтой юм. Мөнхийн гэрлэлтийн үзэл баримтлал үнэхээр гайхамшигтай! Хүмүүс мөнхийн гэрлэлтийн тухай үзэл баримтлалыг

ойлгосноор Бурхан биднийг дэлхий дээр гэр бүлүүдэд төрүүлж, бидэнд зөвхөн аюулгүй байх төдийгүй аз жаргалтай амьдрах зарлиг өгсөн нь хэчнээн гайхалтай болохыг мэддэг. Би эдгээр зарчмуудаар амьдарч, эдгээрийг найз нартайгаа хуваалцахын хамт “Би архи уухгүй,” “Би энэ үдэшлэгт явахгүй,” эсвэл “Би үүнийг хийхгүй” гэж хэлэхэд тэд намайг хүндэлдэг. Аажимдаа тэд намайг хамгаалдаг болсон. Өөрийгөө Бурханы үнэ цэнэтэй хүүхэд гэдгийг ойлгосон нь, намайг хэн бэ гэдгийг Тэнгэрлэг Эцэг минь мэддэг бөгөөд Тэр миний төлөө үргэлж анхаарал халамж тавьж байдгийг ойлгосон нь надад их хүч чадал өгсөн юм.

Анна (Аня) Власова, Орос:

Би өөрийгөө тэнгэрлэг гэр бүлийн хэсэг гэж боддог болсон нь надад их тусалсан. Би Бурханыг хайрлаж, дээдлэн хүндэлдэг бөгөөд хийдэг сонголтуудаараа Түүнийг ичээхийг хүсдэггүй.

Кейли Виттеморе, Флорида,

АНУ: Гэр бүлийн ариун нандин байдлыг ойлгосон нь ариун явдлын хуулиар амьдрах хүчтэй хүсэл эрмэлзлийг надад төрүүлсэн. Бид зарлигуудыг зөрчсөн үед хүсэхийн аргагүй сөрөг үр дагавар ирдэг нь миний ойлгосон бас нэгэн зүйл юм.

Фаланде (Фэе) Томас, Гайти:

“Одоо юм бүхэнтэй болж чадах байтал яах гэж хүлээх юм бэ?” хэмээн хүмүүс яагаад хэлдгийг би сайтар бодож үзсэн. Гэвч иймэрхүү аз жаргал хэр зэрэг удаан үргэлжлэх бол гэдгийг ч бас бодсон. Би ариун явдлын хуулиар амьдрахыг хичээдэг. Үр дүнд нь амар амгаланг мэдэрсэн.

Хипполит (Хип) Коуадио,

Зааны Ясан Эрэг: Надад маш их тусалсан нэг зүйл бол: “Үр удамаа үлдээх энэхүү ариун нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр, нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн. . . бид тунхаглаж байна” гэж мэдэгдсэн Гэр бүлийн тунхаг юм.¹

Надад тусалсан өөр нэг зүйл бол ариун явдлыг бидэнд тайлбарласан Ах нарын тайлбар юм. Тэд ёс суртахуунгүй байдал хэрхэн эхэлдгийг бидэнд анхааруулж, бид бие махбоддоо зүй бусаар хандсанаар сүнсэнд зүй бусаар хандаж байгаа хэрэг гэдгийг заадаг билээ. Бид нэгэн цагт амилсан бие махбодтой болохын төлөө Аврагч төлөөс төлсөн юм гэдгийг Ахлагч Жеффри



“Бид ирээдүйд дахин амилах мах бодтой болж болохын тулд төлөөсийг Аврагч төлсөн билээ. Бид Түүний хийсэн төлөөсийн төлөө талархалтай байх арга зам бол бие махбодоо цэвэр ариун байлгах явдал юм.”

Р.Холланд заасан. Түүний төлсөн төлөөсийн төлөө бид талархалтай байх арга зам бол бие махбодоо цэвэр ариун байлгах явдал мөн.²

Лиз: Би 15 орчим настай байхдаа нэг хүнтэй ярилцсанаа санадаг. Хүн гэрлэхээсээ өмнө янаг амрагийн харилцаатай болно гэдэгт итгэх аргагүй юм гэсэн миний үзэл бодлын тухай тэр эмэгтэй бид хоёр ярилцсан юм. “Тийм ээ, гэвч яах ч аргагүй гэнэт янаг амрагийн харилцаа бий болсон бол яах вэ? Нэг шөнө. . . нэг л мэдэхэд. . .?” гэж хэлснийг би санаж байна. Гэвч надад сонголт бий гэдгийг би мэдэж байлаа. Ямар ч юм гэнэт “тохиолддоггүй.”

Тэнгэрлэг Эцэг бидэнд сонгох эрх болон зарлигуудыг өгч, Сатан биднийг боолчлох буюу бидний эрх чөлөөг хумихын тулд чадах бүхнээ хийхийг чөлөөтэй болгосон билээ. Хүмүүс архи ууж, хос хосоороо салж булагнасан үдэшлэг дээр ямар нэг юм “болсон” үе байсан тухай миний найз ярьсан юм. Тиймээс би ийм нөхцөл байдлаас зайлсхийдэг. Бид сонголтыг зөвшөөрсөн буюу эс зөвшөөрсөн хариу хэлэх эцсийн мөчид хийх ёсгүй. Сонголтыг “Би энэ үдэшлэгт явах уу, үгүй юү?” гэж өөрөөсөө асуух үед буюу өмнө нь хийдэг.

Олон хүн юмсын талаар өмнө нь бодож, тэдгээрийн үр дагаврын талаар урьдчилан бодохгүй бол юу л хүснэв, түүнийгээ тэр үед нь хийх болно. Хэрэв та “Эцсийн үр дүнг нь бодсон учраас би энэ сонголтыг хийх болно” хэмээн хэлдэг бол олон гай зовлонгоос зайлсхийж чадна.

Та сонгох эрх болон зарлигуудын тухай дурдлаа. Харин гэрээнүүд—баптисмын болон ариун сүмийн гэрээнүүд жишгүүдээр амьдрахад тань тусалдаг уу?

Фас: Баптисм хийлгэхээс өмнө миний амьдрал ямар байсан, гэрээнүүд хийснээс хойш амьдрал хэрхэн өөрчлөгдсөн талаар би боддог.

Цагаатгалын ачаар бид уучлагдаж болдог нь үнэхээр гайхамшигтай юм. Би гэрээнүүдээ санасан үед хэрхэн наманчилж, улам төгөлдөржин, үргэлж урагш ахин өсч хөгжиж болох тухай боддог.

Аня: Та ялангуяа ариун сүм дээр мөнхийн ирээдүйгээ харж чадна. Зөвхөн өнөөдрийнхөө тухай төдийгүй харин мөнхийн ирээдүйнхээ талаар бодоход чинь ариун сүм туслах учраас чи ухаалаг сонголт хийж чадна.

Лиззи: Янаг амрагийн харилцаа бол муу зүйл гэдэгт бид олонтоо итгэсээр ирсэн. Гэвч энэ нь тийм биш юм. Үүнийг зөв эрх мэдлээр, зөв цагт, зөв хүнтэй үйлдэж байгаа бол цэвэр ариун байж чадна. Гэрээнүүдийн тухайд ч мөн ийм юм. Та гэрээнүүд хийхдээ “Би амьдралдаа энэ алхмыг хийхэд үнэхээр бэлэн байна” хэмээн хэлэх болно. Бид юмсыг зөв гэж бодсон дэс дараалаар хийж байгаагаа мэддэг учраас гэрээнүүд надад тусалдаг. Хэрэв би Тэнгэрлэг Эцэгийн хүссэн зүйлийг хийх юм бол аз жаргалтай байх болно гэдгээ би мэддэг.

Жонатан Томасини, Франц: Хэрэв би гэрээнүүдээ зөрчих юм бол өөртөө ч, Бурханд ч үнэнч байж чадахгүй. Гэрлэлтийн гэрээ нь өөртөө хяналт тавьдаг эхнэртээ би юу санал болгож чадахаа харах, түүнчлэн өөрийгөө сайн нөхөр байхад бэлтгэж, цэвэр ариун байхад надад тусалдаг.

Ариун явдлын хууль яагаад үеэ өнгөрөөсөн тухай дэлхийд хоорондоо зөрөөтэй олон үзэл бодол байдгаас нэлээд олон нь үнэмшилтэй мэт харагдах боловч ээдрээтэй нарийн юм. Энэ талаар та ямар шүүмжлэлийг сонссон бэ? Жишгүүдийг чинь шүүмжилдэг хүмүүст та юу гэж хариулсан бэ?

Лиззи: Намайг ахлах сургуулийн төгсөх ангид байхад нэг багш



ЖИШИГ БА ТҮЛХҮҮР

“Жишиг нь гэрлэхээс өмнө бэлгийн

харилцаанд орохгүй байж, гэрлэснээсээ хойш эхнэр, нөхөртөө туйлын үнэнч байх явдал мөн. Гэвч бид өөрсдийнхөө хийж болох алхмаас, жишгүүдийг үл тоомсорлосноос, бусад хүмүүс жишгүүдийг баримталдаггүйн улмаас бууж өгөх ёсгүй. . . .

Та нарт Ариун Сүнсний бэлэг өгөгдсөн байгаа. Та нарыг шийдвэр гаргахад Ариун Сүнсний шивнээ шийдвэрийг тань сайшаан батлах буюу анхааруулан сэрэмжлүүлэх болно. Тэрээр та нарыг нүгэл хилэнцээс холдуулан удирдах буюу хэрэв замаа алдаж төөрсөн бол зөв замд буцаан оруулах болно. Та нар бол Бурханы хөвгүүд, охид гэдгээ хэзээ ч бүү март. Сатан та нарыг үүрд шоронд хорьж чадахгүй. Шоронгийн хаалгыг онгойлгох наманчлалын түлхүүр та нарт үргэлж бэлэн байдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакер, “The Standard of Truth Has Been Erected,” *Лиакхона*, 2003 оны 11-р сар, 26.

бидэнд “зөвлөгөө” өгснийг би санаж байна. Тэр эмэгтэй ахлах сургууль төгсөнгүүтээ гэрлэсэн ч, төдөлгүй салсан ажээ. Тэгээд тэр бидэнд “далайд олон загас байдаг?” гэдэг байж билээ. Тэр энэ үгээрээ, сониучирхаж үзэх юмс ч бас сорьж үзэх эрчүүд ч бишгүй олон байдаг гэсэн санааг илэрхийлдэг байв. Багш маань ийм үг хэлсэнд би мэл гайхан цочирдож билээ. Тийм ээ, тэр үеэс хойш би үнэхээр олон хүн байдаг тухай боддог болсон ч ийм зүйлийг огт хүсдэггүй байв!

Жонатан: Миний таньдаг нэг эмэгтэй, тэрээр хэн нэгэнтэй харилцаатай болсон үед тэр хүнтэй бэлгийн харилцаагаараа хэр тохирох эсэхийг үзмээр санагддаг хэмээн ярьж билээ. Тэр өөртөө таалагдсан нэг залуутай болздог болж, тэгээд янаг амрагийн явдлын дараа нөгөөх залуу түүнд тохирохгүй юм байна гэж бодоод хоёр тийшээ болсон тухайгаа ярьсан. Тэр өөрийн бодлыг зөвтгөхийн тулд энэ тухай ярьсан нь ямар нэг хэмжээгээр үндэслэлтэй ч юм шиг санагдаж билээ. Эцэст нь би түүнд, та хоёр өөр илүү сайн арга замаар бие биеэ таньж мэдэх хэрэгтэй. Хэрэв ингэх юм бол ариун явдлын хуулиар амьдрах итгэл бий болж, та нар гэрлэсэн хойноо илүү агуу аз жаргал, нийцтэй байж чадна хэмээн зөвлөж билээ.

Аня: Хоёр хүн бие биедээ хайр сэтгэлтэй болно гэдэг сайхан хэрэг. Иймд янаг амрагийн явдал бол хайраа илчилж байгаа хэрэг гэдэг үгийг би үргэлж сонсдог.

Мартин: “Бид хоёр бие биедээ хайр сэтгэлтэй шүү дээ” гэж шалтаг заахыг сонссон үед Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын хэлсэн нэг үг миний санаанд орж ирдэг. Хүмүүс бие биедээ хайр сэтгэлтэй гэж бодсон үед тачаангуй хүсэл тэдний бодолд сэмхэн орж ирэх нь олон тохиолддог хэмээн тэр хэлжээ.³ Олон хүн гэрлэхээсээ

өмнө янаг амрагийн харилцаатай болдог. Хэдийгээр тэд бие биедээ хайр сэтгэлтэй гэж боддог ч энэ бол тачаангуй хүсэл мөн. Хэрэв тэд үнэхээр бие биедээ хайртай юм бол бие биеэ улам илүү хүндэлж, дэмжин, янаглах цаг хугацаа бий гэдгийг ойлгох хэрэгтэй. Гэрлэхээсээ өмнө янаг амрагийн харилцаатай болох нь миний бодлоор, тэр хоёр хүн боддогтойгоо адил бие биеэ өргөн дэмждэггүйгээ харуулж байгаа хэрэг. Учир нь гэвэл, тэд жишгүүдээрээ амьдрахад одоо бие биеэ дэмжих чадваргүй байгаа юм чинь хожим нь бие биедээ дэмжлэг үзүүлж чадна гэж үү?

Кейли: Бурханд итгэдэггүй зарим хүмүүс Библи болон ариун явдлын хууль үеэ өнгөрөөн хоцрогдсон гэж боддог. Ахлах сургуульд миний зарим найз нар үндсэндээ шашингүй үзэлтнүүд буюу танин мэдэхгүйг үгүйсгэгчид байсан бөгөөд нэг найз маань өөрийнхөө сүмийн сургаалуудад огт итгэдэггүй байлаа. Тэр чухамдаа дур зоргоороо амьдардаг байсан бөгөөд юу л гэж бодно, түүнийгээ зөв гэж боддог байв. Түүний бодлоор янаг амрагийн явдал нь сэтгэл ханамж бөгөөд үүнийг хориглодог юу ч гэсэн хүсмээр зүйл биш ажээ.

Намайг Библи болон Бурханы зарлигуудад итгэдэгт тэр найз маань гайхдагийг би мэддэг ч гэсэн зарлигуудыг хориг хязгаарлалт гэж үздэггүйг, зарлигууд намайг илүү аз жаргалтай болгодог учраас би тэдгээрийн дагуу амьдардаг гэдгийг ойлгоход нь түүнд туслахыг хичээдэг байлаа. Хэдийгээр бидний санал зөрдөг ч, тэр намайг хүндэлдэг байсан бөгөөд бид хоёр дотны сайн найзууд хэвээр үлдсэн юм.

Лиз: Эдгээр бүх учир шалтгааны хариу сайн мэдээний үндсэн зарчмуудад агуулагддаг. Бурхан бий гэдэгт, Түүний агуу төлөвлөгөө бий гэдэгт, уг төлөвлөгөөнд өөрийн

чинь биелүүлэх ёстой үүрэг хариуцлага бий гэдэгт, өөрийгөө Бурханы үнэ цэнэтэй хүүхэд гэдэгт итгэсэн үед та өөрийнхөө үнэ цэнийг ойлгож, бие махбоддоо хүндэтгэлтэй хандах болно. Хүмүүс эдгээр зарчмуудад итгэдэггүй буюу тэдгээрийг мэддэггүй бол үнэ цэнийг нь бусад хүмүүсээс эсвэл бусад газруудаас олж харахаар тэднийг гярхай ажигладаг.

Ариун явдлын хуулиар амьдрахаар шийдэхэд чинь гадны ямар нөлөө, үлгэр жишээ танд тусалсан бэ?

Хип: Нэг өрөөнд хамт амьдардаг найз маань сүй тавьсан байлаа. Нэг өдөр биднийг удахгүй болох түүний гэрлэлтийн тухай ярилцаж байтал хэн нэгэн нь, “Та хоёрыг бат бөх итгэлтэй хэвээр байхад бие биедээ туслах ямар хүчин зүйл байна вэ?” гэж асуув. “Ариун явдлын хуулийг сахихгүй бол бидний харилцаа сүйрнэ. Тиймээс бид хоёр бишоп болон эцэг эхчүүдийнхээ өмнө эвгүй байдалд орох юуг ч

“Би зарлигуудыг хориг хязгаарлалт гэж үздэггүй бөгөөд зарлигууд намайг аз жаргалтай болгодог учир би тэдгээрийн дагуу амьдардаг.”

хийхгүй гэж тохирсон юм” хэмээн тэр хариулж билээ. Энэ амлаал одоо ч надад нөлөөлсөөр байдаг.

Жонатан: Би одоо залуу насанд хүрэгч. Бошиглогчдын үгийг сонсож, Сүмийн удирдагчдын ярьдаг зүйлсийн тухай тунгаан бодох нь амар хялбар байна. Түүнээс өмнө би ихэнх үүрэг хариуцлага эцэг эх болон гэр бүлүүдэд ноогддог гэж боддог байв. Сүм мэдээлээр болон бусад олон чухал зүйлсээр хангаж чадна, гэвч сайн мэдээ бол онцгой чухал зүйл бөгөөд биднийг аз жаргалтай болгодгийг ойлгоход манай гэр бүл дэх үлгэр жишээ надад үнэхээр тусалсан юм.

Лиз: Намайг том болсон хойно миний насны Сүмийн нэг гишүүн манайд хамгийн ойрхон буюу цаг эсвэл цаг хагас явж хүрэх газарт амьдардаг байлаа. Тэнд сургуулийн найзуудаас нэг нь ч байсангүй. Гэвч намайг ганцаархнаа байсан ч манай удирдагчид Мючелд хүрч ирдэг байсанд би үнэхээр их талархдаг байлаа. Тэд семинар дээр байнга хүрч ирнэ. Бас надад заахаар нэг ч хичээлийг алгасалгүй хүрч ирдэг байв. “Танцхан суралцагч ирсэн болохоор өнөөдөр хичээл хийхгүй” гэж тэд хэзээ ч хэлдэггүй байсан. Мэдээж хэрэг, би их зүйл сурсан. Харин манай удирдагчид үргэлж хүрч ирдэг байсан нь миний санаанаас огт гардаггүй. Чухамдаа би тэдний ачаар Сүнснийг мэдэрдэг байлаа.

Бид Ариун Сүнсний бэлгийн үнэ цэнийг хэзээ ч бүрэн дүүрэн үнэлж чадахгүй гэж би боддог. Надад эцэг эх, гэр бүл, удирдагчид байсан ч сургуульд байхаасаа би ганцаараа байдаг байлаа. Гэвч Сүнс надтай хамт байсан. Хүмүүсийн амьдралд Сүнснийг байлгаж чаддаг юу боловч ариун явдлын хуулийг дагахад нь тэдэнд агуу нөлөө үзүүлэх болно.

Лиззи: Өөрөө өөртөө гэрчлэлтэй болж чадсан маань миний хамгийн

том нөлөөллүүдийн нэг байлаа. Хэрэв та сайн мэдээнд бат бөхөөр суурилж чадаагүй бол өөр замыг сонгох нь үнэхээр амархан байх болно. Хэрэв та сайн мэдээнд бат бөх суурилсандаа итгэлтэй байгаа бол бусад бүх зүйл түүнээс хамааран бүтэлтэй байх болно.


Хип: Бид бие бялдрын хүч тэнхээтэй байхыг хүсэх үедээ дасгал хийдэг. Дасгал хийснээр үр дүн ирнэ. Хэрэв бид энэ зарчмыг сүнслэг арга замаар хэрэгжүүлэхийг хүсвэл сүнслэгээр дасгал хийх хэрэгтэй. Судар унших, хийдэг бүх зүйлдээ Сүнсийг урин оролцуулах гэхчлэнгээр сүнслэг байдлыг өөртөө хөгжүүлэхийн тулд хийх зүйл бидэнд олон бий. Бид бас зөв шударга зорилго дэвшүүлж, түүндээ хүрэхийн төлөө ажиллах ёстой. Гэвч зорилгодоо зөвхөн өөрсдийн хүчээр хүрч чадахгүй. Бид Их Эзэнийг өөртэйгөө хамт байлгах хэрэгтэй. Бид Түүнээс хүч чадал болоод сорилт бэрхшээлийг даван туулах Сүнснийг олж авдаг. Тэгвэл бид Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн дараах гуйлтыг дагаж чадна:

“Хүсэл мөрөөдлийг чинь устгах боломжийг дур тачаалдаа бүү олго. Уруу таталтанд бүү ор.

‘Ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй’ гэсэн Мормоны Номын үгсийг санаж яваарай.”⁴ ■

ЭШЛЭЛ

1. “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129.
2. Жеффри Р.Холланд, “Of Souls, Symbols, and Sacraments,” *Brigham Young University 1987–88 Devotional and Fireside Speeches* (1988), 77–79-г үз.
3. “Нүгэл үйлдсэн үед цэвэр хайр хаягдаж, гэм нүгэл түүний орыг эзэлдэг. Энэрэл хайр махан биеийн хүсэл хийгээд хазаарлагддаггүй дур таашаалаар солигдож, чөтгөрийн бий болгохыг эгээрэн хүсдэг, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцааг зөвтгөдөг сургаальг хүлээн авдаг” (*Teachings of Spencer W. Kimball*, хянан тохиолдуулсан Эдвард А.Кимбалл [1982], 279).
4. Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Be Thou an Example,” *Лиакхона*, 2005 оны тавдугаар сар, 113.



“Бурханы санваарт хүндэтгэлтэй хандах гэж юу гэсэн үг вэ?”

Санваар бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр өөрсдийн ажлыг хийдэг хүч юм. Энэ бол дэлхий дээрх хамгийн агуу хүч. Санваараар ёслолуудыг гүйцэтгэж, адислааууд өгөн, ариун сүмийн ажлыг хийж, сайн мэдээг номлон, гайхамшгуудыг үйлддэг.

Санваартнууд Аврагчийг төлөөлдөг бөгөөд хэрэв Аврагч дэлхий дээр байсан бол Түүний хийх байсан зүйлсийг хийдэг учир тэд санваартаа хүндэтгэлтэй ханддаг. Тэд зохистой амьдарснаараа санваартаа хүндэтгэлтэй ханддаг. Тэд хувцаслалт, ажил үйлс, үг яриа, үйлчлэл, бодол санаагаараа санваараа хүндэлдэг.

Залуу эмэгтэйчүүд баптисмын гэрээнүүдээ сахиж, ариун ёслол, ариун сүмийн ажил зэрэг санваарын ёслолуудад хүндэтгэлтэй оролцох нь санваарыг хүндэлж байгаа хэрэг юм. Тэд аав, ах, эрэгтэй дүү нартаа болон бусад санваартнуудад зарлигуудыг сахиж, зохистой амьдрах, санваартны үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж болно.

Бид дуудлагадаа итгэлтэйгээр үйлчилж, санваартнуудад болон санваараар гүйцэтгэдэг ажил, өөрсдийн хүлээн ёслолууд болон гэрээнүүдэд хүндэтгэлтэй хандсанаар санваарыг хүндэлж байгаа хэрэг юм.

Бурханы төлөөлөгчийн хувиар үйлд



Бурхан энэ бэлгийг бидэнд соёрхсон нь хэчнээн гайхамшигтай болохыг ойлгосноор бид санваарт хүндэтгэлтэй хандах нь энгийн зүйл болж чадна. Иймээс та нарт итгэмжлэл хүлээлгэн олгосон энэхүү хүчинд талархал, хүндэтгэлтэйгээр хандагтун. Миний эргэн тойрон дахь хүмүүс намайг Бурханы хүчийг атгадаг гэдгийг мэддэг үү? Тэд Түүний тухай юу гэж боддог бол? хэмээн өөрөөсөө асуу. Санваартаа хүндэтгэлтэй хандах гэдэг нь та өөрийгөө Бурханы төлөөлөгч гэдгийг гүнээ ухамсарлаж, Тэрээр өөрт чинь итгэмжлэл хүлээлгэсний төлөө хүндэтгэлээ харуулах замаар үйлдэхийн тулд чадах бүхнээ хийх явдал юм.

Масон Р., нас 19, Колорадо, АНУ

Ариун журамтай бай



Залуу эмэгтэйн хувьд би санваарт хүндэтгэлтэй хандах хэрэггүй гэж хэлж болох юм. Гэвч бүх залуу эмэгтэйчүүд санваарт хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Бид ариун журамтай байснаар санваарт хүндэтгэлтэй ханддаг. Бид залуу эрэгтэйчүүдэд цэвэр ариун бодол санаатай байхад тусалснаар санваарыг хүндэлдэг. Бас даруухан хувцаслаж, хэл яриагаа цэвэр байлгах нь санваарт хүндэтгэлтэй хандаж байгаа хэрэг. Бид ингэснээрээ залуу эрэгтэйчүүдэд санваараа хүндлэхэд нь тусалдаг бөгөөд энэ бол бид санваарт хүндэтгэлтэй хандаж байгаа хэрэг мөн.

Мариса Б., нас 14, Аризона, АНУ

Бурханы өмнө хүлээсэн үүрэг

Миний бодлоор Их Эзэн Өөрөө дэлхий дээр байсан бол Түүний хийх байсан зүйлсийг бид хийх нь санваарт хүндэтгэлтэй хандах гол арга зам мөн. Учир нь бид Есүс Христийг төлөөлдөг. Энэ бол бид санваарт томилогдохдоо Бурханы өмнө хүлээсэн бүх үүрэг, амлалтуудаа биелүүлэх ёстой гэсэн үг юм. Бид Түүний санваарт хүндэтгэлтэй хандсанаар “[бидний] гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч, урагш гэрэлтүүл” (С ба Г 115:5) гэсэн Түүний зарлигийг биелүүлдэг. Бурханаас эрх мэдэл олгогдсон Түүний олон үйлчлэгч дэлхий дээр байдгийг мэдэхэд нь бид бусдад тусалдаг.

Бисмарк Б., нас 18, Санто Доминго, Бүгд Найрамдах Доминикан Улс

Санваарт хүндэтгэлтэй хандгаа харуул.

Санваартаа хүндэтгэлтэй хандах гэдэг нь санваарыг хүндэтгэлтэй бөгөөд итгэлтэйгээр ашиглах явдал гэж би боддог.

Хариултууд нь туслах болон ирээдүйг харахад зориулагдсан бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

Санваартаа болон тойргийнхоо ариун ёслолд хүндэтгэлтэй ханддаг Аароны санваартан гишүүд танай тойрогт байгаа болохоор ариун ёслолыг түгээх, бэлтгэх талаар арвин баялаг туршлага танайд байна гэсэн үг. Бид бүгд цагаан цамц өмсөж, зангиа зүүдэг. Энэ нь манай тойрогт болон надад маш их нөлөө үзүүлсэн. Санваартай байх нь надад тохиолдсон хамгийн сайхан зүйл гэдгийг би мэднэ.

Хансен Б., нас 15 Техас, АНУ

Жишгүүдээсээ бүү ухар

Санваартаа хүндэтгэлтэй хандах гэдэг нь жишгүүдээсээ ухарч болзошгүй нөхцөл байдалд өөрийгөө оруулахгүй байх гэсэн үг юм. Бид семинарт Хуучин Гэрээг судалж байхдаа Эхлэл 39-өөс Египетийн Иосеф Потифарын эхнэрийн сээтэгнэлээс зугатааснаараа санваартаа хүндэтгэлтэй хандсан жишээг мэдсэн билээ.

Залуу эмэгтэйчүүд санваарт хүндэтгэлтэй хандахад туслах нэг арга зам бол *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь жишгүүдийг баримталж, даруухан хувцаслах явдал мөн.

Жозеф Б., нас 16, Техас, АНУ

Санваарыг дээдэл

Санваарт хүндэтгэлтэй хандана гэдэг нь залуу эрэгтэйчүүд өөртөө өгсөн Их Эзэний энэхүү бэлгийг дээдлэн хүндлэх явдал гэж би боддог. Залуу эрэгтэй санваартаа хүндэтгэлтэй хандаж байгааг харахад надад их сайхан санагдаж, би түүнийг илүү хүндэтгэдэг. Тэнгэрлэг Эцэг түүнд санваарыг итгэмжлэн олгосон болохоор тэр залуу эрэгтэй зөвхөн санваарыг эзэмших төдийгүй бас үүнийг эрхэмлэн дээдлэх үүрэгтэй гэж би боддог.

Мелинда Б., нас 16, Вашингтон, АНУ

Аврагчийг сана



Санваар бол дэлхий дээрх Бурханы цорын ганц үнэн хүч бөгөөд Түүнд эргэж очих замыг бидэнд заадаг. Бид санваарт хүндэтгэлтэй хандах тухай ярихдаа Ерөнхийлөгч Томас С.Монсон болон бусад Төлөөлөгчдийн сургаалыг дагах тухай боддог. Санваарт хүндэтгэлтэй хандах хамгийн сайн арга зам бол бид заалгасан зүйлсээ амьдралд хэрэгжүүлдэг байх явдал мөн. Энэ нь Аврагчийг санах боломжийг бидэнд олгодог. Түүнийг санасан үед Түүний Сүнс бидэнтэй хамт байх болно. Сүнстэй байх нь тавьсан зорилгоо хэрэгжүүлж, сайн мэдээний жишгүүдээр үлгэр жишээ үзүүлэх боломжийг бидэнд олгодог.

Ням гарагийн анги: Кили Э., Жейтен В., Жозеф Э., Александра Р., Кейли В., Алиша Ф., Хейли В.; Айдахо, АНУ.



САНВААР БОЛ АРИУН ЗҮЙЛ

“Залуу эрэгтэйчүүд түүнчлэн залуу эмэгтэйчүүд. . . санваарт хүндэтгэлтэй хандаж, үүнийг ариун

зүйл гэдгийг мэддэг байх ёстой. . . . Учир нь энэхүү эрх мэдлийн хүчээр дэлхий даяар, ариун газар болгонд сайн мэдээний ёслолууд гүйцэтгэгддэг бөгөөд санвааргүйгээр эдгээр ёслолуудыг гүйцэтгэх аргагүй юм. Энэхүү эрх мэдлийг эзэмшдэг хүмүүс өөрсдөө санваараа хүндэлдэг байх ёстой. Тэд өөрт нь олгогдсон эрх мэдэлд тэнцэхүйц зохистой амьдрах ёстой.”

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918), *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 144.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Манай Сүмийн зарим гишүүд яагаад бидний жишгүүдээр амьдардаггүй юм бэ гэж асуусан гишүүн бус хүмүүст чи юу гэж хэлэх вэ?”

Хариултаа 11-р сарын 15-наас өмнө lahona@ldschurch.org хаягаар эсвэл дараах хаягаар ирүүлнэ үү:

Liahona, Questions & Answers 11/12
50 E. North Temple St., Rm. 2420
Salt Lake City, UT 84150-3220, USA
хаягаар шуудангаар явуулж болно.

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

УХААЛАГ АНД НАЙЗ БАЙ





**Ахлагч
Роберт Д.Хейлс**

Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулга

*Насны залууд суралцаж
мэдлэг, мэргэн ухааныг
эзэмш. Тэгээд эргэн тойр-
ныхоо хүмүүсийг өргөн
дэмжиж, хүчирхэгжүүл.*

Та нар үнэхээр сайхан амьдрахыг хүсч байгаа бол “Насны залууд мэргэн ухаанд суралц; тийм ээ, насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун” (Алма 37:35) гэсэн судрын зөвлөгөөг дагах хэрэгтэй. Сурах үйл явцыг дараах байдлаар хураангуйлан томъёолж болно:

Бид бүгд үндсэн мэдлэгээс эхэлдэг. Бид үүн дээрээ анги танхимд заалгасан болон уншсан зүйлээсээ олж авсан мэдлэгээ нэмэн баяжуулдаг. Мөн амьдралын туршлагаа нэмдэг. Ингээд бид мэргэн ухаан буюу дөрөв дэх алхмыг хийдэг. Энэ цэг дээр дэлхийн сурах үйл явц төгсдөг. Харин дэлхийд байдаггүй нэг зүйл бидэнд бий. Баптисм болон гишүүний баталгааны дараа бидэнд Ариун Сүнсний бэлэг өгдөг. Бид баптисмын үеэрээ өөрсөд дээрээ хүлээн авсан хууль, ёслолууд болон гэрээнүүдэд хэр дуулгавартай байгаагаас шалтгаалан, ариун

ёслолын цуглаануудад тогтмол оролцох, санваарын болон ариун сүмийн гэрээнүүдэд чин үнэнч байх үүргээ биелүүлснээр бидэнд зааж, биднийг удирдах Ариун Сүнсний бэлэг үргэлж байх болно. Сүнс биднийг үйлдэл хийхэд удирддаг. Бид бүгдэд сүнсний бэлэг, авьяас чадвар байдаг (С ба Г 46-г үз).

Мэргэн ухаан болон сүнсний бэлгүүд нийлж, зүрх сэтгэл дэх ойлголт руу хөтөлдөг. “Мэргэн ухааны эхлэл болбоос түүнийг олж авах, олж авсан бүхнээрээ ухааныг олж авах явдал болой” (Сургаалт Үгс 4:7). Насны залууд мэргэн ухаан ба мэдлэгийг эзэмших нь туйлын чухал юм.

Залуу насны маань нэгэн туршлага надад мэргэн ухааны тухай нэг зүйлийг ухааруулсан юм. Би хотын хөвгүүн байсан болохоор аав намайг баруун Юта дахь авга ахын ферм дээр ажил хийлгэхээр явуулдаг байлаа. Би тэнд байхдаа үхэр яагаад хэдэн мянган га газраас шилж авсан газар дээрх өвсийг идэхгүй төмөр утсаар хэрсэн хашааны завсраар толгойгоо шургуулан хашааны нөгөө тал дахь өвсийг идэх гэж зүтгэдгийг огт ойлгоогүй юм. Бид тэр үхэртэй хэчнээн адилхан болохыг та нар бодож үзсэн үү? Ялангуяа бид залуу байхдаа хориглосон ямар нэг зүйлийн цаад талд

юу байгааг харахыг үргэлж хүсдэг шүү дээ. Төрөлх хүмүүний хувьд бид төмөр утсаар хэрсэн торны завсраар толгойгоо шургуулан цаана нь юу байгааг харахыг хүсдэг. Бид яагаад ингэдэг юм бол?

Бид хориглосон шугамыг давахгүйгээр амьдралдаа маш их баяр баясгалантай байж болно шүү дээ. “Мэргэн ухааны эхлэл болбоос түүнийг олж авах явдал” бөгөөд тэрхүү мэргэн ухаанаар “хар санаатнуудын жимд хөлөө бүү тавь. Түүнээс зайлсхий. Түүгээр дайран гарах ч хэрэггүй” (Сургаалт Үгс 4:14–15) гэдгийг санагтун. Тэр ч байтугай бүү ойрт. Төмөр утсаар хэрсэн хашааны завсраар толгойгоо бүү шургуул.

Чамд сайн найзууд бий юу?

Сургаалт Үгсийн ном мэргэн ухааны талаарх эдгээр сургаалуудын дагуу сайн найз нөхдийг сонгох тухай “Хар санаатнуудын жимд хөлөө бүү тавь” (Сургаалт Үгс 4:14). “Хүү минь, тэдэнтэй хамт бүү яв. Жимээс нь хөлөө хол байлга. Учир нь тэдний хөл хорон муу руу ухасхийдэг” (Сургаалт Үгс 1:15–16) хэмээн сургасныг та нар ажиглах болно.

Та нар сайн найз нөхөд сонгосноо яаж мэддэг вэ? Би та нарт

хоёр сорилт өгье. Хэрэв та нар энэ сорилтуудыг хэрэгжүүлвэл “мөнх амьдралд хүргэдэг давчуу бөгөөд нарийн замаас” (2 Нифай 31:18) гажиж, танихгүй замд хэзээ ч орохгүй байх болно.

1. **Сайн найз нартай байсан цагт зарлигуудаар амьдрах нь амар хялбар байх болно.** Жинхэнэ сайн найз чамайг хүчирхэгжүүлж, эцсийг хүртэл тэвчихэд чинь туслах сайн мэдээний зарчмуудаар амьдрахад тань тусална.
2. **Жинхэнэ сайн найз чамайг түүний арга зам, Их Эзэний арга зам хоёрын аль нэгийг сонгож,** давчуу бөгөөд нарийн замаас гажихад хүргэхгүй. Дайсан дэлхийгээр хэрэн тэнүүчлэн, бид бүгдийг унагахыг хүсч байна. Хэрэв найз нар чинь чамайг буруу замд оруулбал тэднээс нэн даруй холд. Найз нөхдөө ухаалгаар сонго.

Чи өөрөө ямар найз вэ?

Одоо би нэг хэцүү асуулт асууя: *Та нар* ямар найзууд вэ?

Өөрийгөө аврахаас илүү эрхэм зорилго амьдралд байдаг. Бид бол эргэн тойрныхоо хүмүүсийг өргөн дэмжиж, хүчирхэгжүүлэхээр итгэмжлэл хүлээсэн хүмүүс. Их Эзэн биднийг хамтдаа Өөртөө эргэж очихыг хүсэн хүлээдэг.

Та нар бол бусдыг үлгэрлэн дагуулагч хөтөч. Тийм болохоор уруудаж унасан хөтөч байхаас илүү аюултай зүйл гэж үгүй. Өөрсдийгөө хэн гэдгээ санагтун. Та нар бол дэлхийн гэрэл, найз нөхөд, ах, эгч дүүсийнхээ гэрэл. Тэд та нараас үлгэр жишээ авах болно.

Сургаалт Үгс 4-т ийн сургасан байдаг:

“Харин шударга зөв хүмүүсийн



Дэлхийд үлгэр дуурайл үзүүлж, эргэн тойрныхоо хүмүүсийг зөв шударга замаар удирдан хөтөл. Тэд та нарыг зүг чиг заагч гэрэлт цамхаг лугаа адил ширтэн харж байна.

жим болбоос үүрийн гэгээ мэт агаад тэр нь өдрийг авчрах хүртэл улам тод гэрэлтсээр байх болно.

(шүлэг 18–19) Хар санаатны зам нь харанхуй мэт буюу.

Тэд юунд бүдэрч байгаага ч үл мэднэ”. Тэдэнд гэрэл байдаггүй, удирдамж чиглэл байдаггүй.

Зүг чигийг заах ёстой цамхаг гэрэлгүй бол юутай адил байж болохыг та нар мэдэх үү? Бид харанхуйд төөрөх болно.

Нисгэгч цахилгаан эрчим хүчгүй бол түүнгүйгээр ажилладаг зүйлсийг эс тооцвол ямарч заагчгүй болно. Тэрээр ганц хүний суудалтай

сөнөөгч онгоцон дотор 12, 200 метрийн өндөрт үүлэн дунд сэгсрэгдэн, яах ч аргагүй болсноо мэдэрнэ. Зүг чигийн ямар ч баримжаагүй болно. Нэг удаа би үүнтэй адил явдлаас эсэн мэнд гарсан юм. Энэ явдлыг би хэзээ ч мартаггүй. Та нар ч бас хэзээ нэгэн цагт ийм явдалтай тулгарч болно. Ялангуяа гэрэл заавал хэрэгтэй үед, зүг заагч гэрэлт цамхаг ажиллагаагүй болохоос илүү аюултай зүйл байхгүй.

Таны үлгэр жишээнээс хамааралтай хэн нэгнийг удирдах хэрэгтэй бол яах вэ? Сайн үлгэр жишээ үзүүл Дэлхийд үлгэр дуурайл үзүүлж, эргэн тойрныхоо хүмүүсийг зөв шударга замаар удирдан хөтөл. Тэд та нарыг зүг чиг заагч гэрэлт цамхаг лугаа адил ширтэн харж байна. Хэн нэгэнд хэрэгтэй болсон үед тэнд бай.

Сүнс бол баяр баясгалан, аз жаргалыг авчирдаг, дагуулан удирдагч гэрэл мөн. Амьдралынхаа хэв маягаас болж Сүнсийг өөрөөсөө холдон одоход хүргэхгүй байцгаая. “Бүрэнхий, дүнсгэр” энэ дэлхийд бид хэзээ ч ганцаархнаа байхгүйн төлөө би хэчнээн их залбирдаг билээ (1 Нифай 8:4).

Насны залууд мэргэн ухаанд суралцаж, мэдлэг эзэмшихээр хичээн чармайхад тань Их Эзэний адислалууд та бүхэнд байх болтугай. Та нар дуулгавартай байдлаар, Сүнсний гэрэл хийгээд Ариун Сүнсээр сайн мэдээний үнэнүүдийг зүрх сэтгэлдээ гүнзгий ойлгон, мэргэн ухааныг эзэмших болтугай. Сайн найз нөхөр бай. Эргэн тойрныхоо хүмүүсийг өргөн дэмжиж, хүчирхэгжүүл. Үлгэр дуурайл үзүүлэх замаар дэлхийг илүү сайн болго. Давчуу бөгөөд нарийн зам дээр байж, эцсийг хүртэл тэвчин, тэнгэр дэх гэртээ нэр төртэйгөөр эргэж очиход нь найз нөхдөдөө тусал. ■

Бүжигт орохдоо ХЭРХЭН ХУВЦАСЛАХ ВЭ?

Кристал Мартин

Би олонхийг дагаж уруу татагдсан ч хувцаслалтын талаар бусдад үлгэр дуурайл үзүүлэх хэрэгтэйгээ дараа нь ойлгосон.

Намайг өсвөр насны охин байхад зарим үед сайн мэдээгээр амьдрах нь хэцүү байдаг байлаа. Миний амьдарч байсан нутагт Сүмийн гишүүд цөөхөн байснаас гадна Сүмийн гишүүн биш найз нар маань намайг зөв зам дээр үлдэхэд саад учруулдаг байв.

“Чи миний энэ даашинзыг өмс. Чиний нүдний өнгөнд сайхан зохиж байна” гэж найз нарын маань нэг бүжигт орохын өмнө хэлж билээ. Тэгээд даашинзаа миний биенд барьж үзэв. Гэтэл тэр нь ханцуйгүй байлаа. Би тэр даашинз дээр хантааз өмслөө.

Тэгээд бүжигт ортол ханцуйгүй даашинз өмссөн хүн ганц ч алга. Би бусдаас гаж сондгой байх шиг санагдан зогсож байлаа. Өрөөнд халуун болоход найз нар маань намайг хантаазаа тайлаач гэв. Хантаазаа тайлсан нь арай дээр санагдлаа.

Хантаазаа тайлъя гэж бодсон агшинд би патриархын адислалаа гэнэт саналаа. Надад олон уруу татаат тохиолдоно, хэрэв би уруу татагдах юм бол олон хүн намайг даган уруу татагдана гэж миний патриархын адислалд өгүүлсэн байдаг. Би зөвхөн өөрийнхөө төлөө төдийгүй, намайг ширтэн харж байсан бусад хүмүүсийн төлөө зөв зам дээр байх хэрэгтэйгээ тэгэхэд ойлгосон юм. Тиймээс хантаазтайгаа байхаар шийдлээ.

Заримдаа намайг бусдын хийдэг л зүйлсийг хийдэггүйн төлөө шоолдог байсан ч би итгэлдээ үнэнч хэвээр үлдэж, үүнийхээ төлөө адислагдсан юм. Олон хүн надаас үлгэр жишээ авдаг байсныг би хожим нь мэдсэн. Зарим найз нар маань намайг жишүүдээ чанд баримталдаг байсныг хүндэлдэг байснаа ярьж билээ. Ахлах сургуульд байх

үед тэд бусдын хийдэг л зүйлийг хийдэггүй байсны төлөө намайг шоолж, зовоодог байсандаа уучлаа гуйсан.

Би Сүмийн жишүүдийг дагаж, бусдад үлгэр дуурайл үзүүлэхийг хичээдэг байсныхаа ачаар номлогчийн туршлагатай болж, сайн мэдээг бусдад заах боломжтой болсон билээ. Хэрэв би зөв зам дээр байгаагүй бол бусдад нөлөөлж чадахгүй байсан. ■



ХУВЦАСЛАЛТЫН ЖИШГҮҮД

“Даруу бус байдлаар хэзээ ч бүү хувцасла. Онцгой үйл явдлуудаар ч гэсэн даруу бус хувцаслаж болохгүй. . . . Залуу эмэгтэйчүүд . . . мөрөө ил гаргасан хувцас өмсөхөөс зайлсхийх ёстой.”

Залуучуудын бат бөх байдлын төлөө (товхимол, 2011), 6, 7.

Хувцаслалт ба гадаад төрх “АРИУН СҮНС УДИРДАГ”



Мэри Н.Кук

Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий ерөнхий-лөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Христийн төлөөлөгчид бид бие махбоддоо хүндэтгэлтэй хандаж, “ямар ч цагт, бүх зүйлд, мөн хаана ч гэсэн” жишигүүдээ чанд сахих ёстой.

Ким үргэлж даруу хувцасладаг. Саяхан би түүнээс даруухан даашинз, цамц, усан сэлэлтийн хувцас юу болох тухай түүний саналыг асуусан юм. Бид даашинзны зах, эмжээрийн хэмжээ ямар байхыг яг таг нарийн тодорхойлохын оронд даруухан хувцаслалтын зарчмуудыг болон үзэмжтэй сайхан харагддаг даруухан хувцас олоход тохиолддог бэрхшээлийн тухай ярилцав. Бид даашинзыг уртасгах тухай бүтээлч, асуудлыг хамтын оюун ухаанаар шийдэх яриа өрнүүлсэн нь хөгжилтэй болсон. Эцэст нь Ким “Би ямар нэг хувцсыг анх өмсөж үзэхэд л сэтгэлд нийцэхгүй бол энэ хувцас даруу биш бөгөөд өмсөхөд зохимжгүй гэдгийг мэдэрдэг” гэж хэллээ. Би даруухан хувцас худалдаж авч ерөөсөө сурахгүй нь бололтой. Дэлгүүрт үзсэн хувцсаа буцаагаад өлгүүрт нь өлгөчихдөг.”

Кимийг зохистой амьдрахыг хичээсэн үед өмсөх хувцсаа сонгоход нь Ариун Сүнс түүнийг удирдах болно. Тэр даруу байдлын жишгээр амьдардаг бөгөөд хувцаслалт, гадаад төрх байдлын дүрмийг өөрчлөхийг хичээдэггүй ажээ. Тэрээр бие махбод бол ариун сүм (1 Коринт 3:16-г үзнэ үү) гэдгийг ойлгодог бөгөөд бие

махбоддоо анхаарал тавьж, хамгаалан, зохих ёсоор хувцаслах үүргээ мэддэг.

Ариун сүмийг гадна болон дотор талаасаа үзэсгэлэнтэй сайхан харагдахаар, сайн хамгаалалттай байхаар бодож төлөвлөн барьдаг. Ариун сүмийн барилгыг төлөвлөхөд анхаарах гол зүйл бол энэ нь Их Эзэнийг *төлөөлдөг* бөгөөд Түүний өргөө гэдгийг ойлгох явдал юм. Бид ариун сүмийг зөвхөн зохистой хүмүүс ордог ариун барилга байгууламж гэж үзэн *хүндэтгэлтэй ханддаг*. Бидний оролцдог ариун нандин ёслолууд болон гэрээнүүд биднийг Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очих боломжтой болгодог учраас бид ариун сүмүүдэд хүндэтгэлтэй *ханддаг*.

Чиний бие махбод дэлхий дээрх хамгийн үзэсгэлэнтэй ариун сүмээс илүү үнэ цэнэтэй юм. Чи бол Бурханы хайртай хүү буюу охин нь! Бид бие махбоддоо хамгаас эрхэм ариун зүйл гэж үзэн хүндэтгэлтэй хандаж, дээд зэргээр анхаарал халамж тавьж, хамгаалж байх ёстой.

Их Эзэнийг төлөөлөх нь

Бид долоо хоног бүр ариун ёслолоос хүртэхдээ Аврагчийн нэрийг өөр дээрээ авдаг. Бид бол дэлхий дээрх Түүний төлөөлөгчид. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь удирдамжуудын нэгэнд: “Та нар хувцаслалт, гадаад төрхөөрөө дамжуулан бие махбод чинь хэчнээн их үнэ цэнэтэйг [Их Эзэнд] харуулдаг. Та нар Есүс Христийн шавь нар бөгөөд Түүнд хайртай гэдгээ харуулж чадна” хэмээн тэмдэглэжээ.¹

Нэг залуу эмэгтэй эдгээр үгсийг уншаад, даруу бус байдлын өчүүхэн ч илрэл гаргахгүй амьдрахаар шийдсэн ажээ. Тэр эмэгтэй тэр даруй хувцасныхаа шүүгээнээс Аврагчийн төлөөлөгч байхад зохимжгүй бүх хувцсыг гаргаж хаясан ажээ. “Өмсөх ёсгүй гэдгийг нь мэдэж байгаа ямар ч хувцсыг дэлгүүрт өмсөж үзэхгүй байх нь миний хувьд ухаалаг хэрэг болно. Яах гэж уруу татагдах юм бэ?” гэж тэр хэллээ. Их Эзэнийг төлөөлөх зарчим нь түүнийг ийм хатуу шийдвэр гаргахад хүргэжээ.

Хүндэтгэл

Христийн төлөөлөгчид бид “ямар ч цагт, бүх зүйлд, мөн хаана ч гэсэн” (Мозая 18:9) жишгүүдээ чанд баримтлах замаар бие махбоддоо хүндэтгэлтэй ханддагаа харуулж чадна. Зөвхөн цэвэр ариун хүмүүс ариун сүмд ордог байхыг Их Эзэн шаарддаг билээ. Ариун журамтай байх та нарын сонголт бол Их Эзэнд болон бие махбоддоо хүндэтгэлтэй ханддагийн нотолгоо мөн.

Бид бас бусдын биед хүндэтгэлтэй хандаж, ариун журмаар амьдрахад нь тэдэнд туслах ёстой. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард хэлсэн нь: “Залуу эмэгтэйчүүд хэт бариу, богинохон эсвэл доогуураа задгай оноотой хувцас өмсвөл, уулзаж учирдаг залуу эрэгтэйчүүдээ буруу ойлголт төрүүлж мэдэх төдийгүй эмэгтэй хүний үнэ цэнэ бэлгийн хүсэл таашаалаас бүхэлдээ хамааралтай байдаг юм шиг тэдэнд санагдуулж болно. Энэ нь Бурханы итгэлтэй охины зөв шударга байдлын илрэл хэзээ ч байгаагүй, байх ч үгүй.”²

Залуу эмэгтэйчүүд ээ, бие махбоддоо хүндэтгэлтэй хандахын хамт бусдад ялангуяа залуу эрэгтэйчүүдэд цэвэр ариун бодол санаа, үйлстэй байхад нь тусал. *Өдөр бүр* зөв шударга амьдрах нь та нарт *мөнхийн* үнэ цэнэ өгнө гэдгийг ойлгон, бие махбоддоо хүндэтгэлтэй хандагтун.

Хүндэтгэл

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс бидэнд ийн сургажээ: “Ариун сүмийн гаднах газар түүний дотор

болдог ёслолуудын ариун нандин чанар хийгээд хүндэтгэлтэй байдлыг бэлгэдэн харуулдаг бол бидний хувцаслалт бидний дотоод сэтгэлийн цэвэр ариун, сайн сайхан байдлыг тусган харуулдаг. Бидний хувцасласан байдал. . . ариун сүмийн ёслолууд хийгээд гэрээнүүдэд зохих ёсоор хүндэтгэлтэй ханддаг эсэхийг, бид тэдгээрийг хүлээн авахад биеэ бэлтгэсэн эсэхийг харуулдаг.”³

Ариун ёслолд оролцохдоо “Ням гаррагт өмсдөг хамгийн сайхан” хувцсаа өмсөж, Аврагчийн цагаатгагч золиослолд хүндэтгэлтэй ханддагаа харуул. “Залуу эрэгтэйчүүд ариун ёслолыг гүйцэтгэхдээ хүндэтгэлтэй хувцаслах ёстой.”⁴ Залуу эмэгтэйчүүд ээ, даруухан хувцаслацгаа.

Сэрцгээ! Гэртээ, сургууль дээрээ, далайн эргийн наран шарлагын газар, бүжиг эсвэл спорт тоглоомоор тоглохдоо даруу хувцаслалтын үлгэр жишээг үзүүл. Хувцсаа сонгох шийдвэр гаргахдаа Ариун Сүнсэнд өөрийгөө удирдах боломж олгодог Кимийн жишээг дагагтун. “Хэрэв би Их Эзэний дэргэд байгаа бол гадаад төрхөндөө сэтгэл зовохгүй байж чадах уу?” гэж өөрөөсөө асууж бай.”⁵

Хэрэв бид хувцсаа сонгохдоо Их Эзэний төлөөлөгч байж, хүндэтгэлийн энэхүү зарчмаар амьдрах юм бол Аврагчийн хайртай төлөөлөгчид та нар “урагш гэрэлтүүлэх” болно (Сургаал ба Гэрээ 115:5). ■

ЭШЛЭЛ

1. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 6.
2. М.Рассел Баллард, “Mothers and Daughters,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 20.
3. Роберт Д.Хейлс, “Modesty: Reverence for the Lord,” *Лиахона*, 2008 оны 8-р сар, 20.
4. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 8.
5. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 8.



ҮГЭЭР ХҮЧИРХЭГЖСЭН НЬ

*Өсвөр насныхан судрууд тэдэнд
зааж, тэднийг тайтгаруулж,
удирдсан тухай гэрчилдэг.*



СУДРУУД ХЭРЭГТЭЙ ҮЕД ТУСАЛДАГ

“Судрууд бол бидний оюун ухааныг гэрэлтүүлж, тэнгэрээс удирдамж, сүнсний нөлөөг урьдаг гэрэл лүгээ адил юм. . . . Судруудыг цээжилснээр агуу хүч ирж болно. Нэг судар цээжлэх нь нэг шинэ найзтай болсонтой адил юм. Энэ нь хэрэгцээ гарсан үед тусалж, сүнсний удирдамж, тайтгарал өгөн, шаардлагатай өөрчлөлтөд тус дөхөм үзүүлэх эх сурвалж болдог шинэ хувь хүнийг нээн илрүүлэхтэй адил юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, “The Power of Scripture,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 6.

Цээжилсэн судар нь тэдэнд тусалсан тохиолдлын тухай ярихыг бид залуучуудаас хүссэн юм хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт 2011 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр хэлжээ. Тэдний хариултаас доор нийтлэв.



Миний сэтгэл санаанд ирсэн амар амгалан

“Хүү минь, сүнсэнд чинь амар амгалан байг; саад тотгор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно” (С ба Г 121:7).

Олон жилийн турш надад хамгийн их тайтгарал өгсөн судар бол Бошиглөгч Иосеф Смит Либерти шоронд байхдаа Тэнгэрлэг Эцэгт хандан тусламж гуйсан залбирал болох Сургаал ба Гэрээ 121:7 юм. Би семинарт явж байхдаа энэ шүлгийг цээжилсэн бөгөөд тайтгарал хэрэгтэй болсон үед уг шүлгийг санадаг. Тэнгэр дэх Эцэг минь надад хайртай бөгөөд миний сорилт бэрхшээлүүдийг нэг бүрчлэн мэддэгийг энэ шүлэг надад сануулдаг. Сэтгэл санаа гонсгор, сул доройгоо мэдэрсэн үедээ амар амгалан байхын тулд би энэ шүлгийг ашигладаг.

Нэг удаа би тэнд байх ёсгүй нэг үдэшлэгийг орхиж гарахад энэ шүлэг надад тусалсан. Найз нар маань надад архи уух, тамхи татахыг санал болгоход би эелдгээр татгалзсан. Энэ шүлэг итгэл бишрэлийнхээ төлөө бат зогсоход хэрэгтэй хүч чадлыг өгч, хүнд шийдвэр гаргахад надад тусалсан юм. Би найзтайгаа таван жил үй зайгүй нөхөрлөж байлаа. Бид хоёр хамт спортоор хичээллэж, аялалд хамт яван, долоо хоногийн амралтын өдөр бүрийг хамт өнгөрүүлдэг байлаа. Гэтэл найз маань арай

ахмад насны өөр найз нартай болж, тэдэнтэй хамт цагийг өнгөрүүлдэг болсон бөгөөд би тэдэнтэй хамт байхыг хүсдэггүй байлаа. Эцэстээ би түүнтэй найз хэвээр үлдэх үү эсвэл Мэргэн Ухааны Үг болон ариун явдлын хуулийн талаарх итгэлээсээ няцах уу гэдгийн аль нэгийг сонгоход тэр намайг хүргэсэн билээ. Иймд би их гутарсан. Итгэдэг зүйлийнхээ төлөө бат зогсох нь ийм хэцүү байх юм гэж би огт мэддэггүй байжээ. Гэвч би шинэ найзуудтай болохоор сонгож, бүх зүйл сайн сайхан болно хэмээн Иосеф Смитэд өгсөн Тэнгэрлэг Эцэгийн амлалтыг дотроо үргэлж санадаг байлаа.

Итгэл бишрэлээсээ няцахаас дор юм байдаггүй. Иймээс би зөвийг сонгосноороо жинхэнэ бөгөөд өнө удаан үргэлжлэх баяр баясгаанг мэдэрсэн билээ. Энэ судар миний гэрчлэлийг бэхжүүлж, хэрэг болсон үед надад тусалсан юм.

Лорен Ж.

нас 16, Арканзас, АНУ



Сул дорой зүйлүүд хүчирхэг болдог.


Хэдэн сарын өмнө ахлах сургуулийн элсэлтийн шалгалт болоход би шалгалтанд бэлтгээгүйгээ мэдэрсэн. Шалгалтаа сайн өгөх боломжгүй гэдгийг би мэдэж байлаа. Тиймээс би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирлаа. Намайг залбирч байхад дараах судрын үгс санаанд минь орж ирсэн: “Хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно. Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө (Ифер 12:27).

Тулгарсан сорилт бэрхшээлийг даван туулах хүч чадлын төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахад Тэр намайг адисалж, сул талаа ялахад тусалдгийг би мэдсэн билээ. Их Эзэнд асуудлаа танилцуулах нь миний гаргаж чадах хамгийн зөв шийдвэр байлаа. Тэр бол хамгийн гарамгай багш. Тиймээс Тэр надад тусалсныг би мэднэ.

Ирвин О.

нас 16, Эль Сальвадор

ГЭРЭЛ ЗУГУУДЫГ ХОСУЭ А.РЕНА БОЛОН ГЛОРИА ХАВАТ



Байнга залбир

“Ялан дийлэгч болж гарахын тул чи ямагт залбир; тийм ээ, чи Сатаныг ялж гарахын тулд, мөн түүний ажлыг дэмжиж байдаг Сатаны зарц нарын гараас зугтаахын тулд буюу”
(С ба Г 10:5).

Энэ шүлэг надад уруу таталтыг эсэргүүцэхэд тусалдаг. Би хийх гэж байгаа ямар нэг зүйлээ буруу гэдгийг мэдсэн үед энэ шүлэг болон түүний захиас миний санаанд орж ирдэг. Энэхүү өдөөлтийн дараа би залбирах бүрдээ тулгарсан уруу таталтыг даван туулахад хэрэгтэй тусламжийг хүлээн авдаг.

Жесс Ф.

нас 17, Юта, АНУ

Би чамтай хамт байна

“Зовлон зүдгүүрүүдэд тэвчээртэй байгтун, учир нь чамд эдгээр нь олон байх болно; гэвч тэдгээрийг тэсвэрлэ, учир нь, харагтун, би чамтай бүр чиний өдрүүдийн төгсгөл хүртэл хамт байх болно”
(С ба Г 24:8).

Энэ судрыг цээжилсэн нь ялангуяа айдас төрж, ганцаардсан үед надад адислал болдог. Энэ шүлгийг санасан үед би зориг орж, санаа сэтгэл сайхан болдог. Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд бидэнд ялангуяа хүнд сорилт бэрхшээл тулгарсан үед удирдамж, дэмжлэг хэрэгтэй байдаг. Зарим үед ирээдүй бүрхэг буюу урам хугармаар байхад ч гэсэн Их Эзэнд итгэж, Түүний халуун тэврэлтийг мэдэрч чадна гэдгийг би мэднэ.

Намайг бага байхад хэрэв би хийх ёстой зүйлээ хийвэл Их Эзэн үргэлж миний дэргэд байх болно гэдгийг гэрт болон Хүүхдийн Хэсэгт надад заадаг байлаа. Надад ингэж заадаг байсан болохоор бас энэ судрын ачаар би Түүнд үргэлж итгэн найдаж болно гэдгийг мэдсэн билээ.

София И.

нас 15, Уругвай



ЗОРИЛГО ТАВЬ

Судар цээжлэх зорилго тавин, түүнийгээ хэрэгжүүл. Та нар семинарт төгс эзэмших судрын шүлгүүдийг эсвэл Бурханы өмнө хүлээсэн үүрэг буюу Хувийн хөгжил дэвшлийн нэг хэсэг болгон судрын шүлгүүдийг цээжилж болно.

ШУЛУУН БӨГӨӨД НАРИЙН **ЗАМ**

Олон янзын зам байдаг ч зөвхөн ганцхан
нь мөнх амьдрал өөд хөтөлдөг.

(2 Нифай 9:41; 31:17-21-ийг үз; Alma 7:9-ийг үз.)



Хүүхдийн Хэсгээс

Залуу Эрэгтэйчүүд эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн ангид дэвшин шилжих үед та нарт хэрэг болох зарим зүйлийн тухай доор өгүүлэв!

ЗАЛУУ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ТУХАЙ ТА ЮУ МЭДЭХИЙГ ХҮСЧ БАЙНА ВЭ?

Аароны санваартнууд Аврагчийг төлөөлөн бусдад үйлчилдэг

Ариун ёслолыг түгээх
Мацгийн өргөлийг цуглуулах
Гэр бүлээ бэхжүүлэх

Бурханы өмнө хүлээсэн үүрэг


Шинэ зүйлүүдийг сурч, хий
Бусадтай хуваалц
Тэнгэрлэг Эцэгтэйгээ ойр дотно харилцааг хөгжүүл

Залуучуудын бат бөх байдлын төлөө

Өөрийг чинь бат бөх итгэлтэй болгох жишгүүд

Өөрийгөө бэлтгэх

Номлолд бэлтгэх
Гэрлэж, эцэг болоход өөрийгөө бэлтгэх



Ариун сүмд орох

Нас барсан хүмүүсийн өмнөөс баптисм хүртэх
Гэрээнүүд хийхэд бэлтгэх
Ариун Сүнснийг мэдэрдэг байх

Үйл ажиллагаа

Чуулгатайгаа хамт үйлчлэх
Мючел хөгжилтэй!

Хүүхдийн Хэсгийн эрхэм хүндэт залуу эрэгтэйчүүд ээ,

Та нар 12 нас хүрсэн үедээ Аароны санваар авах болно. Энэ бол маш чухал зүйл. Бурхан Өөрийн санваарыг өгөхдөө та нарт итгэдгээ хэлэх болно. Аврагчийн үйлчилж байсны адилаар бусдад үйлчлэх нь та нарын ариун үүрэг байх болно.

Энэхүү санваарыг авахад бэлтгэх цаг одооноос эхэлж байна. Тойрог буюу салбарын чинь санваартнууд ариун ёслолыг хэрхэн адислан түгээж байгааг, хэрхэн баптисм хүртээж, адислал өгч байгааг, номлолд хэрхэн үйлчилж, гэр бүлээ хэрхэн удирдаж байгааг харж, тэдний яриаг сонс. Сайн мэдээний жишгүүдээр амьдрахын тулд үргэлж чадах бүхнээ хий. Ингэсэн тохиолдолд та нар Аароны санваар авах тэрхүү агуу өдөрт бэлтгэгдэх болно.



Хүндэтгэсэн:

Давид Л.Бек

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

ШИЛЖИН ДЭВШИХ НЬ

ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУХАЙ ТА ЮУ МЭДЭХИЙГ ХҮСЧ БАЙНА ВЭ?

Шинэ найз нар

Хамтдаа хөгжилтэй суралцах
Бие биеэ дэмжих

Үйл ажиллагаа

Хамтран үйлчлэх нь
Мючел хөгжилтэй!

Есүс Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэх

Үнэн ба зөв шударга ёсны төлөө тэмцэх
Гэрчлэлээ хуваалцах

Өөрийгөө бэлтгэх

Бурханы охины хувьд
Удирдагч болон сайн үлгэр
жишээ болох
Үнэнч эхнэр болон ээж
болох

Залуучуудын бат бөх байдлын төлөө

Өөрийг чинь бат бөх итгэлтэй болгох
жишгүүд

Хувийн хөгжил дэвшил

Сурах шинэ зүйлүүд
Зорилт тавих болон ёс суртахуунтай байх

Ариун сүм рүү явах

Нас барсан хүмүүсийн өмнөөс баптисм
хүртэх
Ариун Сүнснийг мэдэрдэг байх
Гэрээнүүд хийхэд бэлтгэх



Хүүхдийн Хэсгийн эрхэм хүндэт залуу эмэгтэйчүүд ээ,

Та нарын Залуу Эмэгтэйчүүдийн ангид дэвшин шилжих өдрийг бид сэтгэл догдлон хүлээж байна! Та нар бол Тэнгэрлэг Эцэгийн үнэ цэнэтэй охид. Та нар Залуу Эмэгтэйчүүдийн ангид шилжиж очоод ямар ч цагт, бүх зүйлд мөн бүх газарт Түүний гэрчлэгч болон зогсох болно. Та нар үнэн ба зөв шударга ёсны төлөө зогсож, Аврагчийн гэрлийг бүх дэлхийд цацруулах ёстойг сануулах хүзүүний зүүлт хүлээн авна. Хувийн хөгжил дэвшлийн ном судар судлах, хувийн зорилго тавьж ажиллах болон ариун сүмд орох бэлтгэлээ хангахад чинь та нарт туслах болно. Эдгээр бүх зүйл эхнэр ба эх, дэлхий дэх агуу удирдагч болоход тань та нарыг бэлтгэх болно.

Хүндэтгэсэн:

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч
Элайн С.Далтон



© BUSATH PHOTOGRAPHY/ИЙНГЭРЛЭГ

Эрхэм хүндэт Амига

Сайн байна уу? Мексикээс мэндчилж байна! Би чиний захидлыг хүлээж аваад бас төрсөн өдөр чинь ойртож байгааг сонсоод сэтгэл их хөдөлмөө. Хүүхдийн Хэсгээс шилжих гэж байгаадаа сэтгэл чинь бага зэрэг гонсгор байгаа юм шиг санагдлаа. Би Залуу Эмэгтэйчүүдийн ангид шилжин ирсэн тухайгаа чамд дурдаж болох уу?

Би ч бас Хүүхдийн Хэсгээс шилжихдээ сандарч байсан. Олон найзтай болж чадахгүй байх гэж би санаа зовж байлаа. Хамгийн ахмад охидын нэг биш, харин хамгийн балчир охидын нэг байх болсондоо би эмээж байлаа. Гэтэл бүх юм сайхан болсон. Миний төрсөн өдрийн өмнө бишоп надтай ярилцага хийж, өөрчлөлт нь сайн зүйл байх болно гэж хэлсэн. Ням гараг болоход би ичиж, Хүүхдийн Хэсгийн өрөөндөө байж байлаа. Аз болоход Залуу Эмэгтэйчүүдийн удирдагчдын нэг нь намайг тэндээс олсон. "Чамайг энд байгаа гэж би бодсон нь үнэн байна! Нааш ир, хичээлдээ орох цаг болмоо"

гэж тэр хэлж билээ.

Диаз эгч нээлтийн үйл ажиллагаан дээр надад баяр хүргэж, Залуучуудын бат бөх байдлын төлөө, Залуу Эмэгтэйчүүдийн Хөгжил Дэвшил товхимлууд, өдрийн тэмдэглэл гэсэн гурван номыг надад өгсөн. Би энэ номнуудад дуртай болсон. Би өрөөг тойруулж хараад, Хүүхдийн Хэсэгт байсан зарим охид энд байхыг харлаа. Миний танихгүй охид сайн байна уу гэж надтай мэндлэв. Удалгүй би айж эмээхийн оронд амар амгаланг мэдэрлээ.

Үүний дараа бүх зүйл хэвийн боллоо. Мючелийн үйл ажиллагаа сайн мэдээгээр хэрхэн амьдрах болон гэр бүл, найз нөхдөдөө хэрхэн туслахыг заасан учраас надад маш их хэрэгтэй байлаа. Мөн жил бүр аялаар явах нь хэчнээн хөгжилтэй байдаг гээч! Одоо би Лаурел ангид байгаа. Хувийн Хөгжил Дэвшил лээ удахгүй дуусгана гэдэгт итгэлтэй байна. Би Залуу Эмэгтэйчүүдийн медалца зүүхийг тэсч ядан хүлээж байна. Энэ медаль өнгөрсөн жилүүдэд би Тэнгэрлэг Эцэгтээ хэр зэрэг ойртон өсч хөгжсөнийг надад сануулах болно.

Иймд миний найз битгий айгаарай. Цоглог жавхаатай байж Залуу Эмэгтэйчүүдэд оч. Тэнд очсондоо харамсахгүй гэдгийг би чамд амлаж байна.

Хайртай шүү,
Марибел

Амьдралынхаа нэгэн шинэ үеийг баяртай угтаарай

Марисса Виддисон

Сүмийн сэтгүүлүүд

МОДОД ӨВӨЛД бэлтгэн өнгөө өөрчилдөг газарт та нар амьдардаг уу? Энэ дөрвөн найз тийм газарт амьдардаг юм. Ноа Б., Дайлан Л., Патрик М., Бен М. дөрөв Канадын зүүн эргийн Хунтайж Эдвардын арал дээр амьдардаг. Энэ дөрвөн хөвгүүн модод өнгөө өөрчилдөг лүгээ адил шинэ амьдралдаа бэлтгэж байна. Тэр дөрөв нэг жилийн дотор 12 настай болж байгаа бөгөөд Хүүхдийн Хэсэгт баяртай гэж хэлэн Залуу Эрэгтэйчүүдэд сайн байна уу хэмээн хэлнэ гэсэн үг юм. Өсч том болон, Залуу Эрэгтэйчүүдийн ангид дэвшин орох болсон талаараа тэдний юу ярьсныг сонирхъя.

Өөрийнхөөрөө бай

Ноаг энд шилжин ирэхэд шинэ найз нар нь түүнд арал дээрх амьдралдаа дасан зохицоход тусалсан ажээ. Одоо тэр нөгөө гурваасаа арай ахмад учраас Залуу Эрэгтэйчүүдийн ангид дасан зохицоход тэдэнд тусалж байна. “Бусад залуу эрэгтэйчүүд намайг яаж хүлээн

авах бол, тэдэнтэй хэрхэн танилцах талаар миний санаа зовж байлаа” хэмээн Залуу Эрэгтэйчүүдийн тухай яригаа эхэллээ. “Үйл ажиллагаануудад оролцсон нь надад үнэхээр тусалсан.” Ноа Хүүхдийн Хэсэгт байхдаа Хиламаны армийн тухай дуунд дуртай байжээ. Залуу Эрэгтэйчүүдэд шилжиж ирээд, санваартны чуулга нь хэчнээн их эв нэгдэлтэйг тэр харжээ.

Тэр юу гэж зөвлөв? “Өөрийнхөөрөө бай.”

Санваараа хүндэл

Патрикийн хувьд санваар авах нь тодорхой насанд хүрэх явдал биш ажээ. Энэ бол зохистой байж, санваар авахад бэлтгэгдсэн байна гэсэн үг. “Бид 12 хүрсэн учраас л санваар авдаггүй. Харин санваар авахад бэлтгэгдсэн байх ётой” гэж Патрик хэллээ.

Бэлтгэл хэчнээн чухал болохыг Дайлан ойлгодог ажээ. Тэр ариун ёслолыг түгээхэд сүнслэг байдлын хувьд бэлтгэхийн тулд сүм дээр 15 минутын өмнө ирэхийг хичээдэг. “Би ариун ёслолыг гурав, дөрвөн удаа түгээх бүрд Сүнс миний зүрх сэтгэлд нөлөөлсөн. Урьд нь надад


хэзээ ч тийм мэдрэмж төрж байгаагүй” гэж тэр яриу.

Ариун ёслолыг түгээх нь надад Сүүлчийн Зоогийг санагуулдаг: “Есүс тэнд зогсож байгаа юм шиг, Есүсийн зогсож байгаа газарт бид зогсож байгаа юм шиг, Тэр биднийг тэнд ирэхийг хүсэх мэт санагддаг” гэж Бен ярилаа.

Ариун сүм рүү хар

Бен Бурханд Итгэх Итгэлийн Шагналаа авахаар ажиллаж байгаа аж. Бас нас барагсдын төлөө анх удаа баптисм хийлгэхээр тэсч ядан хүлээж байна. “Би ариун сүмийн дотор орж үзээгүй байгаа. Гэвч бусад хүмүүс ариун сүмд орсны дараа тэнд хэчнээн сайхан, дулаан бүлээн мэдрэмж төрсөн тухай гэрчлэлээ үргэлж хуваалцдаг” гэж Бен яриу.

Ноа саяхан анх удаа ариун сүмд яваад ирсэн ажээ. Чуулгынх нь залуу эрэгтэйчүүд түүнийг гэр бүлийнхээ гишүүн шиг үзэж ханддаг хэмээн тэр хэллээ. “Заримдаа чи сандарч мэднэ. Гэвч чамд туслах хүмүүс бэлэн байх болно” гэж тэр хэлэв. “Чамд маш сайхан байх болно.” ■



Их Эзэн Есүс Та ирээч

Энгийнээр ♩ = 72-84

Savior of the World: His Birth and Resurrection
Сүмийн бүтээлээс



1. Э - зэн Е - сүс би - дэнд и - рээч, Ма - лын са - рав - чинд и - рээч.
2. Э - зэн Е - сүс, өв - дөг нь сө - хөрч Зүрх нь ш - анал - санд и - рээч.
3. Э - зэн Е - сүс, А - гуу Ав - рагч Дор - ноос ман - дах их гэ - рэл.

А - гуу бү - тээгч Та хүү бо - лон Яд - маг энэ га - зар мэнд - лээч.
Эг - нэш - гүй хай - раа - раа бид - нийг Өө - рийн ам - рал - танд а - ваач.
Эг - нэгт та - ны хүүх - дүүд бол - ёё, Ну - лимс - ийг минь ха - таа - гаач.

Ха - ран - хуйн үүлс - ийг хөө - хөөр Им - ман - уул, Та энд и - рээч.
Энэ ер - төн - цийг за - хир - хаар Ал - дар суун - даа Та зал - раач.
Энэ ер - төн - цийг за - хир - хаар Ал - дар суун - даа Та зал - раач.

Ма - лын са - рав - чинд и - рээч Та, Ав - рагч Их Э - зэн.
Уг - тах бид - ний - гээ бэлт - гээч Та, Ав - рагч Их Э - зэн.
Уг - тах бид - ний - гээ бэлт - гээч Та, Ав - рагч Их Э - зэн.

Savior of the World: His Birth and Resurrection нь Тэргүүн Зөвлөл болон
Арванхоёрын чуулгын удирдлага дор туурвигдаж шүлэглэгдсэн.

© 2003 IRI. Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү дууг ашгийн бус зорилгоор гэрт болон
сүм дээр ашиглахаар хуулбарлан олшируулж болно. Энэ тэмдэглэл хуулбар бүр дээр байх ёстой.



Энэ сэдвээр
Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын Ахлагч
Даллин Х.Өүкс
бодлоо хуваал-
цаж байна.

**Би хаана амьдарч
байгаагаасаа үл
хамааран
ЕСҮС ХРИСТИЙГ
ИТГЭЛЭЭР дагах
НЬ ЯАГААД
ЧУХАЛ ВЭ?**



Есүс Христ бол Бурханы
Хайртай Төрсөн Ганц Хүү.



Тэр бол бидний Бүтээгч.
Тэр бол Дэлхийн Гэрэл.
Тэр бол биднийг үхэл,
нүглээс Аврагч.



Энэ бол дэлхий дээрх
хамгийн чухал мэдлэг
бөгөөд та нар үүнийг
өөрөө мэдэж болно.



Бид Есүс Христийн
дагалдагчид. Дундын
сонголт гэж байхгүй.



"Teachings of Jesus (Есүсийн сургаалуудаас),"
Лиэхона, 2011 оны 11-р сар, 93.

Санваарын адислалууд бүх хүмүүст боломжтой

Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.




бусад санваартнууд өгдөг. Бид Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очихын тулд санваарын тодорхой адислалуудыг авах ёстой. Усанд умбуулалтаар хийх баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах, гэр бүлүүдийг лацдан холбодог ариун сүмийн хосгүй нандин ёслолууд эдгээр ёслолуудад орно. Ариун сүмд бас сайн мэдээний адислалуудыг авалгүйгээр нас барсан хүмүүсийн төлөө ёслолуудыг гүйцэтгэж болно. Санваарын адислалууд бүх хүмүүст боломжтой! ■

Иосеф Смит Мормоны Номыг орчуулж байх үед түүнд болон бичээч Оливер Каудерид нэг асуулт тулгарчээ. Тэд энэ тухай залбирахаар ойруу очив. Тэднийг залбирч байх үед “тэнгэрээс нэгэн элч гэрэлт үүлэн дотор доош буун иржээ.” Энэ элч Иохан Баптисст байв.

Тэрээр Иосеф Оливер хоёрын толгой дээр гараа тавин тэдэнд Аароны санваар олгожээ. Тэгээд Иохан Баптисст Иосеф Оливер хоёрт бие биендээ баптисм хүртээхийг зарлиг болгов. Үүнээс хойш удалгүй Төлөөлөгч Петр, Иаков, Иохан нар дэлхийд ирж, Иосеф Оливер хоёрыг Мелкизедек санваарт томилжээ. Бурханы санваар дэлхий дээр дахин бий болов. (Иосеф Смит–Түүх 1:68–72-г үз.)

Бид санваараар дамжуулан гайхамшигтай адислалууд болон ёслолуудыг хүлээн авдаг. Ийм адислалуудыг шинээр төрсөн хүүхдүүд, өвчтэй хүмүүст өгдөг бөгөөд хүүхдүүдэд тэдний аав нар эсвэл зохистой



Дуу ба судар

- *Children's Songbook (Хүүхдийн Дууны Ном)*-оос санваарын тухай нэг дууг сонго
- Сургаал ба Гэрээ 84:35

ЗС ҮЙЛ АЖИЛЛАГАА Санваар хүмүүст тусалдаг

Бурханы санваар бол ёслол болон адислалуудаар дамжуулан хүмүүст үйлчилж, тэднийг адислах хүч мөн. Доорх зургуудад өөрийгөө оруулан зур.



Санваартнууд ариун ёслолыг адисалж, түгээдэг. Өөрийгөө ариун ёслол түгээхэд бэлэн болж, сандал дээр сууж байгаагаар зур.



Санваарын адислалаар өвчтэй хүмүүсийг адисалж болно. Өөрийгөө бие тааруухан, оронд хэвтэж байгаагаар зур.

Зөвхөн чи

Агуу Үнэт Сувдаас Иосеф Смит—Түүх 1:68–73-ыг унш. Эдгээр шүлгүүдийг доорх хоосон зайг бөглөхөд ашигла. Цаасны нөгөө тал дээр эдгээр шүлгүүдийг уншсанаар мэдсэн бусад зүйлсийг тэмдэглэ.

1. "Аароны санваар нь . . .
_____ тохинууллын хийгээд _____ сайн мэдээний түлхүүрүүдийг атгадаг."
2. _____ баптисм хүртсэн анхны хүн байлаа.
3. Оливер Каудери _____-д баптисм хүртээв.
4. Иохан Баптист _____, _____ нарын удирдлага дор _____ ажиллажээ.
5. Хожим нь Петр, Иаков, Иохан нар _____ Иосеф Оливер хоёрт _____ санваар хүртээв.



Гэр бүлүүд ариун сүмийн ёслолуудаар дамжуулан хамтдаа лацдан холбуулж болно. Гэр бүлээ ариун сүмийн өмнө байгаагаар зур.



Баптисм болон Ариун Сүнсний бэлэг хүлээн авах нь санваарын ёслол юм. Өөрийгөө баптисмын сангийн өмнө зогсож байгаагаар зур.

Харуулт: 1. тэнгэр элчүүд, Иохан; 2. Оливер Каудери; 3. Иосеф Смит; 4. Петр, Иаков, Иохан; 5. Мелкизедек.

Хоёр дахин их адислал

Мадагаскарын Антананаривогийн Софи, Флоди А. нартай танилцана уу.

Ричард М.Ромни

Сүмийн сэтгүүлүүд

Арван настай ихэр охид Софи, Флоди нар Мадагаскарт амьдардаг. Мадагаскар бол Африкийн эргээс холгүй орших том арал юм. Софи, Флоди нарын гэр бүлд тэдний ярих дуртай, нэг үнэн түүх байдаг ажээ. “Манай аав номлогчидтой анх уулзангуутаа л Сүм үнэн гэдгийг мэдсэн. Аав их түргэн хөрвөсөн” гэж Флоди хэллээ. Ээж нь хэдэн сарын дараа баптисм хүртжээ.

Ихрүүдийг төрөхөөс өмнө аав, ээж хоёр нь охинтой болохын төлөө мацаг барьж, залбирдаг байж. “Ингээд ээж минь нэг биш, харин хоёр охинтой болсон юм” гэж Софи ярилаа.


Энэ чинь хоёр дахин их адислал шүү дээ! ■



Софи Флоди хоёрын гэр бүл Өмнөд Африкийн Иоханнесбургийн Ариун сүмд очиж, хамтдаа лацдан холбуулахын тулд гурван жил мөнгө хадгалжээ. Тэд ариун сүмд очихын тулд Энэтхэгийн далайг гатлан 2100 гаруй км аялах шаардлагатай байлаа.



Охидын ээж нь гэрийнхээ дэргэд хувийн эмнэлэгтэй ажээ. Тэд эмнэлгийн шалыг шүүрдэж, цэвэрхэн байлгахад тусалдаг гэнэ.



Мадагаскарын төрийн далбааны цагаан өнгө нь цэвэр ариун байдлыг, улаан нь тусгаар тогтнолыг, ногоон нь итгэл найдварыг бэлгэддэг ажээ.



Софи Флоди хоёр тус бүрдээ нэг мууртай бөгөөд муураа тэвэрч илэх дуртай гэнэ.



Лемур, хамелеон хоёр бол Мадагаскарт байдаг амьтад.



Ихэр охид хоёр ах, зээ дүү, аав, ээж нарынхаа хамт гэр бүлийн үдшээ хийх дуртай.

Би бас БАПТИСМ ХҮРТЭЖ БОЛОХГҮЙ ГЭЖ ҮҮ?

“Хүүхдүүд нүглүүдийнхээ ангижралын тулд найман настайдаа баптисм хүртэх ёстой” (С ба Г 68:27).

Нано, Мириам хоёр оо, та нар Есүс Христийн үлгэр жишээг дагаж, дараагийн хагас сайнд баптисм хүртэх үү?” гэж систер Сильва асуув.

Пауло сонссон зүйлдээ итгэж ядан байв. Номлогч систерүүд саяхан 10 настай ах, эгч хоёрыг нь баптисм хүртэхийг урилаа шүү дээ!

“Тэгье! Тэгье!” гэж ихрүүд баяртайгаар хэллээ.

Мириам инээмсэглэсээр байлаа. Нано систер Лопестой таван удаа алгаа нийлүүлэн ташлаа. Эмээ нь өрөөний булан дахь том улаан буйдан дээрээсээ инээмсэглэлээ.

Систер номлогчид Пауло болон түүний ах, эгч нарт эмээгийнх нь гэрт хэдэн долоо хоног сайн мэдээг заасан бөгөөд эмээгийнх нь гэр Сан Мигель хэмээх Португалиас 1600 км зайд байрладаг салхи ихтэй ногоон арал дээр байдаг ажээ. Пауло эмээгийнхээ үүдний хаалганы дээд хэсгийг талд нь хүртэл онгойлгон, далайн сэвэлзсэн салхиар амьсгалан, өөрт нь сайн мэдээг заахаар гудамж өгсөн ирж яваа систер Лопес, Сильва нарыг харах дуртай байлаа.

Өнөөдөр онцгой хичээлтэй хэмээн номлогчид хэлжээ. Яагаад гэдгийг Пауло мэджээ. Нано Мириам хоёр яг Есүсийн зааснаар баптисм хүртсэн шүү дээ! Пауло бас Аврагчийн үлгэр жишээг дагахыг хүсч байлаа.

“Систерүүд ээ, би бас дараагийн хагас сайнд баптисм хүртэж болох уу?” гэж тэр зурагтай Мормоны Номоо барьж, тэсч ядсан байдалтай асуулаа.

Систер Сильва инээмсэглээд толгой сэгсрэв. “Уучлаарай, Пауло. Бид бүгдээрээ баптисм хүртэх хэрэгтэй ч зөвхөн найман нас хүрсний дараа л баптисм хийлгэж болно гэж Их Эзэн хэлсэн юм. Чи дөнгөж зургаатай учраас ийм сонголт хийх арай болоогүй байна.”

“Гэвч систерүүд ээ, би залбирч, Мормоны Номыг гэрийнхэнтэйгээ хамт уншсан ш дээ. Та хоёрын хичээл надад таалагдсан. Би эмээ, авга ах Мариотой хамт долоо хоног бүр Хүүхдийн Хэсэгт явдаг. Сүм үнэнийг би мэднэ! Би Нано Мириам хоёртой хамт баптисм хүртэж болохгүй гэж үү?” хэмээн Пауло зөрүүдлэв.

“Чи зарлигуудаар амьдарч, сайн мэдээнээс суралцсан чинь маш сайн хэрэг. Гэвч чи баптисм хүртэх хүртлээ дахиад хоёр жил хүлээх хэрэгтэй” гэж систер Лопес хэллээ.

Паулогийн хоолой халуу оргиж, нүднээс нь нулимс дусалж эхлэв. Тэр үсэрч босоод ах эгч нартайгаа





унтдаг дээврийн өрөө рүүгээ гүйлээ.

Пауло дэрэндээ нүүрээ нааж, хэдэн минут уйлсны дараа дээврийн шатаар нэг хүн өгсөн ирэхийг сонслоо. Авга ах Марио хүрч ирэн Паулогийн орон дээр суув.

“Юу болоов, Пауло?” гэж авга ах нь асуув.

“Систер Сильва, Лопес нар намайг баптисм хүртэж болохгүй, харин Нано Мириам хоёрыг болно гэсэн. Би Сүмийн гишүүн болмоор байна ш дээ! Би ариун ёслол дээр сүмийн дуулал дуулж, Хүүхдийн Хэсэгт судруудыг судлах дуртай. Би бусдаас хоцрохыг хүсэхгүй байна” гэж Пауло хэллээ.

“Пауло, чи баптисм хүртэх насанд хүрээгүй ч, Сүмийн нэг хэсэг шүү дээ” гэж авга ах Марио нь эелдэгхэн хэлэв.

“Яаж?” гэж Пауло хэлээд дэрэндээ шургав.

“Хүүхдийн Хэсэг ариун ёслолын цуглааны хөтөлбөр бэлтгэдгийг чи мэднэ шүү дээ. Танай Хүүхдийн Хэсгийн багш энэ хөтөлбөрт сайн дураараа гэрчлэлээ хэлэх хүүхдүүдийг хайж байгаа гэж надад хэлсэн. Энэ бол чиний хувьд сүмд оролцох нэг арга зам” гэж авга ах Марио ярилаа.

“Тийм гэж үү?” гэж хэлээд Пауло босч суугаад авга ахынхаа өөдөөс харав. Тэр минут хэртэй бодлоо. “Би Нано Мириам хоёрын баптисм дээр гэрчлэлээ хэлж болно шүү дээ!”

“Энэ чинь ёстой мундаг санаа!” Чи баптисм хүртэх насанд хүрээгүй ч, гэрчлэлээ хэлж болно шүү дээ” гэж авга ах Марио хэллээ.

Пауло орноосоо үсрэн босч, шатаар хурдан буув.

“Пауло чи хаачих нь вэ?” гэж авга ах Марио дуудлаа.

“Би гэрчлэлээ хэлэх дадлагыг

номлогчидтой хийхээр явлаа!” гэж Пауло баяртайгаар хэллээ. “Би баптисм хүртэхээр хүлээх зуураа гэрчлэлээ хуваалцах болно!” ■



“Тэвчээр бол идэвхтэйгээр хүлээн, тэвчих явдал мөн. Энэ нь бид ямар нэг зүйлийг хүлээх үедээ ажиллах, итгэж найдах, итгэлээ ашиглах зэргээр чадах бүхнээ хийх хэрэгтэй гэсэн үг юм.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, “Continue in Patience,” Лиакона, 2010 оны 5-р сар, 57.

Дикон шиг хувцасласан нь

Хилари М.Хендрикс


Бодит түүхээс сэдэвлэв.




5.

Би цагаан цамц, гоё өмд
өмсөөр байна. Би дикон шиг
хувцаслахыг хүсч байна.

Ээж нь Элид гоё өмд, цагаан цамц
өмсөж, зангиа зүүхэд нь туслав.



6. Эли сүм дээр диконууд ариун ёслол түгээж
байгааг хараад гараа нугалав.



7. Нэг дикон Элид ариун ёслолыг авчирч өгөхөд тэр жижигхэн
талхны үйрмэг авч тосгуурыг ээждээ өгөв.

8. Ээж нь Эли рүү хараад инээмсэглэв.
Эли ээждээ ариун ёслолоос хүртэ-
хэд нь тусалсандаа баяртай байлаа.
Дикон болчихсон юм
шиг л түүнд санагджээ.



НУУСАН ЗУРГУУД

Эли дикон шиг хувцаслахыг хүсчээ. Дикон шиг хувцаслахад нь туслах зүйлсийг өрөөнөөс нь олж, түүнд тусална уу.



БУДАХ ХУУДАС



Бид санваараар дамжуулан авралын ёслолуудыг хүлээн авдаг.

“Мөн тэрчлэн энэхүү санваарыг хүлээн авдаг тэд бүгд намайг хүлээн авдаг хэмээн Их Эзэн хэлдэг” (С ба Г 84:35).

Сүмийн мэдээ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org -аас үзнэ үү.

Бразилийн залуус гэр бүлийн түүхийг ариун сүмийн ажилтай холбож байна

Мелиса Меррилл

Сүмийн мэдээ ба үйл ажиллагаанууд

Хосе А. Москао нэгэн өөрчлөлт хийх хэрэгтэйг ойлгов: Бразилийн Кампинас ариун сүмд ирж буй залуус ёслолуудад оролцох хоорондоо маш их цагийг дэмий сууж, хүлээж өнгөрөөдөг байв.

Ариун сүмийн ойролцоох гэр бүлийн түүхийн төвийн захирал Москао ах ариун сүм хол учраас маш олон залуус ариун сүм рүү олон хоног аялах хэрэгтэй болдог ба ихэвчлэн бүлэг болон явж, тэндээ хэдэн өдөр хоноглодог гэдгийг мэддэг ажээ. Баптисмд оролцох, хоол идэх мөн ариун сүмд ёслолуудыг хийлгэж буй эцэг эх, удирдагчдаа хүлээх хооронд тэдэнд цаг их гардаг.

Тиймээс тэдгээр залууст чөлөөт цагаараа ариун сүмийн эргэн тойронд зугаалах боломж олгох хэрэгтэй гэж тэр боджээ.

Тэр бодлоо үйлдэл болгожээ.

Урилга

Тэр залуусыг гэр бүлийн түүхдээ урьж, тэдэнд хэрхэн FamilySearch индексжүүлэлтийг хийхийг зааж эхэлсэн гэнэ.

Эхлээд залуусын зарим нь ичиж, халширч байсан байна. Гэсэн ч Москао ах амьд бошиглогчдын үгст дуулгавартай байж, хүмүүсийг харанхуйгаас гэрэлд авчрах тухай ярихад залуусын сэтгэл нь хөдөлж байсныг дурдсан юм (Давид А.Беднар, “Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эргэх болно,” *Лиакхона and Ensign*, 2011 оны 11-р сар, 24–27-г үз).

Ариун сүм болон гэр бүлийн түүхийн төв нэг дор орших нь маш чухал бөгөөд тэгснээр ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажил нь нэгэн агуу ажлын хоёр хэсэг гэдгийг гадаад байдлаараа харуулдаг. Бразилийн Кампинас ариун сүмийн ерөнхийлөгч Жорж А.Өүкс

ариун сүмд ирж буй залуус суралцаж эхэлж байгаа нь сайхан хэрэг гэжээ.

Тэр мөн “Тэднийг гэр бүлийн түүх болон индексжүүлэх ажилд оролцуулснаар тэдний ариун сүмийн аялалын гол зорилго нь нас барагсдын төлөө баптисм хүртэх болсон юм. Одоо индексжүүлэх ажил нь тэдний ажлын нэг хэсэг болоод байна” гэжээ.

Оршил

Залуусыг төвд ирэх үед Москао ах болон уг төвд сайн дураараа ажилладаг номлогчид тэдэнд дараах зарчмуудыг хэрэгжүүлэхэд нь тусалж, товч мэдээлэл өгдөг байна.

- Тэд Сион ууланд аврагчид болж байна (Обадиа 1:21-г үз).
- Тэд бошиглогчийн дуудлагыг дагаж байна (“Хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эргэх болно”-г үз).
- Тэд бүртгэлийн газар болон сүмийн он удаан жил мартагдсан хальс, тоосонд дарагдаж үлдсэн номнуудын харанхуйгаас хүмүүсийг аварч байна. Индексжүүлэх ажил нь тэдгээр нэрсийг гэрэлд авчирдаг бөгөөд гэр бүлүүд нь тэднийг эрж олоход амархан болдог.
- Энэ ажилд нэгдсэнээр тэд “үүрдийн сайн мэдээнд хамаарах бүх сэдвээс хамгийн алдартай нь болох нас барагсдын төлөөх баптисмд” (С ба Г 128:17) оролцдог.
- Тэд гэр бүлүүдийг адисалдаг, нас барагсдыг гэтэлгэх агуу ажилд цаг заваа зарцуулж байна.
- Бид бүгд Бурханы гэр бүлийн нэг хэсэг. Иймээс тэд өөрсдийн танихгүй хүмүүсийн нэрсийг индексжүүлэхийн сацуу гэр бүлдээ давхар тусалдаг.



Ариун сүмийн аяллын үеэр Бразилийн Кампинас ариун сүмийн дүүрэг дэх залуус баптисмын ёслолуудад оролцож, тэдгээрийн хооронд гарсан чөлөөт цагаараа FamilySearch индексжүүлэх ажилд оролцдог болжээ.

- Тэд хэрхэн индексжүүлэхийг ойлгосноор гэр бүлдээ болон тойрог, салбарынхаа бусад залууст индексжүүлэлтийг хийхэд туслах боломжтой болдог.

Москао ах болон номлогчид гэр бүлийн түүхийн төвийн компьютерийг ашиглан өсвөр насныханд хэрхэн индексжүүлэлтийг эхэлж, гэртээ очоод програмыг суулгаж, ашиглах талаар заадаг. Тэнд нэгэнт ойлгосон бол “агуу их эрч хүчтэйгээр ажиллаж эхэлдэг” гэж Москао ах хэллээ.

Гэр бүлийн түүхийн ажлыг хийх урам зориг

Энэхүү урам зоригийг бид тоон үзүүлэлтээс харж болно. 2012 оны эхний хоёр сард л гэр бүлийн түүхийн төвөөр зочлогчид 6,370 нэрийг индексжүүлсэн байна. Эдгээр нэрсийн 3,305-ыг 12-оос 18 насны залуучууд хийсэн байна. Индексжүүлэх ажлын цар хүрээ ихэссэнээр Кампинас гэр бүлийн түүхийн төв өглөө 8:00-аас орой 6:00 хүртэл сунгасан цагаар ажиллаж, заримдаа 10:00 хүртэл ажилладаг болсон байна.

Залуус хэдийгээр ариун сүмийг орхиж гэр рүүгээ явдаг байсан ч индексжүүлэх ажлыг орхидоггүй байлаа. Тэд гэртээ ирсэн үедээ Москао ахын хэлдгээр “өнөөдөр Сүмд байгаа 170,000 идэвхтэй индексжүүлэгч армийн” үүргээ биелүүлсээр байна. Маш олон залуус

индексжүүлэх ажлыг хийснээр Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь болон Хувийн хөгжил дэвшлийнхээ зорилгыг биелүүлж байна.

Сайн нөлөө үзүүлэх нь

Энэ жилийн эхээр Бразилийн Эспирито Санто, Вила Велагийн 16 настай Изабела ээж, эгчийнхээ хамт ариун сүм рүү аялсан бөгөөд аяллынх нь сүүлийн өдөр эмээ нь нас бараад нэг жил болж буй өдөр таарсан байна. Изабела эмээгийнхээ өмнөөс баптисм хүртэж, ээж нь эмээгийнх нь төлөө өөр бусад ёслолуудыг хийлгэжээ.

“Би тэр аяллын үеэр ямар нэгэн сайн зүйл хийх ёстойгоо мэдэрсэн. Би индексжүүлэлтийг сурахыг хүссэн бөгөөд Хосе Москао ахаас тусламж авсан.

Би эмээгийнхээ төлөө баптисм хүртэх үед Сүнс надад хүчтэйгээр нөлөөлсөн. Хөшигний цаана мянга мянган хүмүүс цөхрөлтгүй хүлээж байгаа бөгөөд тэдэнд миний тусламж хэрэгтэй гэдгийг би ухаарсан. Би үйлчлэхэд цаг заваа зориулж, тэдгээр хүмүүсийн төлөө их зүйлийг хийж чадах байснаа ойлгосон. Индексжүүлэлт нь хайрын үйлчлэл юм” хэмээн Изабела ярив. ■

Энэ явдлын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл news.lds.org вэб сайт руу орно уу.

ЭНЭТХЭГТ АНХНЫ ГАДАС БАЙГУУЛАГДЛАА

**Ахлагч Э.Жак болон Памела
Келлерстрасс эгч**

Энэтхэгийн Бангалор номлол

2012 оны 5-р сарын 27-нд Энэтхэгт Хидерабад Энэтхэг гадас байгуулагдах үед 1500 гаруй гишүүд Энэтхэгийн Хидерабад Новотел чуулганы төвд цугларсан бөгөөд тэдний нүднээс баяр баясгалан, талархал, сэтгэл догдлол илт

Энэтхэг, Непал, Шри Ланкагаас ирсэн 600 орчим ганц бие залуу насанд хүрэгчид Энэтхэгийн анхны гадасны нээлтийн чуулганд хүрэлцэн иржээ.

харагдаж байлаа. Чуулганыг Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын Ахлагч Даллин Х.Оакс хөтлөн явуулсан бөгөөд Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Ахлагч Доналд Л.Холлстром болон Азийн бүсийн ерөнхийлөгчөөр үйлчилж байгаа Далын Ахлагч Антони Д.Перкинс нар оролцсон юм. Мөн тэдний эхнэрүүд хүрэлцэн ирсэн байлаа.

Жон Гаттийг гадасны ерөнхийлөгчөөр, Сүреш Натаражаныг нэгдүгээр зөвлөхөөр мөн Ражаратнам Башийг хоёрдугаар зөвлөхөөр тус тус дэмжин баталлаа. Энэтхэгийн анхны патриархаар дүүргийн

ерөнхийлөгч байсан Прасад Рао Гадиг томиллоо.

Энэтхэгт урьд нь болж байгаагүй хамгийн том чуулганы цугларагсад хандан Энэтхэгийн Бангалор номлолын ерөнхийлөгч Ранди Д.Фанк ийн хэлжээ

Шинэхэн байгуулагдсан Энэтхэгийн Хидерабад Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл (зүүнээс баруун): Сүреш Натаражан, нэгдүгээр зөвлөх; Жон Гатти, гадасны ерөнхийлөгч; Ражаратнам Баши, хоёрдугаар зөвлөх.



“Өнөөдөр түүхэн дэх гайхамшигтай өдөр болж байна. Бид энэ өдрийг үргэлж санах болно. Бид Их Эзэний Төлөөлөгч энд байсныг үргэлж санах болно”.

Ахлагч Перкинс Азийн бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхний хайр, талархлыг Энэтхэгийн гишүүдэд илэрхийлэхийн сацуу “Бид энэхүү газар нутагт бий болох гайхамшигт ажлын эхлэлийг харж байна. Сүмийн өсөлт хөгжилт болон гадасны зохион байгуулалтыг сайн мэдээний мөнхийн зарчмууд болон санваарын загвар дээр үндэслэн байгуулдаг” гэжээ.

Ахлагч Холлстром шинэ гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн дуудлагыг гэрчлэх хоёрдахь гэрч байсан төдийгүй тэрээр шинэ гадасны удирдагчдыг сонгох ил тод үйл явцын талаар тайлбарласан юм. Далын гишүүний хувьд түүнийг ямар нэгэн шударга бус, заль мэх хэрэглэлгүйгээр энд ирэхээр томилсон билээ. Тэрээр Их Эзэний замаар ирсэн бөгөөд Түүний Сүнсэнд тулгуурлан илчлэлт хүлээн авсан юм. “Ерөнхийлөгч Гаттийг гадасны ерөнхийлөгч болгох нь Их Эзэний таалал байсан” хэмээн Ахлагч Холлстром хэлжээ.

Нөхөртэйгөө хамт хүрэлцэн ирсэн Кристен Оакс эгч хүүхдүүдээ зааснаар тэд “эхчүүд нь үүнийг мэдэж байсан гэдэгт” (see Alma 56:48) эргэлзээгүй итгэлийн талаар ярьсан юм.

Чуулганы хамгийн сүүлийн үг хэлэгч Ахлагч Оакс Энэтхэгийн ард түмэнд болон Сүмийн гишүүдэд “бидний итгэдэг

зарчмуудыг дагаж, ярих” боломжийг олгосон шашны эрх чөлөөтэй Энэтхэг улсад талархлаа илэрхийлсэн юм.

Ахлагч Оакс дуудагдсан тэдгээр удирдагчдийг Их Эзэн бэлтгэж, сонгосон гэдэг Сүнсний гэрчийг хүлээн авах талаар гэрчилсэн юм. Ахлагч Оакс мөн гадасны шинэ үүрэг хариуцлагуудын талаар ярьсан юм.

Шинэ Гэрээнд бошиглогч Исаиа Израилыг Израилын

Тэрээр “Патриархын адислал нь Израилын овог дахь таны удам угсааг харуулдаг. Мөн энэ нь хэрэв бид итгэлтэй байх юм бол бидэнд ирэх адислал, амлалтуудыг хэлдэг.

Энэтхэгийн Сүм өсч, хөгжихийн хэрээр Энэтхэгт ариун сүм барих сүнсэлэг илчлэлтийг бошиглогч хүлээн авах цаг ирэх болно. Зохион байгуулагдсан гадас бүр ариун сүмтэй болох боломжийг

Ахлагч Оакс болон Сүмийн бусад удирдагчид Энэтхэгийн Хидерабад зочлох зуураа Энэтхэг, Непал, Шри Ланкагаас ирсэн олон зуун гишүүдтэй уулзжээ.



хүүхдүүдийг орогнуулдаг майхантай адилтгасан байдаг. Тэр “Өнөөдрийн Сүм бол майхан юм. Бид бүгд майхныг гадсаар бөхлөх ёстой гэдгийг мэддэг. Өнөөдрийн хувьд Хидерабад бол Сионы гадас бөгөөд та нарыг урагш алхалж, аравны нэг болон номлогч нарыг тусламж болгон илгээнэ гэдэгт найдаж байна” гэжээ.

Гадас зохион байгуулагдснаар Хидерабад дахь гишүүд патриархын адислал хүлээн авах боломжтой боллоо. Ахлагч Оакс патриархын адислалд юу агуулагдсаныг тайлбарласан бөгөөд энэхүү адислалыг “хувийн судар” хэмээн дүрсэлжээ.

ихэсгэдэг. Хүмүүс нь итгэлтэй байж, үүрэг хариуцлагаа биелүүлснээр ариун сүм баригдах болно” хэмээн хэлсэн юм.

Ахлагч Оакс чуулганыг адислан “Энэтхэг хэмээх агуу оронд анхны гадас байгуулагдсан энэ мөчид би та бүхнийг өнөөдрийн сурсан хичээлээ үргэлж санахаар адисалж байна. Та нарыг мөн баптисм хүртэх үедээ хийсэн гэрээнүүдээ санаж явахаар адисалж байна. Та нар Түүний адислалуудад баясаж болохын тулд Бурханы зарлигуудыг сахих ой санамж, шийдвэр төгс байдлаар адисалж байна” хэмээн өндөрлөлөө. ■

Төлөөлөгч Филиппиний шинэ НБТ-г онцгойлон адисалжээ

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулган Ахлагч Рассел М.Нелсон 2012 оны 5-р сарын 20-нд Филиппиний шинэ Номлогчийг Бэлтгэх Төвийг онцгойлон адисалсан бөгөөд энэ нь Филиппин, Камбодж, Хонг Конг, Энэтхэг, Индонез, Монгол, Пакистан, Шри Ланка, Тайван, Тайландын 144 номлогчийг нэг дор хүлээн авах чадвартай ажээ. Эдгээр номлогчид өөрсдийн эх хэлээр бэлтгэгддэг.

Шинэ төвийн хоёр барилга нь хурлын танхим, орчуулгын өрөө, компьютерийн өрөө, угаалгын газар, дуу дүрс бичлэгийн тоног төхөөрөмжүүдтэй сургалтын өрөө, номлогч нарт зориулсан унтлагын өрөө, анги танхим, албан өрөөнүүдийг багтаасан байна.

Ахлагч Нелсон шинэ барилга байгууламжийг онцгойлон адислахдаа Есүс Христийн Цагаатгалд болон Их Эзэнд үйлчилж, түүнийг хайрладаг дэлхий даяарх Сүмийн гишүүд болон номлогчдод талархлаа илэрхийлсэн юм. Тэр Филиппин улсын “үүд хаалга” Их Эзэний үйлчлэгч бүрт нээлттэй байж, ард түмэн нь “зөв шударга байдалд, сүнслэг болон материаллаг хэрэгцээгээр өсч хөгжих эрх чөлөө бүхий хариуцлагатай байдлаар” адисалсан байна.

Филиппиний Шинэ Номлогчийг бэлтгэх төвд буй Филиппин, Камбодж, Хонг Конг, Энэтхэг, Индонез, Монгол, Пакистан, Шри Ланка, Тайван, Тайландаас ирсэн 144 номлогч өөрсдийн төрөлх хэлээр бэлтгэгдэж байна.



Бразилийн Манаус Ариун Сүм нь Дэлхий даяарх 138 дахь харин Бразилдаа 6 дахь ариун сүм юм

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф 2012 оны 6-р сарын 10-нд Дэлхий даяарх 138 дахь бөгөөд Бразилдаа 6 дахь ариун сүмийг онцгойлон адисалжээ.

Ерөнхийлөгч Угдорф Бразилд амьдарч буй нэг саяас илүү итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг гүн гүнзгий, хүчтэй урсгалтай Амазон мөрөнтэй адилтгасан байна.

Бараг 20 жилийн туршид томоохон гол мөрөн, ойн төгөлөөр алслагдсан Манаус хотын гишүүд Бразилийн Сао Паулогийн ариун сүм рүү очих гэж завь, автобусаар цуван хоёр талдаа 15 өдөр, харин Венесуэлийн Каракас ариун сүм рүү автобусаар 8 өдөр аялсаар иржээ.

1990 онд Бразилийн Манаус номлол нээлтээ хийх үед номлолын ерөнхийлөгчөөр Ахлагч Клаудио Р.М.Коста томилогдсон юм.

Ахлагч Коста “Эдгээр хүмүүс ариун сүмийг хайрладаг учраас Манаусын Ариун Сүм өдөр бүр маш завгүй байна гэдэгт би итгэдэг. Тэд хүүхдүүддээ ариун

сүмийг хайрлахыг заадаг. Ариун сүм тэдэнд маш их үнэ цэнэтэй” хэмээн хэлсэн юм.

Самоагийн Сүмийн гишүүд тусгаар тогтнолын 50 жилийн ойг анхны гадас байгуулагдсан 50 жилийн ойн хамт тэмдэглэж байна

2012 оны 6-р сарын 1-ний баасан гаригт 350 Самоа үндэстэн Хожмын Үеийн Гэгээнтнүүд бусад Самоачуудтай хамт Апиагийн гудамжаар баярын жагсаалд оролцжээ. 50 жилийн өмнө 1962 онд Самоа улс Шинэ Зеландаас тусгаар тогтножээ.

Байгууллага, сургууль, орон нутгийн сүмүүд болон олон улсын байгууллагууд мөн жагсаалд оролцжээ. Хожмын Үеийн Гэгээнтэн сурагчид хэдэн арван мянган үзэгчдийн анхаарлыг жагсаалын үзвэрээрээ татаж, тэднийг хөгжөөсөн байна.

Мөн тэрхүү долоо хоногт Хожмын Үеийн Гэгээнтэн Самаочуудын тэмдэглэсэн бас нэгэн тэмдэглэлт баяр бол 50 жилийн өмнө Апиад анхны гадас зохион байгуулагдсан үйл явдал ажээ.

6-р сарын 3-ны ням гарагт номхон далайн бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд болох Далын Ахлагч Жеймс Ж.Хамула болон Кевин В.Пийрсон нар Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд хандан үг хэлсэн ба улс даяарх ХҮГ цуглааны байруудаар цацагдан гарсан онцгой цуглаанд оролцжээ.

Самоа дахь Хожмын Үеийн Гэгээнтнүүд гэр бүл, орон нутаг, улс үндэстэндээ үргэлжлүүлэн үйлчилж, тэднийг хүчирхэгжүүлэх зорилго тавианд байна хэмээн Бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Хамула хэллээ. Тэрээр үргэлжлүүлэн “Сүм маш гайхалтай өсч хөгжиж байна. Бид Есүс Христийн үлгэр жишээ, сургаалыг дагахыг эрэлхийлснээр гэр бүл болон хувь хүнийхээ хувьд маш ихээр өсч хөгжиж байна” гэжээ. ■

Энэ нь миний гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг

Би 1967 оноос хойш *Лиахона*г хичээнгүйлэн судалж байгаа бөгөөд энэ нь надад сүнслэгээр өсөхөд тусалдаг. Энэ нь надад мэдлэгээ өсгөж, Их Эзэний Сүнсний шивнээг мэдэрч, сайн мэдээний талаар гэрчлэлээ өсгөхөд тусалдаг учраас би *Лиахона*г сар бүр тэсэн ядан хүлээдэг. Надад ялангуяа “Тэнгэрлэг Эцэг эхээ хүндэтгэн даган дуурайх нь” хэсэг маш их таалагдсан (*Лиахона*, 2012 оны 2-р сар, 80). Би ч бас өөрөө график дизайнер учраас энэхүү түүхийн эзэнг маш сайн ойлгож чадсан.

Фабио Фажардо, Колумб

Багш болон найз

Лиахона—надад зааж, намайг дэмжиж, миний амьдралыг засаж залруулдаг учраас би маш дуртай. Би өглөө эрт сайн зүйлсийг уншсан үедээ өдрийн туршид сайн байхыг хичээдэг. *Лиахона*г унших үед миний хайр, итгэл улам хүчирхэг болдог. Би мөн найзууддаа *Лиахона*г бэлэг болгож өгдөг. Сайн багш, сайн найз байж чаддаг болохоор сэтгүүлдээ маш их баярладаг шүү!

Анастасиа Напрасникова, Украин

Санал зөвлөмжөө liahona@

ldschurch.org хаягаар

илгээнэ үү. Ирүүлсэн материалуудыг хэмжээ, тодорхой байдлын хувьд хянан засварлаж болно.

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглах өгүүлэл, үйл ажиллагаануудыг бичсэн байгаа. Зарим жишээг доор өгөв:



“Алсын хараатай амьдрал биднийг ирээдүйд бэлтгэдэг” 12-р хуудас:

Өгүүлэлд дурдсан биднийг бие даасан болоход туслах 6 зөвлөмжийг унш. Эдгээр зөвлөмжүүдийг дагаж, бие даах чадвараа өсгөснөөр ямар асуудал болон гэнэтийн саад бэрхшээлээс зайлсхийж болох вэ? Аль зөвлөмжийг дагаснаар илүү их бие даасан болохыг залбиралтайгаар шийдэж, эдгээр зөвлөмжүүдээр бие даасан байдлаа дээшлүүлэх зорилго тавихыг гэр бүлийнхнээсээ хүс.

“Бэлгийн харилцааны ёс суртахуунгүй дэлхийд хэрхэн ариун явдалтай байх вэ?” 42-р хуудас:

Өгүүлэлийн асуултуудыг гэр бүлийнхэнтэйгээ ярилц. Ариун явдлын талаар таны гэрчлэлийг хүчирхэгжүүлсэн туршлага, зарчмуудыг хуваалц. Өгүүлээс сурсан зөвлөгөөг хэрэгжүүлэх арга замуудын талаар ярилц.

“Ухаалаг анд найз бай” 48-р

хуудас: Эхлээд сайн найзуудыг таньж мэдэх талаар Ахлагч Хейлсийн зөвлөсөн хувийн шалгалтыг унш. Сайн найз байхын чухал болох талаар ярилц. Сайн найз байх 3 арга замыг бодож олохыг гэр бүлийн гишүүд бүрээс хүс.

“Эрхэм хүндэт Амига” 60-р хуудас, “Амьдралынхаа нэгэн шинэ үеийг баяртай угтаарай” 61-р хуудас:

Эдгээр хүүхдийн хэсгийн хүүхдүүдийн талаар болон тэд хэрхэн Залуу Эмэгтэйчүүд, Эрэгтэйчүүдийн ангид орохоор бэлтгэж байгааг унш. Гэр бүлээрээ эдгээр хүүхдүүд бэлтгэхийн тулд юу хийсэн тухай ярилц. Гэр бүлийн гишүүдээс *Хувийн хөгжил дэвшил* эсвэл *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь товхимолыг* уншиж, тэдний ирээдүйд хийхийг хүсч байгаа зарим үйл ажиллагаануудыг олохыг хүс.

Нэг гэр бүлийн үдэш, хоёр хичээл

Нэг орой манай аав ээж болон ээжийн талын эмээ өвөө нар маань гэр бүлийн үдэшт оролцохоор манайхаар зочилсон юм. Гурван хүүхэд маань гурвуулаа гэр бүлийн үдэшт оролцох дуртай бөгөөд тэр орой манай долоон настай хүүгийн хичээл заах ээлж байсан юм. Бид жижигхэн самбар бэлдэж, Бүтээлтийн тухай зургийг гаргаж тавьсан бөгөөд түүний заасан зүйлийг сонсож суулаа. Хүү маань бэлэн болсон байсан бөгөөд маш их догдолж байсан юм.

Хичээлийн үеэр бид хүүгээ анхааралтай сонслоо. Түүнийг дууссаны дараа гурван настай Самуел бас хичээл заахыг хүсэв. Тэр зургуудыг авч, ширээн дээр тавилаа.

Тэр бяцхан дуу хоолойгоороо бараг л үг нь ойлгогдохгүй шахам гэр бүлийн үдшийн хичээлээ заалаа. Тэр хэдийгээр хичээл заах гэж бэлтгээгүй ч анхааралтай сонссон байв. Тэр бидэнд дэлхий хэрхэн бүтээгдсэнийг тайлбарлаж, биднийг хайрладаг Есүс Христийн хайрын талаар хэлэв.

Тэр яг л ах шигээ маш амархан хичээл зааж дуусгасанд бид гайхширч хоцорсон юм. Манай ээж, аав болон өвөө, эмээ бүр гайхшрах, баярлах нь зэрэгцэж суулаа. Бид тэдгээр бяцхан хүүхдүүдийн сайн мэдээг хайрлах хайрыг болон тэднийг хайрлах Есүс Христийн хайрыг харсан юм.

Лизбет Санчез Фажардо, Мексик

САЙН ҮЙЛС ҮРГЭЛЖИЛСЭЭР БАЙХ БОЛНО

Кейтлин А.Раш

Бусад өдрөөс юугаараа ч ялгарах юмгүй, ердийн нэг баасан гараг байлаа. Би гэртээ хамгийн дотны найз нарынхаа хамт кино үзэж, үе үе шивнэж ярилцсаныхаа дараа чанга инээлдэн сууж байв. Жинхэнэ баяр баясгалангийн мэдрэмж өрөөгөөр дүүрч, хөгжилтэй түүх, сонин санаануудыг сонсоод би инээдээ барьж чадсангүй. Гэрт маань байсан найз нарынхаа заримтай нь би танилцаад дөнгөж ганц сар л болж байсан бөгөөд заримтай нь бүр амьдралынхаа 25 жилийн турш найзууд байлаа.

Би олон жил найзалсан найзуудтайгаа хэдэн жилийн өмнөх коллежийн найз нарынхаа тухай дурсамжаа хуваалцав. Ярианыхаа явцад би эдгээр найз нараа хэчнээн их санадгаа, бид ямар их хөгжилтэй бас үй зайгүй дотны андууд байснаа бодлоо. Бид коллежоо төгссөний дараа дэлхий даяар тарж, урьд нь хэзээ ч төсөөлөн бодож байгаагүй нөхцөлд ажиллаж, амьдарч байна. Би түр зуур уйтгарлан санаа алдах тэрхэн агшинд өрөөнд намайг хүрээлэн инээмсэглэсэн найзуудынхаа нүүрийг хяламхийн харахад *Сайн үйлс үргэлжилсээр байх болно* гэсэн бодол толгойд зурсхийн орж ирлээ.

Тэрхүү энгийн бодол надад гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн бөгөөд өөрчлөх шаардлагатай хэцүү үе тулгарахад сайн үйлс үргэлжилсээр байх эсэхэд би эргэлздэг байлаа. Би одоо баяр баяслаар дүүрэн, ухамсартайгаар, шийдвэр төгс амьдарч байгаа ч өнгөрсөн үеэ санагалзан байлаа. Надад нэг сайн зүйл байгаа үед би түүнийг өөртөө үргэлж байлгаж, алдахгүйг хүсдэг гэдгээ мэднэ. Энэхүү ажилгүй, хөгжил хөөртэй баасан гараг өгүүлшгүй сайхан хормуудын нэг байлаа. Би юмс үнэхээр сайхныг мэдэрсэн



Одоо үедээ харамсдаг хүн өнгөрсөн үе рүү түргэн эргэж ордог бол харин би өнөө үеэсээ баяслыг олж, ирээдүйгээ харж явдаг хүмүүст талархалтай байдаг.

үедээ юм бүхэн нүд ирмэхийн зуур болж өнгөрдөг бөгөөд энэ нь улмаар цаг хугацаа, ашигтай нөхцөл байдлыг алдахад хүргэдэг юм байна гэж боддог болсон.

Харин баасан гарагийн тэр оройн хувьд харамсах зүйлгүй байлаа. Би хайрладаг хүмүүсээрээ хүрээлүүлэн тайван сууж байхдаа зарим сайн зүйлс жам ёсоороо төгсгөл болж, ирээдүйд олон хэцүү зүйл тохиолдох нь эргэлзээгүй боловч, сайн үйлс үргэлжилсээр байх болно гэдгийг мэдэж байлаа. Хэрэв би тэднийг үргээчихгүй л бол сайн найзууд минь үргэлж надтай хамт байх болно. Миний хайрладаг хүмүүс хувь заяаны эрхээр салаад явна. Тэр үед бий болсон хоосон зайг гайхалтай сайхан шинэ хүмүүс хийгээд миний хэзээ ч төсөөлж байгаагүй шинэ туршлага нөхнө.

Зарим үед ийн салж явах нь хэцүү байдаг ч ингэхээс өөр аргагүй. Салаа замын эрхээр салж явах нь найз нараа мартаж, сайхан дурсамж бүдгэрэн арилна гэсэн үг биш. Харин ч энэ нь улам илүү аз жаргал, туршлагад бидний зүрх сэтгэлийг нээж өгнө гэсэн үг.

Тэр баасан гарагаас хойш хэдхэн долоо хоногийн дараа манай салбарын залуу насанд хүрэгчдийн ерөнхийлөгчийн зөвлөл чөлөөлөгдлөө. Бидний өсгөн өндийлгөсөн эдгээр эрчүүд болон тэдний эхнэрүүдэд түшиглэвэл манай салбарт ямар өөрчлөлт гарч болохыг тааварлах нь хэцүү болохыг энэ жижигхэн салбарын хэн ч гэсэн хэлж чадах байх. Харин би нүдээ анин, тэр нэгэн баасан гарагт миний сэтгэлийг ихэд хөдөлгөсөн *Сайн үйлс үргэлжилсээр байх болно гэсэн үгсийг дотроо давтан хэлсээр байлаа*. Би тайтгарч, өөрчлөлтөнд бэлэн байв.

Өөрчлөлт бол Их Эзэний зам. Тэрбээр биднийг аз жаргалтай байж, өсч хөгжин, амьдралаа урагш ахиулж чадсандаа сэтгэл хангалуун байхыг хүсдэг. Амьдрал бол аялал юм. Бид өнөө үеэс баяслыг олж, зайлшгүй тулгарах сорилт бэрхшээлүүдэд бэлтгэлтэй байж, урагш тэмүүлэн, урам зоригоор дүүрэн байвал бидний зүрх сэтгэл аяллын замд хуримтлуулах олон туршлага хийгээд эргэлзээгүй тохиолдох сайн үйлсэд нээлттэй байх болно. ■

Энэ жил *Лиахонагийн* олон дугаарт Мормоны Ном дахь судрын баатруудыг нийтлэх болно. Судрын баатруудын дүрсийг бат бөх бөгөөд ашиглахад хялбар болгохын тулд хайчилж аван, хатуу цаас, жижигхэн цаасан уут юм уу гар хийцийн савхан дээр наа. Судрын баатруудыг дугтуй эсвэл уутанд хийж, тэдний тухай өгүүлдэг судрын түүх хаана байдгийг заасан шошго нааж хадгал.



Чулуунууд



Есүс Христ



Жаредын ах



Завинууд

Жаредчууд амлагдсан нутаг руу удирдагдсан нь

Ифер 1-3, 6



Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга
“аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал,
наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл,
ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах
зарчмуудын дор оршин амьдарна” гэдгийг заасан билээ
 (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”). Эдгээр
зарчмуудыг амьдралдаа болон гэр бүлдээ хэрэгжүүлэх
санаануудыг 4, 16, 20, 22-р хуудсаас үзнэ үү.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ